



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР, ЛХАГВА ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

---

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, Лхагва гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-20
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	21-113

---

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/	21-40
2.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	40-47
3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	47-62
4.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлэг/	62-69 11-112
5.Байнгын хорооны даргыг сонгох тухай	71-73 111
6.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	73-84
7.Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох	84-85
8.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан/	85-87
9.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	87-91
10.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	91-95
11.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 09 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	95-110

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаверын ээлжит  
чуулганы 06 дугаар сарын 25-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 54.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 17 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Х.Баттулга, Т.Доржханд, Х.Жангабыл, Г.Лувсанжамц, П.Мөнхтулга, Б.Чойжилсүрэн;

Чөлөөтэй: Н.Алтаншагай, Н.Номтойбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, С.Эрдэнэбат;

Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Л.Гантөмөр, Х.Ганхуяг, Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, Б.Түвшин;

Тасалсан: Ж.Алдаржавхлан, Ч.Лодойсамбуу, Б.Пунсалмаа, Р.Эрдэнэбүрэн;

Хоцорсон: О.Амгаланбаатар-03 минут, Б.Батбаатар-21 минут, Д.Батлут-02 минут, Ж.Батсуурь-04 минут, Д.Ганбат-04 минут, С.Зулпхар-04 минут, С.Лүндэг-47 минут, О.Номинчимэг-02 минут, О.Саранучулуун-11 минут, Р.Сэддорж-14 минут, Ц.Туваан-01 минут, Б.Тулга-41 минут, А.Ундраа-32 минут, Н.Учрал-04 минут.

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороонд хуваарилсныг мэдээлэх**

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан нарын 40 гишүүн 2025.06.23-ны өдөр мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025.06.24-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг мэдээлэв./14:19/

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн

мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэгтэй холбогдуулан Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдэв./14:20/

**Нэг.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

*Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлэг асуулт, хариултаар үргэлжлэв.*

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ө.Шижир, Б.Бат-Эрдэнэ, М.Мандхай, Д.Энхтүвшин, Да.Цогтбаатар, М.Энхцэцэг нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Сангийн сайд Б.Жавхлан нар хариулж, тайлбар хийв.

*Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Нэг.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

**Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “-хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал;” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 77

Бүгд: 98  
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж Төслийн 1 дүгээр зүйлийн “хяналт тавих асуудал;” гэсний дараа “бүсчилсэн хөгжлийн үндэсний хороо;” гэж нэмэх гэсэн 2 дахь саналаа татаж авсан тул санал хураалт явуулаагүй болно.

#### **Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:**

**Д.Амарбаясгалан:** 3.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “-хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал;” гэснийг “-хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал;” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 48  
Бүгд: 98  
51.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Хоёр.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

#### **Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:**

**Д.Амарбаясгалан:** 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.4.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдээс хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, захирамж, хурлын тэмдэглэл /цаашид “хууль тогтоомж, бодлого, шийдвэр” гэх/-ийг хэрэгжүүлэхэд хяналт тавих ажиллагаанд энэ хууль үйлчилнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21  
Татгалзсан: 77  
Бүгд: 98  
21.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргаас” гэснийг “Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргаас” гэж, 11 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргын” гэснийг “Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, 19

дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны даргад” гэснийг “Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад” гэж, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн “Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Монгол Улсын сайд, Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны дарга” гэснийг “Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29  
Татгалзсан: 69  
Бүгд: 98  
29.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.*

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн нэгтгэсэн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Б.Энхбаяр нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27  
Татгалзсан: 72  
Бүгд: 99  
27.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Д.Амарбаясгалан:** 2.Байнгын хорооны саналаар Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 18

Татгалзсан: 81

Бүгд: 99

18.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

3.Байнгын хорооны саналаар Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20

Татгалзсан: 79

Бүгд: 99

20.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, Б.Жаргалан, М.Мандхай, О.Номинчимэг, Б.Батбаатар нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Зулпхар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 92

Бүгд: 99

7.1 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.*

**Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороонд хуваарилсныг мэдээлэх**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсныг мэдээлэв./16:34/

**Дөрөв.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газраас 2025.06.25-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу санал хураалт явуулав.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027

оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 46  
Татгалзсан: 53  
Бүгд: 99  
48.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаярын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50  
Татгалзсан: 49  
Бүгд: 99  
50.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 49  
Татгалзсан: 49  
Бүгд: 98  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүйд тооцож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54  
Татгалзсан: 44  
Бүгд: 98  
55.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Засгийн газраас 2025.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 55  
Татгалзсан: 43  
Бүгд: 98  
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүлэв./16:46/

*Уг асуудлыг 16 цаг 46 минутад хэлэлцэж дуусав.*

***Тав.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар 2025.06.20-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Д.Мөнх-Эрдэнэ, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Д.Саруул, референт Б.Төрбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Б.Нандингэрэл, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяа, О.Номинчимэг, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./17:10/*

***Зургаа.Байнгын хорооны даргыг сонгох тухай***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 38  
Бүгд: 97  
60.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Байнгын хорооны даргыг сонгох тухай” тогтоол баталсанд тооцов.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан “Байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./17:16/

*Уг асуудлыг 17 цаг 17 минутад хэлэлцэж дуусав.*

**Долоо.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Болормаа танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар, Г.Очирбат, Д.Энхтуяа нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооноос Гаалийн албан татвараас чөлөөлөх

тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 57  
Татгалзсан: 41  
Бүгд: 98  
58.2 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

*Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 71  
Татгалзсан: 27  
Бүгд: 98  
72.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

*Уг асуудлыг 17 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

*Тав дахь асуудал буюу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т заасны дагуу эцэслэн батлах санал хураалт явуулав.*

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
Татгалзсан: 29  
Бүгд: 98  
70.7 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Д.Амарбаясгалан:** 2.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 70  
Татгалзсан: 28  
Бүгд: 98  
71.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

3.Байнгын хорооны саналаар Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59  
Татгалзсан: 39  
Бүгд: 98  
60.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 34  
Бүгд: 98  
65.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 61  
Татгалзсан: 37  
Бүгд: 98  
62.2 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 34  
Бүгд: 98  
65.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 33  
Бүгд: 98  
66.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

4.Байнгын хорооны саналаар Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 66  
Татгалзсан: 32  
Бүгд: 98

67.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

5.Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг буруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63  
Татгалзсан: 35  
Бүгд: 98

64.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүн П.Батчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64  
Татгалзсан: 34  
Бүгд: 98

65.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** 5.Байнгын хорооны саналаар Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг буруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 68  
Татгалзсан: 30  
Бүгд: 98

69.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

6.Байнгын хорооны саналаар Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67  
Татгалзсан: 31  
Бүгд: 98

68.4 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

7.Байнгын хорооны саналаар Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 65  
Татгалзсан: 33  
Бүгд: 98

66.3 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

8.Байнгын хорооны саналаар “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 69  
Татгалзсан: 29  
Бүгд: 98

70.4 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 18 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.*

### ***Найм.Батлагдсан хууль, тогтоолын эцсийн найруулга сонсох***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа нар байлцав.

*Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:*

1.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:03/

2.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:03/

### ***Дагалдан гарсан:***

2.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:04/

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:04/

4.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн

эцсийн найруулгатай танилцлаа./18:04/

5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг буруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:05/

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:05/

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./18:05/

8.““Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./18:06/

*Уг асуудлыг 18 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.*

***Ес.“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль баталсантай холбогдуулан боловсруулсан/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Л.Батмөнх, Байнгын хороодын ажлын албаны Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 45

Бүгд: 99

54.5 хувийн саналаар Монгол Улсын Их Хурлын тогтоол батлагдлаа.

“Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./ 18:12/

*Уг асуудлыг 18 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

**Арав.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн 2025.06.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Б.Мажигсүрэн, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, О.Номинчимэг нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүдээс үг хэлээгүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:28/*

**Арваннэг.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх,

Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.12-т “Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно” гэж заасны дагуу санал хураалтыг хойшлуулав./18:36/*

**Арваннэг. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025.06.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хороодын ажлын албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Д.Рэгдэл, Л.Соронзонболд, М.Бадамсүрэн нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа хариулж, тайлбар хийв.

*Улсын Их Хурлын дэд дарга Б.Пүрэвдорж 19 цаг 09 минутаас 19 цаг 18 минутад хуралдааныг даргалав.*

Улсын Их Хурлын гишүүн М.Бадамсүрэн, Ж.Батжаргал нар үг хэлэв.

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 54

Татгалзсан: 46

Бүгд: 100

54.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Д.Амарбаясгалан:** 1.Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 58

Татгалзсан: 42

Бүгд: 100

58.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв./19:23/

*Уг асуудлыг 19 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.*

*Арваннэг дэх асуудал буюу Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62

Татгалзсан: 38

Бүгд: 100

62.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв./19:24/

*Арав дахь асуудал буюу Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 11 гишүүн өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулав.*

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 67

Татгалзсан: 33

Бүгд: 100

67.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**Хамт өргөн мэдүүлсэн:**

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 64

Татгалзсан: 36

Бүгд: 100

64.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны саналаар Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 66

Татгалзсан: 34

Бүгд: 100

66.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв./19:24/

*Уг асуудлыг 19 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.*

*Чуулганы нэгдсэн хуралдаанаар 12 асуудал хэлэлцэв.*

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 5 цаг 10 минут үргэлжилж, 126 гишүүнээс 104 гишүүн хүрэлцэн ирж, 82.5 хувийн ирцтэйгээр 19 цаг 27 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ

ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр,  
Лхагва гараг Төрийн ордон “Их хуралдай” танхим 14 цаг 17 минут.

### **НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

---

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж байна 84 гишүүн бүртгэгдэж ирц 66.7 хувьтай болсон байна.

2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна,

Хоёрдугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин нарын 3 гишүүн санаачилсан хууль байгаа,

Гуравдугаарт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна. Одонгийн Цогтгэрэл нарын 26 гишүүн санаачилсан хуулийн төсөл байна,

Дөрөвдүгээрт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 11 гишүүн өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа,

Тавдугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн санаачилсан хуулийн төсөл байна,

Зургаадугаарт, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна, Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа нарын 9 гишүүн санаачлан өргөн барьсан хууль байгаа,

Долоодугаарт, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Засгийн газраас 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн анхны хэлэлцүүлэг явагдана,

Наймдугаарт, Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ,

Есдүгээрт, ТББХ-ны хуралдаанаар Эцсийн хэлэлцүүлэг явуулсны дараа Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна,

Аравдугаарт, Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ,

Арван нэгдүгээрт баталсан хууль тогтоолын эцсийн найруулгыг сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад байнгын хороог тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1. Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Батбаярын Жаргалан нарын 40 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр мэдүүлснийг ТББХ-нд,

2. Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Доржсүрэнгийн Үүрийнтуяа нарын 6 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалдаа оръё. [Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулна.](#)

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг ажлын нэг өдрийн завсарлага авсан. Завсарлагын хугацаа дууссан байна аа. Завсарлагын хугацаа дууссантай холбогдуулаад АН-ын бүлгийг төлөөлж үг хэлэх үү? алга байна. Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг танилцуулсан. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дарааллын дагуу асуулт асууна аа. Нэр өгье. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

**Ц.Идэрбат:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Ер нь төрийн аливаа шийдвэр нэг ийм гэнэтийн гэнэтийн юм баймааргүй байна гэж ингэж хэлэх гэж байгаа юм. Тэгээд гэнэтийн шийдвэрүүд эргээд ард иргэдэд ямар их хүндрэл учруулдгийн тод жишээ бол энэ тэтгэврийн зээлийн асуудал. Ямар ч байсан тэгээд нэг жил нь 2 жил боллоо, тэр 470-ыг авч үлдэх нь 50, 50 хувь боллоо. Гэхдээ л ахмадууд өшөө

шаардлагууд тавьсаар л байна. Тэгэхээр би энэнтэй холбогдуулаад өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад одоо энэ цомхотголын асуудлууд яригдаад байгаа. Үнэхээр цомхотгол ингээд гэнэт хийнэ гэдэг бол тэр чинь юуны ард хүн байгаа. Орон нутгуудад яг албан бичиг бол очоогүй байгууллагуудаас нь нэг тийм мессеж юмнууд очоод байгаа юм байна лээ. Манай байгууллагаас тэдэн хүн хас нэрийг нь явуул. Тэгээд ямар азгүй нь тэр нэрэнд багтаад явж амьдрал ахуй нь хэцүү байдалд орох юм. Тэгэхээр би цомхотголыг эхнээс нь ингэж хиймээргүй санагдаад байна боломгүй байна. Ер нь орон нутагт тэр сумын Тамгын газар, ЗДТГ, аймгийн тамгын газар, сургууль цэцэрлэг бүгд хатуу орон тоотой шүү дээ. Толгой мэдээж хүн нэмсэн тийм дарга нэг ч байхгүй. Харин хаана замбараагүй байдал үүсдэг вэ гэвэл яамдынхан ажилчдынхаа тоог мэдэхээ больтлоо томорчихсон, агентлагууд нь томорчихсон тэгээд эндээсээ эхлээсэй гэж би бодож байгаа юм. Тэгээд л ингээд л нэг хатуу тоо тавиад л орон нутагт 9 хүн хасаарай гээд бүүр нэрийг нь явуул гээд яаруулаад байна гэж байгаа байхгүй юу. Тэгээд иймэрхүү цомхотгол ийм гэнэтийн юм битгий байгаасай гэж.

Дараа нь энэ төрийн албан хаагчдын 36 сарын тэтгэмжийн асуудал энэ төсвийн хэмнэлтэд битгий оруулчхаасай гэж ингэж хүсэж байгаа юм. Үүнийг чинь авах гэж сүүлийн 10 жил гүрийгээд ажиллаж байгаа төрийн албан хаагч нар олон байдаг юм шүү. Тэгэхдээ аливаа юмыг засах гэж байгаа бол хэзээнээс эхэлж засах юм яаж уян хатан явах юм гэдгээ тодорхой болгож байхгүй бол нэг л өдөр тас буугаад л ингээд л хорьчихож би болохгүй гэж ингэж хэлэх гэж байгаа юм.

Хоёр асуулт байгаа юм.

Нэгдүгээрт бол энэ Баялгийн сангийн асуудлыг энэ Засгийн газрын бүтэцэд яг хэн хариуцах вэ? Яг хэн хариуцах вэ? Би чуулганы хуралдаан дээр Баялгийн сангийн асуудлыг хэн нэгэн БЭТ гэдэг хүнээс биш яг Засгийн газрын тодорхой сайд болж өгвөл Ерөнхий сайд нь ядаж нэг улиралдаа танилцуулчхаж байгаач гэдэг хүсэлт тавьсан. Энэ бол аль нэгэн салбарын юм биш. Энэ Монголын нийт ард түмний эрх ашиг энд яваа байхгүй юу. Ер нь өнөөдрийн энэ цалин, тэтгэвэр тэтгэмж, энэ татварын хөнгөлөлт, нийгмийн даатгал энэ бүх зүйлүүд мэдээж жоохон нэмэр болох л байх. Яг ард түмний хүсээд байгаа өөрчлөлтийг бол авчрахгүй гэдэг нь та бидэнд ойлгомжтой.

**Д.Амарбаясгалан:** Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

**С.Бямбацогт:** Идэрбат гишүүний асуултад хариулъя аа. Тэгээд Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль орж ирж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд томилогдох үед мөн сайд нарыг танилцуулах үед манай Улсын Их Хурлын гишүүд энэ дотроос Улсын Их Хурал дахь АН-ын бүлэг бас дараад нь Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний асуудал оруулж ирэхдээ цомхон, чадварлаг, бүтээмжтэй байх ёстой шүү гэсэн шаардлага тавьж байсан. Мөн нийгмийн ард иргэдийн зүгээс ч гэсэн төр данхайгаад байна дарга нарын тоо хэт олшроод байна гэсэн шаардлага тавьж байсан. Энэ асуудал дээр анхаарал тавьж Монгол Улсын Ерөнхий сайд энэ 3 үндэсний хороо, үндэсний хороо эрхэлсэн сайдын асуудлыг энэ бүрэлдэхүүн дотроос цомхотгож урьд нь 19 сайдтай ажилладаг байсан, одоо 16 сайдтай ажиллахаар бүрэлдэхүүнийг оруулж ирж байгаа. Мөн үүнийг дагуулаад Үндэсний хороодыг цөөлөх, одоо шаардлагатай шаардлагагүй олон хэрэгтэй хэрэггүй үндэсний хороод байна гэдэг асуудал яригддаг байсан. Үүнийг цэгцлэх зорилгоор

58 Үндэсний хороог 2 дахин буулгах ийм асуудал орж ирж байгаа. Мөн яамдын газар хэлтсийн тоог 270 гаруй газар хэлтэс 16 яаманд ажилладаг байсан бол үүнийг 180 орчим болгож, 80 орчим даргын тоог цөөлж байгаа. Нэг иймэрхүү байдлаар. Дарга цөөлж байна гэдэг маань үндсэндээ бол тэр хүн ажлаас халагдаж байна гэсэн үг биш. Ахлах мэргэжилтэн шинжээч бусад байдлаар шилжин ажиллах бололцоотой. Ийм байдлаар зохицуулалтууд хийж байгаа. Яг орон тооноос нь халаад гэнэт халагдсаны тэтгэмж өгөөд явах асуудал харьцангуй бас Засгийн газраас уян хатан байхаар ийм байдлаар төсвийн тодотгол дээр яригдана гэдгийг та бүхэнд хэлье ээ.

Үндэсний баялгийн сангийн асуудал бол Монгол Улсын Засгийн газар Засгийн газрыг төлөөлж ЗГХЭГ хувьцаа эзэмшиж ажилладаг.

Яг энүүгээр үндэсний баялгийг бол энэ бодлогыг хэрэгжүүлэх ажил ЗГХЭГ дээр явн. Монгол Улсын төрийн бодлогын бичиг баримтуудыг боловсруулах салбар дундын бодлогын уялдааг хангах асуудал Эдийн засгийн хөгжлийн яам Тэргүүн шадар сайд хариуцаж байгаа. Энэ хүрээнд бол Үндэсний баялгийн сангийн бодлого тодорхойлох бусад салбарын бодлоготой уялдуулах энэ ажлыг Эдийн засаг, хөгжлийн сайд эрхэлж ажиллана аа. Хэрэгжүүлэлтийг бол ЗГХЭГ дээр хийж ажиллах ийм зохион байгуулалт бүрэлдэхүүний тухай хуульд орж байгаа гэдгийг хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Цагаанхүүгийн Идэрбат гишүүн тодруулж асууя.

**Ц.Идэрбат:** Тийм Засгийн газрын баримталж байгаа бодлого юмыг бол маш сайн ойлгож байгаа. Төсвийн зарлагаа багасгая гэдэг энэ том зорилт явж байгаа. Саяын яам, Тамгын газраасаа эхэлье гэдгийг ч дэмжиж байгаа. Гэхдээ яг цаагуур чинь бол надаа Дорнодоос ч мессеж ирээд байна, Хэнтийгээс ч мессеж ирээд байна. Одоо танай байгууллагаас 9 хүн хална гэсэн хурдан нэрээ явуул. Тэгэхээр нөгөө дунд шатад гэх үү дээ иймэрхүү завхралууд гарах вий гэсэн ийм зүйлийг би хэлж байгаа юм. Тэгээд энд бол ингээд дээрээсээ эхэлнэ гэж байна шүү дээ. Зөв зарчим. Ялангуяа энэ яамдууд тэдэн хүнтэй байж байгаад тэдэн хүнтэй болчихсон байна гээд айхтар л тоо дуулдах юм байна шүү дээ. Орон нутагт бол тэгж дураараа хэдэн 10-аар нь нэмдэг эд нар тийм эрх мэдэл юу ч байхгүй шүү дээ. Юу ч байхгүй. ТАЗ-ийнхөн чинь орон нутагт хатуу шүү дээ чанга шүү дээ. Тийм тэр энэ дээр анхаараад.

**Д.Амарбаясгалан:** Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

**Д.Амарбаясгалан:** Тийм одоо байгаа орон тооны дутуу гүйцээгдээгүй орон тоо нь үндсэндээ бол улсын хэмжээнд дунджаар 6 мянган орчим албан хаагч гүйцээгдээгүй юм байна томилогдоогүй байна. Энийг нь царцаая гэж байгаа.

Улсын Их Хурал өнгөрсөн сард Монгол Улсын 2026 жилийн төлөвлөгөө баталсан. Гантөмөр сайд Эдийн засгийн хөгжлийн сайд байхдаа оруулж ирж батлуулсан. Энэ дээр бол төрийн албан хаагчдын тоог 9 хувиар цөөлнө өө 2026 онд гэж бид хууль баталчихсан. Тэр хуулийг хэрэгжүүлэх процессыг одоогоос ингээд тавигдаагүй орон тоонуудыг цомхотгох царцаах байдлаар ингэж үе шаттай бусдаар шууд ажлаас нь хүнийг халаад гудамд гаргахгүй байх ийм зарчмаар явъя аль болох төрийн албан хаагчдаа ингээд зөөлөн газардуулах ийм бодлого баримталъя гэж байгаа. Ер нь яамд газрын тоо ярих юм бол Эдийн засаг, хөгжлийн 28 газартай

байсан бол даргатай байсан бол 14 даргатай болно. Сангийн яам 26 даргатай байсан бол 14 даргатай болох ийм байдлаар үндсэндээ бол ингээд дээрээсээ эхлээд дарга нарын тоог цөөлөх ажлыг.

**Д.Амарбаясгалан:** Ухнаагийн Отгонбаяр гишүүн асуулт асууя. Алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна алга байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

**Ө.Шижир:** Өдрийн мэнд. Ер нь энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчилж тодорхой бүтэц багасгаж байгаатай холбоотой бид нар зардлуудаа заавал эргэж харах ёстой юм аа. Тэгээд цаасан дээр бүтэц нь байхгүй болчихдог, зардал нь хэвээрээ байгаад байж болохгүй. Одоо энэ улс орны эдийн засаг өөрөө ямар хүндэрч байгаа билээ гэдэг асуудал. Тэгээд би ер нь бол Байнгын хороон дээр ч хэлсэн хүнд нь зориулж бүтэц хийдэг болчихсон байна гээд. Одоо бас нэг намаас 2 Шадар сайдтай. Хүнд нь зориулаад нэг Шадар сайд даваад үлдчихсэн. Уг нь энэ Номтойбаяр сайдад өгч байсан юм шиг байна лээ. Тэр Номтойбаяр нь татгалзаад тэр Шадар сайд нь үлдчихсэн. Тэгээд ингээд хүнд нь зориулж ингээд албан тушаалуудыг бий болгоод байдаг байж болохгүй ээ. Үүнтэй холбоотой бас нэг хэдэн юм байгаа юм аа. Ер нь сүүлийн 2 жил 2024 онд өөрөө сонгуулийн жил байсан. Энийгээ дагаад улсын төсөв бол тэлдэг. Сүүлийн 2 жил одоо энэ Сангийн яамнаас гаргасан бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ гэдэг ийм төлбөр хураамж дотор сүүлийн 2 жил гарангийн хугацаанд мэдээлэл сурталчилгааны ажил гэдэг дээр 31 тэрбум төгрөг зарцуулсан байгаа юм.

Жишээ нь Сангийн сайд 2024 онд 146 сая төгрөг, 2023 он буюу сонгуулийн өмнөх жил 231 тэрбум төгрөг, Монгол Улсын Шадар сайд 2024 онд 1.6 тэрбум төгрөг, 2023 онд буюу сонгуулийн өмнөх жил 268 тэрбум төгрөг. Гэтэл АТГ, СЕХ 2004 онд сонгуультай жил мөртөө СЕХ 28 сая төгрөгийн мэдээлэл сурталчилгааны зардал гаргасан байгаа юм. Гэтэл Шадар сайд дээр 1.6 тэрбум төгрөг, ЗГХЭГ-ын даргын 2.4 тэрбум төгрөг, Сангийн сайд дээр 146 тэрбум төгрөг ингээд нэгтгэсэн дүнгээр 31 тэрбум төгрөгөөр сүүлийн 2 жил гарангийн хугацаанд мэдээлэл сурталчилгааны ажил Засгийн газар хийлгэжээ. Энэ юу вэ бол юу вэ гэхээр Төрийн мөнгөөр татвар төлөгчдийн мөнгөөр төсвийн мөнгөөр тухайн үед албан тушаалтай байсан сайд нар сонгуульд зориулж өөрийнх нь сурталчилгааг хийсэн гэсэн үг.

2023, 2024 онуудад ийм өндөр тоонууд байгаа. Нийлбэр дүнгээрээ 31 тэрбум төгрөг шүү. Тэгээд хэдий энэ Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн цомхотгуулж бууж байгаа ч гэсэн бид нар буцаад ийм урсгал зардлуудыг сайн ингэж хянаж байж ийм зардлууд дээр одоо гаргахгүй бол болихгүй. Болихгүй бол бид нар энэ их зардлыг чинь дийлэхгүй ээ. Дахиад хурал зөвлөгөөн дээр дахиад 20 орчим тэрбум төгрөг. Одоо энэ төсвийн мөнгөөр өөрсдийгөө сурталчилдаг, төсвийн мөнгөөр хурал зөвлөгөөн хийдэг энэ байдлаа одоо Занданшатар Ерөнхий сайдын үед таслан зогсоохыг би хүсэж байна аа. Ер нь дахиад аливаа бүтцийг хийхдээ үйл ажиллагаа, хөтөлбөр, ажил, алсын хараа, зорилгодоо тохируулж бүтцээ хийдэг болохоос биш хүнд зориулж бүтэц хийж болохгүй ээ. Дахиад бид нар нэг Шадар сайд аваад үлдчихсэн байгаа шүү. Нэг намаас 2.2 Шадар сайдад.

Тэгэхээр ийм юмнуудаа бас бид нар эргээд хардаг энэ юмнуудаа үнэлэлт дүгнэлт хийдэг юм болохгүй бол үнэхээр болохгүй нь гэдгийг хэлэх гэсэн юм аа.

Тэгээд энэ нэгэнт Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн тодорхой хэмжээгээр бууж ирж байгаа энэ олон үндэсний давхардсан чиг үүрэгтэй үндсэн хороодуудаа бүгдийг нь татан буулгаарай Бямбацогт сайд аа. Төрийн албан хаагчдаас 3 дахин өндөр цалинтай болчихсон байгаа шүү дээ энэ үндсэн хорооны ажилчид чинь.

Тэгээд одоо дараа нь ямар зөрчил үүсэх вэ гэхээр Төрийн албаны зөвлөл дээр энэ зовлон нь ирнэ. Дараа нь энд ажилласан хүмүүсийг төрийн албанд ажилд ороход төрийн албанд ажилласан гэж үзэх юм уу, ажиллаагүй гэж үзэх юм уу. Тэгээд дахиад энэ асуудал чинь өөрөө ТАЗ дээр дахиад зовлон дагуулж ирнэ ээ. Тийм учраас энэ бүгдийг нь буулгаад төрийн албан хаагч бол төрийн албан хаагчаар нь статусуудыг нь тодорхой болгож өгөх хэрэгтэй байна гэдгийг хэлэх гэсэн юм.

**Д.Амарбаясгалан:** Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

**Б.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг дэмжиж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар баярлаж байгаа. Анх Улсын Их Хурлын чуулганд орж ирж Ерөнхий сайдаар томилогдохдоо үнэн байя гэж хэлж байсан үнэн байгаа гэж бод итгэж байгаа.

Дээрээс нь Гомбожавын Занданшатар дарга Ерөнхий сайдын хэлсэн авлига албан тушаал ашиг сонирхлын зөрчилтэй сайд нарыг шууд чөлөөлнө өө гэдгийг хэлсэнд их баярлаж байгаа. Ер нь яах вэ энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнтэй холбоотой асуудал яагаад жилийн жилд гэдэг юм уу эсвэл Засгийн газар солигдох тоолонд эсвэл тодорхой Улсын Их Хурлын чуулганы дараа болгон хөндөгдөөд байдаг вэ гэхээр авлига, албан тушаалтай холбоотой, эрх ашигтай холбоотой л асуудлууд үүдэлтэй. Тодорхой удирдах албан тушаалтнуудаас үүдэлтэй асуудлууд байдаг. Би өнөөдөр энд нэг юм хөндөх гэж байгаа юм. Би түрүүн Монгол Улсын Засгийн газрыг дэмжиж байгаа гэдгээ илэрхийлсэн. Гэхдээ Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарын авлига албан тушаал ашиг сонирхлын зөрчилтэй сайд нараа шууд чөлөөлнө гэсэн учраас үнэн байя гэсэн учраас энд нь би итгэж энэ үгийг хэлж байгаа юм.

2024 оны 9 сарын 9-ний өдөр Монгол Улсын Боловсролын сайдын сургуулийн менежментийг сайжруулахад дэмж дэмжлэг үзүүлэх тухай тушаал гарсан. 1.2 тэрбум төгрөг. Энэ 1.2 тэрбум төгрөгийг болохгүй гэдгийг Улсын Их Хурал дээр хөндсөн. Үүнийх нь дагуу болохгүй гэдгээр нь ашиг сонирхлын асуудал Боловсролын сайд Наранбаяр хөндсөн байгаа. 120 сургуульд 10, 10 сая төгрөгөөр нь хуваарилалт хийгээд шилжүүлсэн. Эргээд сургуулийн судалгаа хөгжлийн шинэ Монгол төв нийгэмд үйлчлэх ТББ руу 120 сургуулиас 10, 10 саяар нь буцаагаад шилжүүлж авсан байгаа. Энэ бол яалт ч байхгүй ашиг сонирхлын зөрчил. Бүх материалууд нь энд байна. Сургуулиудын шилэн дансан дээр байсан материалууд нь ч энд байна. Бид нар энэ Боловсролын сайд Наранбаярыг зөвхөн энэ үйлдлийнх нь төлөө огцрох ёстой гэж үзэж байгаа.

Энэ асуудлыг хөндөж байгаа. Бид нар Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатар нэр бүхий гишүүдээс Боловсролын сайд Наранцогтыг огцруулах бичгийг удахгүй хүргүүлнэ ээ. Та энэ дээр өөрийнхөө Улсын Их Хурлын танхимд хэлсэн үнэн байя. Хэрвээ манай сайд нар авлига албан тушаал ашиг сонирхлын зөрчилтэй холбогдвол шууд ажлаас нь чөлөөлнө өө гэдэг энэ үгэндээ үнэн байгаарай гэдгийг албан ёсоор хүсэж байна.

Тэгээд давхар бид нар энэ холбогдох материалуудыг АТГ болон бусад хууль хяналтын байгууллагад албан ёсоор шилжүүлж энэ асуудал дээр дараа дараагийн шаталсан үйл ажиллагаануудыг явуулна гэдгийг энэ удаа албан ёсоор хэлье ээ. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Замира гишүүн үг хэлье. Асуулт асууя. Лутаагийн Энхнасан гишүүн. Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууя.

**М.Мандхай:** Энэ төрийн хөрөнгө оруулалтын 535 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл хасагдахаар байгаа. Энэ дээр гол нь энэ барилга угсралт нөгөө дэд бүтцийн хөгжлөөс гадна ажлын байрны шинэчлэл, энэ хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын идэвхт өөрөө саад учрах үйл ажиллагаа ингээд удаашрах ийм нөхцөл харагдаж байгаа.

Тэгэхээр энэ нь өөрөө эдийн засгийн идэвхийг сааруулаад цаашдаа тэгээд ДНБ-ий өсөлтийг хүртэл удаашруулах эрсдэлтэй байна аа. Тэгэхээр энэ одоо энэ хөрөнгө оруулалтаас ажлын байрыг бий болгож байгаа хувийн хэвшлийг дэмжих энэ асуудал дээр Засгийн газар яг ямар байр суурьтай, ямар шийдэлтэй байгаа вэ гэдгийг асуумаар байна. Нөгөө талдаа төрийн үйлчилгээний хүртээмж буурахаар харагдаж байна. Хэрэв ингээд нийт Засгийн газрын түвшинд 9 хувь төрийн албан хаагчдын тоог бууруулаад ингээд тавьчихаар мэдээж зарим агентлаг бол татан буугдах юм уу хоорондоо нэгдэж нийлэх ийм өөрчлөлт орох байх. Гэхдээ хүний нөөц цөөрөх нь эргээд иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээ чинь өөрөө хүртээмж нь удаашрах чанарын хувьд муудах нөгөө шуурхай байдал чинь алдагдах юм биш үү гэдэг болгоомжлол байгаад байгаа. Тэгээд ялангуяа хамгийн чухал асуудал болох нөгөө нийгмийн боловсрол эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ үйлчилгээнүүд чинь одоо саарах, иргэдэд ирэх гомдол нэмэгдэх ийм эрсдэл харагдаад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг бас яг тооцож үзсэн үү? Хэрхэн шийдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа вэ гэдгийг хэлэх гээд байгаа. Яагаад би ингэж асууж байгаа вэ гэхлээр жишээлбэл Аргентин Грекийн тухайн үед гаргаж байсан 2015 онд жишээлбэл Грект бас яг адилхан энэ зардлыг бууруулснаас болоод ажилгүйдэл 27 хувь нэмэгдсэн байгаад байгаа. Ялангуяа тэр дотроо залуу ажилгүйдлийн тоо 50 хувь бүүр давсан тэгээд нөгөө нийгмийн үйлчилгээ эмнэлэг боловсролын үйлчилгээ доройтсон ийм асуудал үүсэж байгаа.

Тэгээд энэ дээр хэн хохирох вэ гэхээр эмзэг бүлэгт чиглэсэн нөгөө гол энэ халамж авч байгаа зорилтот бүлэгт маш эмзэг тусахаар байгаад байгаа юм. Нийгмийн эсэргүүцэл хөдөлмөрийн зах зээл дээр дарамт үүсэхээр байна аа. Тэгэхээр энэ төрийн албан хаагчдын цомхотгол энэ байгууллагын бүтэц үйлчилгээний төвлөрөл зэрэг нь орон нутагт иргэдийн бухимдал эсэргүүцлийг илүү авчрахаар харагдаж байгаа. Тэгэхлээр бид нар нэг талдаа ингээд төрийн албан хаагчдын тоог бууруулж байгаа юм шиг мөртөө нөгөө талдаа хөдөлмөрийн зах зээлийг бэлдэх хэрэгтэй байгаад байгаа.

Тэгэхээр энэ өөрөө бэлэн байгаа юм уу? Энэ хэмжээгээр хувийн хэвшил өөрөө энэ олон ажилгүйдлийг ажилгүй залуучуудыг авч ажиллуулах ийм боломж байгаа юм уу энэ тал дээр Засгийн газар хувийн хэвшлийнхэнтэй хэлэлцэж тохиролцсон юм байгаа юу гэдгийг бас тодруулж асуумаар байна аа?

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Ерөнхий сайд хариулъя.

**Г.Занданшатар:** Гишүүний асуултад хариулъя.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж хариулт өгөх дэгтэй байх. Тэгэхдээ 1 зүйл давхцаад байгаа учраас би тодруулж хийе гэж бодож байна аа. Энэ нь одоо төсвийн тодотгол хэлэлцээгүй. Төсвийн тодотгол хэлэлцэхэд тэр төсвийн хөрөнгө оруулалт төсвийн хэмнэлтийн хуулийн дагуу 528.5 тэрбум төгрөгөөр хэмнэлтийн хуулийн дагуу өөрөө хүчингүй болчихсон. Тэр тодотголоор орж ирнэ. Таны ярьж байгаа тэр орон тоотой холбоотой асуудлууд яригдана. Ер нь төрийн чадамж гэж нэг үзүүлэлт байна. Төрийн чадамж гэдэг үзүүлэлтээр төр иргэддээ хүртээмжтэй, чадвартай, чанартай үйлчилгээ үзүүлж байгаа хүртээмжтэй байдал, чадвартай үйлчилгээний байдлаар, төрийн чадамжаар Монгол Улс 145 орны дунд хийсэн судалгаагаар хамгийн муу чадамжтай болсон гэсэн ийм үнэлгээнүүд явдаг юм байна лээ. Тэгэхээр энэ зөвхөн орон тоотой ч холбоотой асуудал биш. Сахилга хариуцлага дэг журам зөвхөн энэ цахимжилтаар ч юм уу аль эсвэл орон тоогоор ч юм уу дангаараа шийддэг асуудал биш.

Ер нь яах вэ зүгээр төсвийн тодотгол дээр дэлгэрэнгүй ярих учраас би нэг зүйлийг онцолж хэлэхэд хэрвээ энэ 3.3 их наядаар төсвийн орлого дутаад төсвийн алдагдал нэмэгдвэл тэр хэмжээгээр инфляц валютын ханшийн өсөлт бидний төсөөлөөгүй хэмжээнд хүрч ард иргэдийн амьжиргаан дээр асар том дарамт хүндрэл учруулж үнийн ханшийн өсөлт бол маш өндөр болох гээд байгаа. Энийг л урьдчилан сэргийлж байгаа алхам гэж хамгийн товчоор хэлбэл ойлгож болно. Тэгээд энийг төсвийн тодотголын үеэр хэлэлцэх учраас хэн нэгэн хүнийхээ ажилгүй болгож амьдралыг нь хохироох гэж байгаа гэхээсээ илүү төрийн бүтээмж чадамжийг сайжруулах давхардсан орон тоог цэгцлэх. Хамгийн гол нь ард иргэдийн нуруун дээр энэ 3.5 сая хүний нуруун дээр ирэх гэж байгаа үнийн дарамт, ханшийн өсөлт, бүтээгдэхүүний үнийн өсөлт, шатахууны үнийн өсөлт бол дэлхий даяар болж байгаа нөхцөл байдал манай энэ төсвийн алдагдал тэрний санхүүжүүлэх өр зээлийн байдалтай уялдаатай байгаа учраас макро эдийн засгийн тэнцвэрийг хангах зайлшгүй шаардлагатай үлдэж байгаа юм гэдгийг би онцлон тэмдэглэж хэлмээр байна. Тэгээд энийг бол тухайн үед нь хэлэлцээд явна аа.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

**М.Мандхай:** Төсвийн үеэр тодотголын үеэр олж ярих нь мэдээж дахиж хэлэлцэгдэх нь зөв өө. Тэгэхдээ бид нар нөгөө Засгийн газрын бүрэлдэхүүний тухай өөрчлөлт оруулах төслийг ярьж байгаа учраас яалт ч үгүй бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орно. Тэгэхээр яах вэ? Би зүгээр энэ дээр нэмээд нэг хэлэхэд бид нар цомхотголын асуудал бүтээмжийг сайжруулж үр юу гэдэг юм үр ашиггүй, үр өгөөжгүй байгаа, ажлын байруудыг цомхотгох нөгөө талаар эдийн засгийг идэвхжүүлэх нь зүйтэй боловч нэг зүйл дээр анхаараасай гэж хэлмээр байгаа юм. Энэ цомхотгож байгаа төрийн албан хаагчдыг ядаж энэ хөдөлмөрийн зах зээлд дахин шилжүүлэх, сургах, чадавхжуулах тэр дэмжлэгийн хөтөлбөрүүдийг нь давхар хэрэгжүүлж ялангуяа энэ ажилгүйдэл олон ихэнхээр ажилгүй болох ажилгүйдлийн асуудал энэ ядуурлын эрсдэлээс сэргийлж ажиллаасай гэж захиж хэлмээр байна аа.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. гишүүд өнөөдөр 11 асуудал хэлэлцэж байгаа асуудал болгон ард дээрээ шууд санал хураалтаа хийгээд явна. Тэгэхээр гишүүд чуулганы танхимд ойрхон байцгаана шүү.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууя.

**Д.Энхтүвшин:** Хамт өргөн мэдүүлсэн дагаж өөрчлөгдөх хуулийн төслүүдтэй холбоотой 3 асуулт байна 1 дүгээрт нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дугаар заалтаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл батлагдсанаас хойш 3 сараас доошгүй сарын хугацаанд тухайн жилийн төсвийн төсөл төсвийн тодотголын төсөл өргөн мэдүүлэх батлахыг хориглохоор заачихсан байгаа. Тэгээд 7.6 дээр нь болохоор энэ заалтад нь хамруулахгүй байх 2 зүйлийг заасан. Гамшгийн аюулын хор уршиг, онцгой нөхцөл байдлын үр дагаврыг арилгах гэсэн.

Тэгээд энэ дээр нэмж Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор төсөв төсвийн тодотгол батлахад энэ 7.5 дугаар заалт хамрахгүй байхаар хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байна аа. Тэгээд энэтэй холбоотой нэг санал нэг асуулт байна. Тэгээд энэ заалт нь ерөнхийдөө их ерөнхий санагдаж байгаа. Сайд нарын эрхлэх асуудал өөрчлөгдөхөд Засгийн газрын агентлаг шинэ хороо байгуулагдах гэх мэт л асуудал ярилцах үед олон нийтийн хэлэлцүүлэг хийхгүйгээр төсвийн тодотгол хийж зардлыг нэмэгдүүлэх юм уу бууруулах ийм боломж нээгдэж байгаа. Тэгэхээр энэ заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч энэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбоотойгоор гэсэн энэ ерөнхий заалтыг Засгийн газар шинээр байгуулагдсантай холбоотойгоор гэж өөрчлөх гэсэн ийм санал оруулах боломжтой юу гэдэг нэг ийм асуудал байна санал байна.

Асуулт нь болохоор Сангийн сайдаас Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7.5 дугаар заалтын талаар ер нь та юу гэж бодож байгаа юм? Энэ 3 сарын хугацааны дараа дотор өөрчлөлт оруулж болохгүй тэгээд энэ 7.5тай холбоотой энэ заалтад хамруулахгүй байхаар ойрын үед төлөвлөж байгаа заалтууд байна уу үгүй юу? Сая бид нар ажлын хэсэг дээр Булгантуяа сайдаар гишүүнээр ахлуулсан ажлын хэсэг дээр энэ асуудлаар ярихад 34.2 асуудлаар ойрын үед энэ заалтад хамруулахгүй байхаар төсөл яригдах шаардлага байна гэж ойлгосон. Энэ талаар Сангийн сайдаас нэг тодруулга авъя.

Хоёрдугаарт нь болохоор Засгийн газрын дахь Хяналтын тухай хуулийн 1.1 дүгээр хэсэгт хууль тогтоомжийн гэснийг нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг шийдвэрийн гэж өөрчлөхөөр тусгасан байна. Тэгээд хуулийн төслийнх нь үзэл баримтлал дээр нь харахаар Шадар сайдын буюу Эдийн засгийн хөгжлийн сайдын асуудалд хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих.

Хоёрдугаарт нь Хэрэг эрхлэх газрын даргын асуудалд болохоор хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал гэж тусгасан байгаа. Гэтэл Засгийн газрын тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 12 ЗГХЭГ нь энэ хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих хяналт шалгалтыг зохион байгуулна гэсэн заалтыг 2024 оны 7 сарын 10-нд энэ заалтыг хүчингүй болгочихсон байгаа. Тэгэхээр энэ хууль тогтоомжийн хэрэгжилт Засгийн газрын

шийдвэрийн биелэлт нь цаашид аль субъект ямар зүйл заалтын дагуу хяналт тавих вэ гэдэг 2 дугаар асуулт байна.

Гуравдугаарх нь болохоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 16.1-д хууль, тогтоомжийн төслийг үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулна гэж заасан байгаа. Засгийн газрын тухай хуулийн 34<sup>2</sup> дээр 2 дугаар заалтыг хүчингүй болгож байгаа талаар энэ үзэл баримтлал дээр ямар нэгэн асуудал дурдаагүй байгаа. Тэгээд яг энэ заалтыг нь аваад үзэхээр 34.2.1 дээр болохоор 3 яам байгаа юм. ХХААХҮ-ийн сайд, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Эрчим хүчний сайд нар ажлын албатай байхаар ийм заалт хуулийн нэг заалтыг нь харахаар 19, 20, 21 дээр ийм заалт байгаа.

Тэгэхээр энэ сайдуудын ажлын алба нь татан буугдаж байна гэсэн үг үү. Эсвэл энэ.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Сангийн сайд Болдын Жавхлан.

**Б.Жавхлан:** Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Энхтүвшин гишүүн ээ тэр хуулийн заалтууд яах вэ ер нь төсвийн сахилга батыг чиглүүлсэн тэрийг илүү их чангатгасан л үзэл баримтлал нь бол зөв юм санал нийлж байгаа юм. Яах вэ цаг хугацааны хувьд дээрээс нь манайх шиг уул уурхайн эдийн засгийн хэт их хамааралтай тэр нь биднээс өөрсдөөс хамаарахгүй гадаад нөхцөл байдлаас их хамааралтай ийм савлагаатай эдийн засагтай улс орны хувьд нэлээн бид өөрсдийгөө маневр хийх, төсөл тэнцлүүдээ сайжруулах ийм боломжуудыг хязгаарлачхаад байна гэдэг нь өнөөдөр амьдрал дээр харагдаж байна л даа. Та энийг ийм юмыг анзаараарай. 7.5-ын эхлэхдээ Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл гээд шууд эхэлчихсэн байгаа юм. Аль оных вэ гэдгийг нь заагаагүй. Одоо жишээ нь бид нар энэ жил 2 төсвийн хүрээний мэдэгдэл яриад байна шүү дээ.

Одоо бид нарын ингээд тодотгол хийж эхлэх гэж байгаа чинь бол 2025 оны төсвийн хүрээний мэдэгдлээр эхэлнэ. Гэтэл Одоо ерөөсөө хэдхэн хоногийн өмнө сар хүрэхгүй хугацааны өмнө бид нар 26 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлийг энэ жил баталчихсан. Одоо ингээд тодотгол хийхээр чинь 2025 оныхоо төсвийн хүрээний мэдэгдлийг өөрчилнө. Гэтэл төсвийн хүрээний мэдэгдэл чинь өөрөө дараагийнхаа 2 жилийн төсвийн төсөөллүүд нь байж байдаг. Ингээд 2025 оны төсвийн хүрээн дээр өөрчлөлт орохоор 26, 27 оны төсөөллүүд нь өөрчлөгдөөд дахиад 26 оны буюу сая хэдхэн хоногийн өмнө баталсан төсвийн хүрээний мэдэгдэл маань дахиад өөрчлөх шаардлага гараад ирж байгаа юм. Иймэрхүү өөрчлөлтүүдийг хийж байж тодотголоо хийхгүй бол бид нар нөгөө нэг 3 сар гэдэг хугацаагаараа дахиад 9 сарын 1-нд бид нар төсвөө өргөн барьж чадахгүй болчихно.

Одоо тодотгол баталснаас хойш дахиад 3 сар хүлээж байж ирэх оныхоо төсвийг өргөн барих иймэрхүү хугацааны ийм хайж ороод ирж байгаа учраас амьдрал баян шүү дээ. Одоо жишээ нь шинэ Засгийн газар энэ удаа ингээд 6 сарын сүүлээр байгуулагдлаа. Эсвэл Засгийн газрын бүтцэд өөрчлөлт орох, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах асуудлууд бол хэзээ ч тохиолдож болно. Хэзээ ч тохиолдож болно гэх мэт ийм хязгаарлалтууд байгаа учраас энийг зохицуулалтуудыг нь хийж өгөхгүй бол болохгүй байна аа. Ийм юм байгаа юм.

Тэгээд эдгээр өөрчлөлтүүд нь хэрвээ орчих юм бол ойрын хугацаанд ямар нэг хугацааны хайч байхгүй ингээд зөрчилгүй явчих боломж байгаа. Тэрнээс биш дахин дахин энийг өөрчлөөд байх шаардлага би гарахгүй болов уу л гэж ингэж харж байна.

7.5 6 дээр мөн та ингэлээ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн гэдгийг шинэ Засгийн газар гэдгээр сольё гэж байна болохгүй юу гээд. Тэгэхээр энэ 2 ер нь адилхан. Шинэ Засгийн газар байгуулагдаад бүрэлдэхүүнд нь л өөрчлөлт орно. Бүтцэд нь өөрчлөлт орж байгаа, нөгөөдөх нь ч гэсэн бүтэц гэж байгаа учраас нөгөө нэг бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд гэдэг нь өөрөө олон тохиолдлыг хамрах нөгөө арай илүү илүү хүрээг хамрах учраас тэр заалтаар нь орж ирж байна гэсэн үг юм байгаа юм.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Бямбацогт сайд хариулт өгье.

**С.Бямбацогт:** Эдийн засаг, хөгжлийн яаманд хөгжлийн бодлогын бичиг баримтууд буюу алсын хараа 2050 Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэл, 5 жилийн үндсэн чиглэл. ЗГ-ын үйл ажиллагааны 4 жилийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, төсөв зэрэг бодлогын бичиг баримтуудыг яаж, хэрхэн яаж хэрэгжилтийг хангаж байна гэдэг тал дээр хяналтаа тавина. ЗГХЭГ бол хууль, тогтоомж Засгийн газраас гаргасан шийдвэрүүдийн биелэлт дээр хяналт тавина. Үйл ажиллагааны хяналт гэсэн үг. Урьд нь 2024 оноос өмнө яг ийм чиг үүрэгтэй байсан. 2024 онд сая сонгуулийн дараа Хяналт хэрэгжүүлэх ерөнхий газар байгуулагдаад үндсэндээ энэ 2 чиг үүрэг хоёулаа хяналт хэрэгжүүлэх ерөнхий газар хэрэгжүүлдэг болсон. Үүнийг өөрчлөөд үндсэндээ 2024 оноос өмнөх чиг үүрэг рүү нь чиглүүлж байгаа юм аа.

Өөрөөр хэлэх юм бол Эдийн засаг, хөгжлийн яам бодлогын бичиг баримтын хяналт тавина. Хэрэг эрхлэх газар бол үйл ажиллагааны хяналт тавих юм. Ийм ялгаатай болж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тодруулж асууя.

**Д.Энхтүвшин:** Саяын тэр Хэрэг эрхлэх газрын хууль тогтоомжтой холбоотой, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавихтай холбоотой заалт нь зүйл заалт нь ерөөсөө байхгүй болчхоод байгаа юм. Тэгэхээр яах вэ хэрэгжүүлнэ гэж ярьж байгаа боловч яг хуулийн хувьд энэ зүйл заалт нь байхгүй болчхож байгаа учраас энэ нь дахиж оруулж ирэх ч юм уу эсвэл энийгээ буцааж сэргээх ийм асуудал байхгүй байсан юм уу гэдэг асуудал байгаад байгаа юм.

Түрүүчийн Жавхлан сайдын асуултад болохоор энийг бас Засгийн газрын бүрэлдэхүүн бүтэц бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах гэхээр маш өргөн асуудал болчхож байна. Нэг сайдын асуудал ч юм уу, дэд сайд орж ирэх ч гэдэг юм уу эсвэл хариуцах асуудлууд дээр нь өөрчлөлт орж ирэхэд энэнтэй дагуулаад төсөв хэлэлцүүлэггүй хурдан тодотгох ийм бололцоо боломжууд нээгдэж байгаа учраас илүү том өргөн энэ цонх нээгээд байгаа учраас энийгээ илүү тодорхой болговол шинэ Засгийн газар байгуулагдвал энэ тодотгох бололцоо боломжуудыг нь нээгддэг.

Нөгөөдөх нь төсвийн захиран зарцуулагч хоорондоо шилжүүлэхэд угаасаа. Сангийн сайд Болдын Жавхлан хариулт өгье.

**Б.Жавхлан:** Энхтүвшин гишүүн ээ нэг ийм зовлон байдаг юм аа. Төсвийн хууль дээр ингэж байгаа юм. Төсвийн ерөнхийлөн захирагч яг тухайн жилийнхээ төсвийн хууль дээр ямар нэр, нэршлээр батлагдсан, яг тэрүүгээр л төсөв захиран зарцуулах эрх нь нээгддэг. Нэг сайдын нэг яамны нэр дотор цэг таслал өөрчлөгдөхөд бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орж байна гэж үздэг. Тэрний дагуу тодотгол хийж ядаж тоо нь өөрчлөгддөггүй юм гэхэд нэрийг нь өөрчилж тодотгол хийхгүй бол тэр хүн төсвөө ерөнхийлөн захирах захиран зарцуулах эрх нь төрийн сан дээр үүсэхгүй.

Тэгэхээр заавал тодотгол хийхээс өөр аргагүй болно. Бид нар ийм нарийн дэгтэй хуультай.

**Д.Амарбаясгалан:** Даваагийн Цогтбаатар гишүүн асуулт асууя.

2 гишүүний дараа энэ чинь үг хэлэх 3 гишүүн байгаа. Тэгээд санал хураалт шууд явагдана. Гишүүд танхимдаа цуглая 10 секунд хасагдчихлаа.

**Да.Цогтбаатар:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тэгээд Ерөнхий сайдтай уулзаж байгаагийнх энэчээ энэ хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль дээр нэг хэдэн санал хэлэх гэсэн юм. Байнгын хорооны санал үгүй хурал болон өмнөх Улсын Их Хурлын чуулганы хурал дээр та байгаагүй учраас би энэчээ зарим зүйлийг давтаж ярьж байж магадгүй. Тэгэхдээ энэ Төсвийн тухай хууль дээр жишээлэхэд төсвийг зарчимтай зарцуулна аа, хариуцлагатай хандана аа, үр ашигтай, хэмнэлттэй байлгана. Тэгээд төсвийн ерөнхийлөн захирагч нар нь томилсон байгууллагынхаа өмнө хариуцлага хүлээнэ гэх мэтчилний ийм хариуцлагын заалтууд байгаа.

2024 оны Засгийн газрын санхүүгийн тайлан энэ 7 хоногт Улсын Их Хурлаар хэлэлцэгдсэн. Нийтдээ 122 их наяд төгрөгийн 6916 хуулийн этгээдийн асуудлыг ярьсан. 15 их наяд төгрөгийн хязгаарлалттай дүгнэлт гарсан. 15 их наяд төгрөг. Жишээлэхэд нийслэл дээр НЗД улирч томилогдоод байгаа хүн 2024 онд 12 тэрбум төгрөгийн алдаа дутагдал гаргачихсан байх жишээний. Одоо энэчээ нь ингэж байгаа юм. Батлагдсан төсвийг зориулалт бусаар үр ашиггүй зарцуулсан. Нийслэлд 3.2 тэрбум, анхан шатын баримтын бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийчихсэн нийслэл 1.9 тэрбум. Тендерийн тухай хууль зөрчсөн нийслэл 7.6 тэрбум гээд байхад бид нар жишээлэхэд НЗД-ыг улируулан томилоод сайн ажиллаж байна гээд ажиллуулаад байгаа юм. Одоо энэ нийслэлийн төсөв чинь 10 жилийн өмнөх улсын төсөв шүү дээ.

Тэгэхээр энэ дээр хариуцлага тооцдог байж болохгүй юу? Пүрэвдорж гишүүн ээ. Би асуулт асууж байгаа шүү. Тэгэхээр энэ хариуцлагынхаа асуудлыг бид нар авч явахгүй бол үлдээд байна. Үлдсэний чинь хажууд энэ авлигатай чинь цуг Монгол Улс хөгжиж чадахгүй хоцроод байна аа.

Тийм учраас Ерөнхий сайдын хийх эхний ажил нь магадгүй энэ хариуцлагын ажил байх болов уу. Энэ дээр таны байр суурийг нэг сонсох гэсэн юм? Дараагийн

нэг хариуцлагагүй газар байна. Төрийн банк. Хувьцааных нь үнэ нь IPO хийчихсэн банкнуудтайгаа харьцуулахад хамгийн их уналттай явж байгаа банк. Тэгсэн мөртөө удирдлагууд нь хэдэн 100 сая төгрөгийн цалин авна жилд. Тэгээд дээрээс нь өөрсдийгөө хэдэн тэрбумаар урамшуулна. Гэтэл Төрийн банк чинь өөрөө миний мэдэхийн энд тэнд өр зээлтэй байгууллага гэх мэтчилнээр одоо энэ сайд нарын асуудал ч гэсэн энэ дээр давтагдаад байгаа. Би энэ өнгөрсөн чуулган дээр асуучихсан учраас үлдээчихье. Гэхдээ сайд нарт энэ асуудлыг чинь хэлэхээр сайд нар чинь биеэ өмөөрөөд байна лээ Ерөнхий сайд аа. Энэ одоо жишээлэх юм бол Уул уурхайн сайд бол Эрдэнэс Монгол нь хариуцдаг, ЭТТ нь хариуцдаг гээд. Энэ Төсвийн тухай хууль дээр чинь бол томилсон байгууллагынхаа өмнө хариуцлага хүлээнэ буюу сайд нар нь тэр харьяа байгууллагынхаа хариуцлагыг нь үүрүүлж чадахгүй байгаа асуудал явсаар байгаад Монголд 30 жил болчихсон байсныг Бямбацогт сайд угаасаа өөрөө баталж өгсөн. Тэгэхээр энэ дээр хариуцлага тооцдог байх тал дээр яг эхний энэ Засгийн газрын хийх ажил дээр энэ тал дээр ямархуу ажил хийж хэрэгжүүлж эхлэх вэ?

Таны байр суурийг сонсох гэсэн юм аа?

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайд хариулт өгье.

**Г.Занданшатар:** Даваагийн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя аа.

Энэ Төрийн банктэй холбоотой асуулт асууж байна. Зөвхөн Төрийн банк төдийгүй төрийн нийт өмчийн компаниудын үйл ажиллагааг зохицуулсан үр ашигтай болгоход чиглэсэн Нийтийн өмчийн тухай хуулийг хуучнаар Төрийн ба орон нутгийн өмчийн тухай хуулийг Засгийн газраас өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн. Өнөөдөр өргөн барих байх гэж бодож байна. Энэ хүрээндээ ТӨБЗГ-т төрийн өмчийн Төрийн банк төдийгүй төрийн өмчийн бүх ААН-үүдийн үр ашгийг тодорхойлох цалин хөлсний дээд хязгаарыг тогтоох, хувьчлах, үр ашгийг нь дээшлүүлэх, нэгтгэх нийлүүлэх ийм цогц арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахыг даалгасан.

Өнөөдрийн Засгийн газрын хуралдаанаар жишээлбэл 2 компанийг нэгтгэж алдагдалтай ажилласан 2 компанийг нэгтгэх ийм шийдвэр гаргасан. Энэ бол нөгөө хариуцлага сахилгатайгаа ч холбогдоод хэрэгжиж байгаа ийм бодитой тодорхой шийдвэрүүд. Зарчмын хувьд энэ Даваагийн Цогтбаатар гишүүний гаргаж байгаа санхүүч хүний хувьд гаргаж байгаа саналууд байгаа. Их зүйтэй саналууд байгаа. Энийг аудитын дүгнэлт бол Засгийн газрын эрх хэмжээний асуудал биш ээ. Энэ бол таны Их Хурлын эрх хэмжээний асуудал. Их Хурлын харьяа байгууллагын Засгийн газарт хөндлөнгөөс хийсэн аудитын дүгнэлтийг та бүхэн хэлэлцээд дүгнэлт гаргаад, чиглэл өгөөд Байнгын хороо Төсвийн зарлагын хяналтын дэд хороогоороо хэлэлцэх учиртай дэгтэй. Тэрүүгээрээ хэлэлцэж дүгнэлт гаргаж шийдэх ёстой асуудал гэж бодож байна аа.

Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн тэр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг асуусан. Тэгэхээр энэ хууль төсвийн тодотголд биш, төсвийг, төсвийн хүрээний мэдэгдлийг 6 сард боловсруулчихаад 10 сард өргөн мэдүүлэхдээ төсвийн хүрээний мэдэгдлээ өөрчлөөд ороод ирдэг байсан практикийг засах гэж л орж ирсэн юм. Түүнээс биш энэ процедураар явбал 5 сар болох юм билээ. Тэгтэл өнөөдөр байшин шатаад эхэлж байхад тэрийг унтраахгүй ингээд хэлэлцээд 5 сар болно

гэвэл өнөөдрийн өдөр хоногоор өөрчлөгдөж байгаа эдийн засгийн нөхцөл байдал улам хүндэрнэ ээ.

Ийм учраас энэнтэй зохицуулж цаашдаа Төсвийн тогтвортой байдлын хуулийг өөрчилж гэсэн саналыг Төсвийн байнгын хороон дээр гаргаж байна лээ. Тэр процессын хууль органик хууль хоёрынхоо харилцааг зөв хангаад цаашдаа тэр эрх зүйн шинэчлэл хийх нь бол Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүн асуулт асууя.

**М.Энхцэцэг:** Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ.

Тэгээд Ерөнхий сайдаас хэд хэдэн асуултууд асууя.

1 дүгээр асуулт болохоор 58 Үндэсний хороог татан буулгана гэсэн байна. Тэгэхээр 58 Үндэсний хорооны 50 хувийг буюу 29 Үндэсний хороо. Тэгэхээр энэ үндэсний хороон дээр Эрчим хүчний үндэсний хороог татан буулгах асуудал орж байгаа юу гэж асууя.

Хоёрдугаарт нь ДЦС 3 дээр гарсан ослын үндсэн шалтгаан ЭХЯ 4-өөс 5 толгойтой байснаас боллоо гээд маш их ярьж байгаа, та ч маш их ярьж байгаа. Гэхдээ энэтэй би 100 хувь санал нийлэхгүй байгаа. Мэдээж яах вэ энэ тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. Гэхдээ өнөөдөр ЭХЯ яг үндсэн ажлаа гүйцэтгэл мэдээлэл сайн биш байгаа учраас л тэр нэг ийм эрчим хүчний реформыг хэрэгжүүлэх Эрчим хүчний үндэсний хороог байгуулсан.

Хоёрдугаарт нь Эрчис Монгол компани гээд байгуулаад эрчим хүчний компаниудыг нэгтгэсэн. Тэгэхээр энэ бол мэдээж ингээд нэг тодорхой хэмжээний үндэслэлтэй амьдралаас ургаад л ямар сайндаа л энэ нэг бүтцүүдийг гаргаж ирсэн л байх л даа. Жишээлбэл яагаад эрчим хүчний Эрдэнэс Монгол компанийг байгуулсан бэ гэдэг дээр нэг үндэслэл их ярьдаг. Тэр бол ЭХЯ-ны хүмүүс дор хаяж 2-оос 3 компанийн ТУЗ-д ордог. Ингэснээрээ нөгөө яамныхаа үндсэн ажлаа хийдэггүй гэдэг асуудал байсан.

Тэгэхээр энийг засаж залруулахын төлөө та ямар ажил хийх вэ?

Хоёрдугаарт нь эрчим хүчний реформыг хэрэгжүүлнэ гээд маш олон ажлуудыг төлөвлөөд явж байгаа. Тухайлбал Эрчим хүчний тухай хуулийг шинэчлэх ажлын хэсэг Улсын Их Хурал дээр байгуулагдсан. Бид нар бүтэн цагаар сүүлийн 8 сар ажиллаад дулааны анхдагч жараад хуудастай хуулийг драфталчихсан. Эрчим хүчний чөлөөт зах зээл рүү шилжүүлэх 150 гаран хуудастай процессын шинж чанартай хуулийг шинэчлэх гээд явж байна. Энэ бол ингээд реформын хүрээнд хийгдэх ажил. Тэгээд Үндэсний хороо ингээд татан буугдаж байгаа болохоор реформын хүрээнд хийгдэх тэр зорилтууд ЭХЯ-ан дээр очиж хуваарилагдаж зорилт нь болоод явах уу? Энэ дээр та хэр анхаарал хандуулж ажиллах вэ?

Ялангуяа бид нар эрчим хүчний салбарыг чөлөөт зах зээл рүү шилжүүлж байж л өнөөдөр байж л өнөөдөр ус нуруун дээрээ байгаа ачаанаас хөнгөлнө. Тэгж байж л энэ эрчим хүчний салбар луу гаднын хөрөнгө оруулалтыг татна. Тэгж байж

бид нар цахилгаанаар хангагдаж дулаанаар хангагдаж чадахгүй байгаа хэрэглэгчээ хангадаг болно. Тэгж байж нөгөө энэ журам давамгайлчихсан манай эрчим хүчний тухай хууль маш ерөнхий 800 гаран журмаар өнөөдөр ажиллагаагаа зохицуулж байгаа.

Тэгээд намайг Улсын Их Хурлын гишүүн болоод ирэхэд эрчим хүчний хуулийг шинэчлэх ажлын хэсэг ЭХЯ-ан дээр байгуулагдаад 3, 4 жил болж байгаа гэсэн хуулиа шинэчлээгүй. Тэгээд яг бид нар ингээд бүтэн цагаар ажиллаад хууль гаргаж байна. Энэ дээр ЭХЯ төдийлөн хамтарч ажиллаж чадаагүй. Тэгэхээр энэ дээр Засгийн газар хэр хамтарч ажиллаад энэ реформыг хэр цааш нь явуулах вэ гэдэг ийм л 3 асуултыг асууя аа.

Эрчис Монголын тухайд үнэхээр энэ буруу шийдвэр гэдгийг хамгийн их хэлж ярьсан хүн би байгаа. Ингэж эрчим хүчний салбарыг олон толгойтой болгох даргыг дахиад нэмэх нь хариуцлагыг сулруулна аа. Төвлөрүүлэх чинь буруу аль болох бие даалгах хэрэгтэй тэгж байж өрсөлдөөн бий болгох хэрэгтэй. Өрсөлдөөн тэсэж үлдэхийн тулд өөрөө өөрийнхөө системийг өөрөө өөрийнхөө тэр үйл ажиллагааг сайжруулаад явдаг тэр систем рүү шилжих нь чухал юм аа. Тэрний хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал юм гэж маш их ярьсан.

Тэрний төлөө нэлээдгүй ажлыг хийгээд явж байгаа. Тэгээд энэ чиглэл дээр Засгийн газар хэр дэмжиж ажиллахаа зорилт тавин ажиллаж байгаа вэ гэсэн ийм асуулт байна аа.

**Д.Амарбаясгалан:** Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

**С.Бямбацогт:** Энхцэцэг гишүүний асуултад хариулъя.

58 Үндэсний хороог бараг 2 дахин цөөлж байгаа. Энэ дотор таны асууж байгаа Эрчим хүчний үндэсний хороо, Боомтын үндэсний хороо, Хяналтын үндэсний хороо гээд одоо бас яг яамтай тодорхой ажлын албатай. Тодорхой төсөв зардалтай байсан. Эд нар эхний ээлжид орж байгаа. Араас нь төсвийн тодотгол дагаад бусад үндэсний хороод эндээс зөвхөн хуультай. Зайлшгүй байх ёстой Жендерийн үндэсний хороо гэх мэтийн хуультай Үндэсний хороод үлдэнэ. Зарим нэг юу гэдэг юм төсөв орон тоо байхгүй Үндэсний хороод үлдэнэ. Бусад үндэсний хороодыг бүгдийг нь татан буулгах ийм бодлого барьж байгаа. Яагаад гэвэл ингээд төрийн байгууллагуудын ажлын чиг үүргийн давхардал ялангуяа яамдын бүтэц чиг үүрэгтэй давхардсан үндэсний хороод нэлээн олон байгуулагдсан байсан. Эдгээрийг татан буулгах ийм зохион байгуулалтууд хийж төсөв зардлыг хэмнэх, илүү бүтээмжийг нэмэгдүүлэх бодлого барьж байгаа.

Эрчим хүчний компаниудын хувьд бүгдээрээ л Монгол Улсын ард иргэдийг ААНБ-ыг цахилгаантай, дулаантай, галтай, голомттой байх үндсэн зорилготой чиг үүрэгтэй. Үүнийхээ төлөө өдөр шөнөгүй цаг наргүй ажилладаг ийм албан хаагч нар. Энэ дээр юу гэдэг юм компани болгон дээр ингээд тусдаа ТУЗ-тэй байгаад ТУЗ-ийн гишүүд нь ЭХЯ-ны газрын даргаас нь авхуулаад мэргэжилтэн хүртлээ байгаад тэгээд ингээд давхар давхар сард 2 сая төгрөгийн цалин аваад ингээд байх нь бол тийм зохимжтой биш байна аа. Энийг цомхон чадварлаг илүү юу гэдэг юм хоорондоо мэдээлэл солилцоо уялдаатай байх бололцоотой байдлаар ингээд нэгдсэн 1 тийм удирдлагатай, нэгдсэн ТУЗ-тэй байх юм бол зардал ч хэмнэх юм

байна. Тэр компани Тэц-3, Тэц-4, Тэц-2. Цахилгаан станц компаниудын хооронд хаана ямар давуу талууд байдаг юм, хаана ямар сул талууд байдаг юм. Хаана ямар үргүй зардал байна хооронд нь харьцуулагдаад ингээд хэмнээд хянаад явах боломжтой гэдэг байдлаар эрчим эрчим Монгол компани байгуулж мөн давхардсан газар болгон дээр хүний нөөц, газар болгон дээр хуулийн зүйл газар болгон дээр юу гэдэг юм маркетингийн алба гээд. Ингээд ерөөсөө л тэр эрчим хүчний компаниудын дунд нь бодлогын зохицуулалт хийх бодлогын зохицуулалтыг хийх зорилгоор тэр Эрчис Монгол компанийг байгуулсан юм байна лээ.

Харамсалтай нь нэг үйл ажиллагаа явуулж чадаагүй. Хоорондоо үл ойлголцол үүссэн. Үүнээсээ болоод ингээд асуудал үүсчихсэн байгаа. Үүнийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр бас нэг бүрчлэн нарийвчилсан шинжилгээ хийж тодорхой хэмжээнд асуудлыг судалж Ерөнхий сайдад танилцуулж байж цаашдаа хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг талаар тодорхой шийдэл гаргахаар ажиллаж байгаа.

Ер нь ингээд үзэхэд бол үндсэндээ маш адилхан олон компаниуд дээр давхардсан олон орон тоо байна, олон бүтэц байна. Үүнийг нэгтгээд нийлүүлээд зардал хэмнэх бололцоо байна. Мөн одоо шаардлагатай нэгэнд нь илүүдэлтэй, үнэгүй байж байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авлаа.

Мөнхчулууны Энхцэцэг гишүүн тодруулж асууя.

**М.Энхцэцэг:** Асуултдаа нөгөө гүйцэд хариулт авъя л даа. Эрчис Монголын талаар эрчим хүчний реформын талаар хариулж байгаа хариултад бол юу яаж байна ер нь санал нэгтэй байна. Энэ маш зөв зүйтэй асуудал. Хамгийн гол чухал асуудал болохоор эрчим хүчний реформын хүрээнд олон ажлуудыг хийхээр төлөвлөсөн. Тэгэхээр тэр бүх ажлуудыг өнөөдөр ЭХЯ хийх үү?

Хоёрдугаарт нь би сая хэллээ. Эрчим хүчний хуулийг шинэчлэх ажлын хэсэг Улсын Их Хурал дээр байгуулагдаад 8 сарын хугацаанд ажиллаад нэлээдгүй олон ажлуудыг хийгээд ингээд явж байгаа. Энэ дээр Засгийн газар хэр хамтарч ажиллаад яагаад гэвэл энэ реформыг хийнэ. Чөлөөт зах зээл рүү шилжүүлнэ гэдэг нь бүүр олон улсад батлагдсан бид нар ийшээ л явах ёстой. Тэгэхээр энийг Засгийн газар хэр дэмжиж ажиллах вэ энэ дээр ямар бодлого баримтлах вэ гэсэн энэ дээрээ хариултаа авъя гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Бямбацогт сайд нэмж хариулъя.

**С.Бямбацогт:** Тэгээд Эрчим хүчний үндэсний хороо, ЭХЯ эрчим хүчний чиглэлээр тодорхой дагнасан манай мэргэшсэн Энхцэцэг гишүүн, Цэнгүүн гишүүн гээд гишүүд бол маш ажил хэрэгч санал гаргасан. Энэ хүрээндээ эрчим хүчний үнэ реформ хийхээр зориг шулуудаад эрчим хүчний үнэ тарифыг нэмэгдүүлсэн. Энэ хэмжээгээр эрчим хүчний компаниудын санхүүгийн дарамт буурсан. Гэтэл нөгөө талдаа үргүй зардал, давхардсан орон тоо, тэнд байдаг хүнд суртал дээрээс нь нөгөө илүү дутуу шахаа бага үнэтэй юмыг өндөр үнэтэй шахдаг, эс үгүй бол нэгэнд нь байгаа юмыг тийм үү? Эвдэрсэн гээд буцаагаад засаад шинэ юм шиг буцаагаад нийлүүлчихдэг иймэрхүү бугширсан, ялзарсан, дотроо хуйвалдсан иймэрхүү

зүйлүүдийг засаж залруулж тэр эрчим хүчний өөрийнх нь үйл ажиллагааны өртөг зардлыг бууруулах боломж байгаад байгаа юм.

Энэ дээр бол гишүүдтэйгээ Энхцэцэг гишүүн, Цэнгүүн гишүүнтэйгээ хамтарч ажиллах талаар бид бодлого гаргана гэж бодож байгаа. Та бүхэнтэй хамтраад цаашдаа энэ дутуу хийсэн ажлыг гүйцээх.

**Д.Амарбаясгалан:** Ерөнхий сайд нэмж хариулт өгье.

**Г.Занданшатар:** Мөнхчулууны Энхцэцэг гишүүний асуултад хариулъя аа. Тодорхой асуултуудад хариулсан. Эрчим хүчний тухай хууль, эрх зүйн шинэчлэл Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийн асуудал. Холбогдох яам ЗГХЭГ-ыг хамтарч ажиллахыг үүрэг болгож тэр чиглэлээр хамтран ажиллахад бэлэн байна Манай Энхцэцэг гишүүн эрчим хүчний чиглэлийн мэргэжлийн хүмүүсийн дуу хоолой оролцоо их чухал аа. Энэ чиглэлээр тийм Улсын Их Хурлын гишүүдтэй зөвшилцөн хамтран ажлын хэсэг байгуулж ажиллахыг Эрчим хүчний сайдад үүрэг болгосон байгаа. Бүрэн либералчлалын хувьд манайх шиг ийм эмзэг эдийн засагтай, эрчим хүчнээс үнэ ханш бүрэн хамаардаг улсын хувьд бүрэн 100 хувь либералчлах, эрчим хүчний бүх компаниудыг хувьчлаад цахилгаан станцуудыг ч юм уу хувьчлаад бүрэн либералчлах боломж бол манай улсын хувьд хязгаарлагдмал 2 хөршийн нөхцөл байдал эрчим хүчний хараат бус байдал өөрийнхөө бие даасан байдлыг шийдвэрлэсний үндсэн дээр либералчлалыг үе шаттай дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна аа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй 5 санал байна аа. Гишүүд санал хураалтад бэлтгэе.

Зарчмын зөрүүтэй 5 санал байгаа.

Зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж түүнийг дэмжсэн болон эсрэг байр суурьтай гишүүд намын бүлгийн төлөөлөл тус бүр 2 гишүүн үг хэлэх боломжтой байгаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

ТББХ-ны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих асуудал гэснийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гэсэн санал байгаа. Тэгээд өчигдөр энэ асуудлаар Байнгын хорооны хурлын дараа холбогдох Байнгын хорооны референтүүд, Тамгын газрын нөхдүүдтэй уулзсан.

Төсөл өргөн баригдахад хөндөгдөөгүй заалтаар санал гаргасныг Байнгын хороон дээр санал хураалгасан байгаа. Тийм учраас Тамгын газар энэ Байнгын хорооны референтүүд энэ дээрээ хариуцлагатай хандаж байхгүй бол Улсын Их Хурлын гишүүд зарим талаар дутуу мэдээлэлтэй санал гаргаж болно. Тухайн саналыг хураалгах эсэх дээр мэргэжлийн байр сууриа илэрхийлж асуудлыг шийдвэрлэж байхгүй бол өмнө нь 1, 2 удаа давтагдаж байсан.

Хураалгах ёсгүй саналыг хураалгаж Улсын Их Хуралд оруулж ирж байгаа. Ингээд санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж гишүүнтэй уулзаж энийг ярилцаад өнөөдөр зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгахааргүй болсон байгаа. Энэ хариуцлага алдсан албан тушаалтанд. Эхнийх нь шүү дээ. Тийм. Тэгэхдээ тийм бүсчилсэн дээр бүсчилсэн хөгжлийн бодлогын асуудал дээр.

Тэгэхээр тэр асуудлыг ер нь энэ Тамгын газар онцгой анхаарч ажиллаж байгаарай гэдгийг энэ ташрамд сануулан хэлье ээ. Ирц болсон уу?

Санал хураалтад бэлдсэн байна.

Санал хураалт нэг дэх асуудлыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт.

21 гишүүн буюу 21.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн хяналт тавих асуудал гэсний дараа бүсчилсэн хөгжлийн бодлого гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн.

Тэгээд энэ чинь нөгөө хураалгаж болохгүй санал чинь энэ.

Пүрэвдорж гишүүн үг хэлье.

**Б.Пүрэвдорж:** Би нэг яг энэ асуудлаар үг хэлэхийнхээ өмнө би тодорхой шийдвэр гаргана. Тэгээд энэнийхээ өмнө би нэг ийм Жавхлан сайдаас нэг асуулт байна аа. Тэгэхээр Хөшөөтийн уурхай бол Ховдын ард иргэдийн хувьд бол хөл дээр нь гишгэдэг компани. Тийм учраас би нэлээн эсэргүүцдэг. 2019 онд 2, 3 өдөр зогсоож байж тэр тал дээр 3 хашаатай, 3 талт хашаан дээр 2 сая төгрөгөөр Хөшөөтийнхөө уурхайгаас нүү гэхэд нь эсэргүүцэж тэмцэж байж 3 өдрийн тэмцлийн үр дүнд хамгийн доод тал нь 8 сая дээд тал нь 230 сая төгрөг нийтдээ 1 4 тэрбум төгрөг Хөшөөтийн компаниас гаргаж ард иргэдэд өгч байсан.

Тийм учраас Хөшөөтийн уурхай бол надад нэлээн дургүй байдаг. Гэхдээ өнөөдөр энэ Хөшөөтийн уурхайд үйл ажиллагаа эрхэлдэг Мон Эн ко гэж компани татвар дээр асуудалтай байгаа. Тэрийгээ зарим талаар хүлээн зөвшөөрөөд тэр татвараа тодорхой хугацаагаар хойшлуулж төлье гэж байгаа. Гэвч Татварын байгууллагаас дансыг нь хаасан. Ямар ч үйл ажиллагаа явахгүй байгаа. Монгол Улсын Засгийн газар нүүрсээ гаргая гэдэг ийм бодлого хаа сайгүй явуулж байна. Гэтэл энэнээс болоод тэр уурхайн үйл ажиллагаа зогсоод дээрээс нь орлого нь

багасаад тэр чинь манай Ховдод тодорхой хэмжээний орон нутагт 10 гаруй тэрбум төгрөг оруулдаг ийм одоо улсын төсөвт чинь маш их мөнгө оруулдаг.

Дээрээс нь орон нутагт 10 тэрбум төгрөг, тонн тутмаас нэг доллар өгч төлдөг. Ийм компани байгаа. Энэ компанийг дагаж нийтдээ мянга хэдэн зуу гаруй жолооч дээрээс нь 3 мянга гаруй өрх энэ Хөшөөтийн уурхайгаас амьдардаг Ховдын эдийн засагт маш их нөлөөтэй ийм компани байгаа. Тэгээд энэ 3 сараас хойш ерөөсөө мөнгө төгрөгийн гүйлгээ гарахгүй үүнээсээ болоод үйл ажиллагаа нь зогсчихсон учраас энэ компанийн хүсэлтийг танд хүргүүлж байна. Одоо ингээд тодорхой хугацаагаар хойшлуулаад тодорхой төлбөрөөр төлье гэж байна шүү дээ. Тэрэн дээр нь үйл ажиллагааг явуулж өгөөд тэр маш их олон ААН-үүд Хөшөөтийн уурхай үйл ажиллагаа явуулдаг тэд нарын үйл ажиллагаа нь мөнгө нь орж ирэхгүй болохоор дахиад татварын байгууллага нь нөгөө нэг хэдэн бараг хэдэн 100 компанийн үйл ажиллагааг бас дахиад дансыг нь хаах замаар маш хүндрэл учруулж байна аа.

Тийм учраас энэ дээр Жавхлан сайд тодорхой арга хэмжээ авч өгөөч гэдэг ийм ард иргэдийн хүсэлтийг хүргэж байна. Саяхан Амарбаясгалан дарга болон бид нарыг хөдөө орон нутагт ажиллаж байхад Хөшөөтийн уурхайн жолооч нар зам хааж байгаад бид нарын үйл ажиллагаанд саад болох гэх хүртлээ тэмцэж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр манай Амарбаясгалан дарга энэ талаар тодорхой мэдээлэл байгаа. Тэгээд энэ дээрээ шуурхай шийдвэр гаргаж өгөөч гэж хүсэж байна. Та нэг хариулж өгөөч.

**Б.Пүрэвдорж:** Минутагд нь үндсэн үг нь орсонгүй. Пүрэвдорж гишүүн гаргасан саналаа татаж байгаа. Энэ өөрөө бас гаргаж санал хураалгах боломжгүй байсан санал гэдгийг би түрүүн хэлсэн. Хөндөгдөөгүй заалтыг хөндсөн.

Хоёр Шадар сайдын эрхлэх асуудлыг хооронд нь хольж хутгаж явсан тохиолдол гарсан байна лээ.

Тэгэхээр 2 дахь саналыг бол хураалгах боломжгүй байгаа. Сая хэн Жавхлан сайд хариулт өгөх боломжгүй дэгээрээ тийм боломж байхгүй. Хөшөөтийн уурхай дээр асуудал үүссэн байна лээ. Сая амралтын өдрүүдээр Улсын Их Хурлын дарга, дэд дарга, ЗГХЭГ-ын дарга Бямбацогт сайд, Болормаа гишүүн, Чойжилсүрэн сайд тэргүүтэй хүмүүс очиж энэ Халзан бүргэдэйн асуудлаар ард иргэдтэй уулзалт хийсэн. Тэнд энэ Хөшөөтийн уурхай дээр туслан гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг тээврийн жолооч нар сүүлийн 3 сар цалингаа авч чадаагүй. Шалтгаан нь Хөшөөтийн уурхайн дансыг хаасан учраас туслан гүйцэтгэдэг компаниудын ажилчдын цалинг олгохгүй байна гэдэг асуудал хөндөгдсөн.

Тэгээд тэдгээр хүмүүст бол салбарын яамнаас хариуцаж байгаа хүмүүсийг явуулж ойрын хугацаанд уулзуулъя гэдэг зүйлийг бол бидний зүгээс хэлсэн. Ер нь энэ орон нутгийн түвшинд ялангуяа энэ экспортын дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийн нөхцөл байдал дээр нухацтай хандаж байхгүй бол төсвийн орлого тасалдаж байгаа экспорт буурч байгаатай холбоотой иймэрхүү төрлийн асуудлууд байхыг үгүйсгэхгүй юм байна лээ.

Тэгэхээр Сангийн сайд энэ дээр анхаарч ажиллаарай гэдгийг хэлье ээ.

Хоёр дахь санал татагдлаа.

ТББХ-ны дэмжээгүй санал.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн хууль тогтоомж Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих асуудал гэснийг хууль тогтоомж, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг Засгийн газрын биелэлтэд хяналт тавих асуудал гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Санал хураалт.

50 гишүүн буюу 50.1 хувиар санал дэмжигдлээ.

2.Засгийн газар дахь Хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

ТББХ-ны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 3.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

3.4.Энэ хуулийн 3.1-д заасан этгээдээс хууль Улсын Их Хурлын бусад шийдвэр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Ерөнхийлөгчийн зарлиг Засгийн газрын тогтоол, захирамж, хурлын тэмдэглэл, тэмдэглэлийг хэрэгжүүлэхэд хяналт тавих шаардлага ажиллагаанд энэ хууль үйлчилнэ ээ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж. Бөхчулууны Пүрэвдорж ТББХ-ны дэмжсэн саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

21 гишүүн буюу 21.4 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

2 дугаар зүйл. Засгийн газар дахь Хяналтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтын Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны даргаас гэснийг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргаас гэж 11 дүгээр зүйлийн гарчиг мөн зүйлийн 11.1, 11.3 дахь хэсэг 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хороон даргын гэснийг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргын гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг 17 дугаар зүйлийн зүйлийн 17.1.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.3 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны даргад гэснийг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын даргад гэж 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсгийн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга гэснийг Монгол Улсын сайд ЗГХЭГ-ын дарга гэж тус тус өөрчилсүгэй.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж.

Санал хураалт.

Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

29 гишүүн буюу 29.6 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

ТББХ шууд хуралдаад эргэж эцсийн хэлэлцүүлгийг оруулж ирэх хэрэгтэй. Тэгээд хэлэлцэж байгаа асуудлуудын дундуур эцсийн хэлэлцүүлгийг оруулж хэлэлцэж өнөөдөрт нь ажлын цагт багтааж баталж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Засгийн газраас цаг хугацаатай асуудлуудыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр хүсэлт тавьсан байгаа.

15.23 цаг

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Х.Тэмүүжин:** Монгол Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн 20 дугаар зүйлд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална аа. 25 дугаар зүйлийн 1-д Улсын Их Хурал Төрийн дотоод гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх мөн зүйлийн 1.8-д хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах онцгой бүрэн эрхтэй гэж заасан. Бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор Улсын Их Хурал Байнгын хороо болон дэд хороодоор байгуулан ажилладаг.

Монгол Улсад үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тагнуулын байгууллага, зэвсэгт хүчин, харин хүний эрхийг хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор хууль сахиулах болон мөрдөн шалгах ял эдлүүлэх чиг үүргийн байгууллагууд гүйцэтгэх ажил буюу мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулж байна аа. Гүйцэтгэх ажил мөрдөн шалгах нууц ажиллагаа нь өндөр түвшинд нууцлал шаарддаг тул эдгээр байгууллагууд үйл ажиллагаагаа төрийн бусад байгууллагатай адилаар нээлттэй тайлагнах боломжгүй байдаг аа.

Нээлттэй, тайлагнах боломжгүй байдал нь энэ байгууллагуудад явуулж буй гүйцэтгэх ажил, хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэх, хүний эрхэд хууль бусаар халддаггүй эсэхэд бүрэн дүүрэн эргэлзээ тайлах, хариулт авах, Улсын Их Хурлын хяналтаас гадна байх үндэс болохгүй ээ.

Тиймээс гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиг үүргийг оновчлох хэрэгцээ нийгмийн шаардлага өдрөөс өдөрт өсөн нэмэгдсээр байна. 2017 оны 5 сарын 18-нд батлагдаж батлагдаж шинэчилсэн найруулгаар ЭХХШТХ-аар мөрдөн шалгах нууц ажиллагаа хэмээх эрх зүйн ойлголт бий болж гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор нууц далд аргаар явуулах зарим төрлийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх арга хэрэгслийг хуульчилсан.

Ингэснээр уламжлалт гүйцэтгэх ажил гэх ойлголтын хүрээнд явагддаг байсан олон төрлийн ажиллагаа гэмт хэргийг илрүүлж нотлох хууль ёсны арга хэрэгсэл болсон нь байна аа. Харин үүнтэй холбоотойгоор мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт зохицуулалт тодорхой бус үлдэж гадаад бодлого аюулгүй байдлын талаас гүйцэтгэх ажлыг харсан уламжлалт 30 жилийн хандлага Улсын Их Хурлын хяналт түүний дотор хүний эрхийн хяналтын зохион байгуулалтыг оновчгүй үр нөлөөгүй гажуудуулсан байдалтай болгожээ.

Хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх ял эдлүүлэх ажиллагаан дахь гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааны хуулийн биелэлтийг хянах асуудлыг Мэргэжлийн Байнгын хороо болох ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд хамааруулж тусад нь Улсын Их Хурлын хяналтын тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дэд хороо байгуулах үндэслэл шаардлага үүссэн гэж үзэж байна аа. Хуулийн төсөлд Монгол Улсын үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн 8-д заасан хууль Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийг Хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх ял эдлүүлэх ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хууль сахиулах ажиллагааны Тусгай хяналтын дэд хороог ажиллуулахаар тусгалаа.

Тус дэд хороо байгуулагдсанаар гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийг нарийвчлан тагнуулын болон цэргийн тагнуулын байгууллагын явуулсан гүйцэтгэх ажилд тавигдах Улсын Их Хурлын хяналтыг Аюулгүй байдал, гадаад бодлого, байнгын хорооны бүрэлдэхүүнд ажиллах Тусгай хяналтын дэд хороо, хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх, ял эдлүүлэх ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх нууц мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавигдах Улсын Их Хурлын хяналтыг ХЗБХ-ны бүрэлдэхүүнд ажиллах Тусгай хяналтын дэд хороо хэрэгжүүлэх зохицуулалтыг хуульчилна аа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулсантай холбоотойгоор Цагдаагийн Цэргийн албаны тухай хууль болон Авлигын эсрэг хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулна аа.

Энэхүү хуулийн төслийг баталснаар хоорондоо эрс ялгаатай үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор явуулдаг тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажил болон хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явагддаг. Мөн энэ

хүрээнд ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэг гүйцэтгэх ажлыг буюу мөрдөн шалгах ажиллагааны нууцад тавигдах парламентын хяналтын ялгаатай эрх зүйн дэглэм хяналтын оновчлогдсон тогтолцоо бүрдэнэ ээ.

Хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулдаг гүйцэтгэх ажил мөрдөн шалгах нууц ажиллагаа нь ял эдлүүлэх ажиллагааны явцад хэрэгжүүлж буй гүйцэтгэх ажилд парламентын хяналтыг Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд цогц байдлаар хэрэгжүүлснээр Үндсэн хуулиар иргэнд олгогдсон эрх, эрх чөлөөг хамгаалах, парламентын хяналтын механизмыг сайжруулах, парламентын ардчилал, парламентад ёсны тогтолцоо төлөвшихөд чухал үйл хэрэг болно.

**Д.Амарбаясгалан:** Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Э.Болормаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүжин нарын 3 гишүүнээс 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хууль сахиулах гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор явуулдаг гүйцэтгэх ажил, нууц мөрдөн шалгах ажиллагаа, ял эдлүүлэх ажиллагааны явцад хэрэгжүүлж байгаа гүйцэтгэх ажил парламентын хяналтыг Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд цогц байдлаар хэрэгжүүлснээр Үндсэн хуулиар иргэнд олгогдсон эрх чөлөөг хамгаалах парламентын хяналтын механизм бүрдэнэ гэж үзсэн байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурлын бүрэлдэхүүнд Хууль сахиулах ажиллагааны Тусгай хяналтын дэд хороо байгуулагдаж төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд төсөлд иргэдийн оролцоог хангах санал авах зорилгоор Улсын Их Хурлын D parliament.mn цахим системд байршуулсан болно оо.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир тус дэд хороог байгуулах та Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос санал авсан эсэх талаар Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа хуулийн төслөөр тогтолцооны өөрчлөлт хийх боломж бүрдэх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл хуулийн төслөөр гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх чиг үүрэг нь ХЗБХ болон түүний дэргэдэх шинэ дэд хороонд харьяалагдах эсэх бусад чиг үүрэг нь Одоо байгаа Байнгын хороонд хамаарах эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд Улсын Их Хурал мэдээлэл авч хяналт тавих талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Хуулийн төслөөр хүний эрхтэй холбоотой хуулийн хэрэгжилтэд хяналт тавих боломж бүрдэх талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл Гүйцэтгэх ажил нэрээр хүний эрхийг зөрчихтэй тэмцэх Улсын Их Хурлын хяналтыг

хэрэгжүүлэх үр дүнтэй бүтэц бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр Улсын Их хурал бүрэн эрх хянан шалгах чиг үүргээ сэргээж, хүний эрх зөрчигдөж, хяналт алдагдаж буй нөхцөл байдлыг залруулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос санал авах талаар санал гаргасан болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 47.4 хувийн саналаар, Хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 15.8 хувийн саналаар, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 36.8 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар ТББХ-ны санал дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

Нийт 4 гишүүн асуулт асуухаар ирүүлсэн байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууя.

**С.Ганбаатар:** Эрхэм хүндэт гишүүдийн амар амгаланг айлтгая аа.

Монгол орон парламентын засаглалтай гэж цээжээ дэлдэж ярьдаг ч гэсэндээ парламентын засаглал, гүйцэтгэх засаглал, шүүх засаглалынхаа хормой дор орчихсон ийм арчаагүй байдалд байгаа. Энэнээс аварч, хамгаалж, парламентын дархлааг бий болгохын төлөө энэ хуулийг би дэмжиж байна. Та нар бодоод үз. Одоо миний ойлгосноор 17 гишүүн шонд өлгүүлээд цагдаад шалгуулаад явж байгаа. Энэ цагдаажсан улс болсон. Энэ тэнэглэлийг зогсоохын тулд бид энэ хуулийг дэмжээсэй гэж хүсэж байна. Парламентыг өөрсдийгөө яриагүй. Би олон жил мөрдүүлж, шалгуулж, хонгилдуулж зовсон. Өнөөдөр залуу гишүүд олон олон ирээдүйд орж ирэх гишүүдийн дархлааг ард иргэдийн зовлон зүдгүүрээ яг сэтгэлдээ бодож байгаад чөлөөтэй ярьдаг байх тэр эрхийн төлөө парламентын дархлааны төлөө би өнөөдөр ярьж байна. Та нар бодоод үз дээ эрх баригчид аа.

Өнөөдрийн энэхүү хуулийн цаад үзэл баримтлал парламент засаглал буюу Үндсэн хуулиа Ерөнхийлөгчийн засаглалаас шүүх засаглалаас хамгаалъя гэдэг ийм санаа бодлоор би дэмжье гэсэн байр суурьтай байгаагаа хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

2 гишүүн асуулт асуугаад, 2 гишүүн үг хэлээд санал хураалттай байгаа. Тэгэхээр Төрийн байгуулалт руу орсон байгаа гишүүдийг санал хураалт дээр орж ир гэж зар өгөөрэй.

Номинчимэг гишүүн байхгүй байна. Байнгын хороо руу орчхож, Батын Батбаатар гишүүн алга байна. Байнгын хороо руу орсон байна Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу дэмжсэн дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. Нэг гишүүн байна.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн индэрт урьж байна. 1 дүгээр индэр.

**Б.Энхбаяр:** Дэлхийн улс орнуудад энэ гүйцэтгэх ажил гэж нэрлэгддэг зүйлд парламент нь хэрхэн хяналт тавьдаг вэ гэдэг асуудал олон жилийн турш яригдаж байгаа юм. Энэ дэлхийн улс орнуудад анх 1939 оны сүүлээр Германы нууц цагдаагийн алба буюу бидний мэдэхээр Гистапа гэж байгууллага парламентын буюу ард түмний хяналтаас гарч улс төрийн шийдвэр гаргах ийм эрх мэдлийн хар гайгаар дэлхийн 2 дугаар дайнд түлхэн оруулж улмаар Герман улсыг ард түмнийг үлэмж хохироосон гэж үзсэний үндсэн дээр анх дэлхий нийтэд энэ нууц цагдаагийн албанд хэрхэн парламентын хяналтыг хийх вэ гэдэг асуудал яригдаж хууль тогтоомжууд шийдэгдсэн байдаг. ОУПХ-ны Женевт төвтэй нууц мөрдөн шалгах ажиллагаанд хэрхэн парламентууд хяналт тавих вэ гэдэг байгууллагаас Монгол Улсад зөвлөмж гаргасан байдаг. Дэлхийн улс орнуудад энэ чиглэлээр хийгдсэн судалгаа төдийлөн их байсан бол миний бие 2020 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдоод 9 сард нь Парламентын судалгааны хүрээлэнгээр анх түрүүн парламентын хяналтын асуудлаар нь судалгаа захиалгат судалгаа хийж үр дүнг авсан байдаг юм.

Улмаар ХЗБХ-ны даргаар 2023 оны 7 сард ажиллаж байх үедээ Герман улсын энэ чиглэлийн парламентын хороо болон Женевт төвтэй саяын байгууллагад судлаачдын баг явуулж бусад улс орны хууль тогтоомжуудыг орчуулж улмаар өөрөө ХЗБХ-ноос ажлын хэсэг гарган гүйцэтгэх үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай бие даасан хуулийн төслийг боловсруулж дууссан байдаг юм аа.

Харамсалтай нь өнгөрсөн парламентын үед энийг батлуулж амжаагүй. Энэ хяналт гэдэг зүгээр нэг Байнгын хороо юм уу, Дэд хороог нэгтгэж салгаад энэ асуудал шийдэгдэхгүй. Энийг хууль санаачлагч өөрөө мэдэж байгаа. Хамгийн гол нь энэтэй холбоотой процессын шударга ёс буюу илүү энэ асуудлыг процессжуулж байж энэ хяналт тодорхой болно. Хяналт тодорхой процесс байхгүйгээс улбаалж үүсэж байсан би ганцхан жишээ хэлье. Улсын Их Хурлын гишүүнийг тагнуулын

байгууллагаас хууль бусаар мөрдөн шалгасан байж болзошгүй гэх асуудал олон жилийн өмнө үүсэж байсан. Улмаар тухайн хууль бусаар шалгагдаж байсан гэх гишүүн өөрөө Улсын Их Хурлаас ажлын хэсэг ахалж улмаар хавтаст хэргийн нууц, маш нууцын зэрэглэлтэй материалтай өөрөө танилцсан асуудал гарч байсан. Энэ юу хэлж байна вэ гэхээр энэ чиглэлийн эрх зүйн орчин нэн тодорхой бус байгаа.

Тийм учраас энэ асуудлыг цогцоор нь Улсын Их Хуралд суудалтай олон намын төлөөллүүд дээр хамтарч саяын хэлсэн өөрийн боловсруулсан байгаа хуулийг цогцоор нь шийдэх хүрээнд би энийг дэмжихгүй байгаа. Энэ асуудлыг 2 намын бүлгийн даргад миний бие өчигдөр тавьсан.

Ирэх 7 хоногийн Даваа гаргийн Байнгын хороодын хуралдаанд олон улсад энэ чиглэлийн парламентын хяналт ямар байдаг вэ? Женев төвтэй саяын ОУБ-аас ямар зөвлөмж өгсөн, Германд батлагдаж байсан хамгийн сүүлд энэ хяналт ямар байдаг вэ гэдэгтэй холбоотой хийсэн хуулийн төсөл болон судалгааны тайланг 20 минутад багтааж танилцуулах ийм хүсэлтийг тавьсан. МАН-ын бүлгийн дарга зөвшөөрсөн байгаа. Бүлгийн хуралдаанд танилцуулна. АН-ын бүлгийн даргад мөн энэ асуудлыг танилцуулсан байгаа.

Тийм учраас асуудлыг зөвхөн Дэд хорооны асуудлыг 2 салгаснаар шийдэх гэж байгаа юм шиг өнгөц дүгнэлт өгч бас мэдээлэл дутуу байдлыг залруулах үүднээс миний бие нэлээн тодорхой мэдээлэл өгч байгаад энэ асуудлыг хамтдаа шийдье гэсэн ийм хүсэл эрмэлзлээр энэ хуулийн төслийг дэмжихгүй байгаа гэдгээ илэрхийлж байна аа. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хороон дээр хэлэлцэгдээд энэ чинь. Гишүүд үг хэлж дууссан байна.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Гишүүд ирцдээ бүртгэгдье. Ирцдээ бүртгүүлье. 99 гишүүн өнөөдөр ирчихсэн л бүртгэлтэй одоогийн байдлаар 40 гишүүн байна. Гишүүд ирцдээ бүртгэгдье. 61 62 гишүүн бүртгэгдсэн байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Ирцэд бүртгэгдээгүй гишүүн байна уу? Уянгахишиг гишүүн бүртгүүлье, хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт.

27 гишүүн дэмжээд санал дэмжигдсэнгүй.

Тэгэхээр санал босож ирж байна гэсэн үг.

Хамт өргөн мэдүүлсэн Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт 18 гишүүн дэмжсэн байна. Дэмжээгүйг дэмжсэнгүй.

3.Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

20 гишүүн буюу 20.2 хувиар Байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэнгүй ээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

15.45 цаг

Дараагийн асуудалд оръё.

**Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл танилцуулна аа. Индэрт урьж байна.

**О.Цогтгэрэл:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Парламент ёсны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хууль тогтоох, төлөөлөх, хянах, хянан шалгах гэдэг тодорхой 3 чиг үүрэг байдаг аа. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурал хууль тогтоох төлөөлөх бүрэн эрхээ тодорхой түвшинд хэлбэржүүлэн тогтоосон гэвч хянан шалгах бүрэн эрхээ үр нөлөө багатай хэрэгжүүлж ирснийг судлаачид тэмдэглэсэн байдаг аа.

Тиймээс Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлт өөрчлөлтөөр эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах зорилгоор Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг шинэ шатад гаргах зарчмын өөрчлөлт хийсэн Улсын Их Хурал Хянан шалгах бүрэн эрхээ 7 арга замаар хэрэгжүүлэхээр хуульд заасны нэг нь Хянан шалгах түр хороо байгуулах юм аа. Түр хороо байгуулах нь иргэдийн мэдэх эрхийг хангах хамгийн гол түлхүүр бөгөөд энэхүү хяналтыг үр дүнтэй нээлттэй хэрэгжүүлэх нь маш чухал юм аа. Иймээс Монгол Улсын үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүдийн 4-ний 1-ээс доошгүй хүн Хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гэж Монгол Улсын Их Хурлын хянан шалгах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 2 дахь Түр хорооны

бүрэлдэхүүнийг УИХ дахь олонх цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч түр хорооны бүрэлдэхүүний 3-ны 1-ээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх Улсын Их Хурал дахь нам эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална гэж. Түр хороог байгуулах тэр тусмаа цөөнхийн төлөөллийг түлхүү хамруулах тухай зааж өгчээ.

Олон улсын парламентын үйл ажиллагаанд мөрдөн шалгах нээлттэй сонголт хийх нь нэг жишиг болсон арга хэлбэр юм аа. Энэ нь тухайн асуудалд холбогдох албан тушаалтан, гэрч, шинжээчийг Улсын Их Хурлаас дуудаж тайлбар мэдүүлэг авах, тусгай шинжээч, хянан шалгагч томилох замаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тухайн тодорхой асуудлыг тал бүрээс нь шинжлэн судалж бодит мэдээллийг ард түмэнд ил тод болгоход маш чухал ач холбогдолтой.

Гэвч өнөөгийн хэрэгжиж байгаа хуулиар Улсын Их Хурлын олонхыг бүрдүүлж буй улс төрийн хүчин Хянан шалгах түр хорооны олонхыг бүрдүүлэхийн зэрэгцээ түр хорооны даргыг олонхоор сонгож байгаа явдал нь Түр хорооны нөлөөг үр нөлөөг үлэмж хэмжээгээр бууруулж байна аа. Иймд түр хорооны даргыг сөрөг хүчнээс буюу цөөнхийн төлөөллөөс ажиллуулж чадвал хяналтын энэ чухал хэрэгслийг үр дүнтэй болно гэж болгоно гэж Улсын Их Хурлын 26 гишүүн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг санаачилсан.

Өнөөгийн хэрэгжиж буй хуулийн 33 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт Түр хорооны даргыг сонгох зохицуулалтыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн бүлгийн төлөөллөөс хэрэв цөөнхийн бүлэг байхгүй бол цөөнхийн төлөөллөөс сонгоно гэж уг хуулийн өөрчлөлтөд тусгасан энэ өөрчлөлтийг батлуулснаар түр хорооны даргыг сөрөг хүчнээс буюу цөөнхийн төлөөллөөс ажиллуулдаг болж чадвал гэнэтийн нэн чухал хэрэгслийг үр дүнтэй ашиглах эрх баригчдыг ард иргэдтэйгээ хамтран цөөн хянах нөхцөл бүрдэж парламент ёс нотлогдоход томоохон дэвшил болох нь гарцаагүй гэж үзсэн.

Мөн Түр хороо байгуулах түр хорооны бүрэлдэхүүнийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар олонхын саналаар шийдэх учраас парламентын олонхын оролцоо чухал хэвээр үлдэхийг дурдах нь зүйтэй.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт зардал гарахгүйгээр хяналт бүрэн хэрэгжих Түр хорооны үйл ажиллагаа үр дүнтэй явагдахад чухал нөлөөтэй зэрэг олон талын ач холбогдолтой хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг эрхэм гишүүд та бүгдээс хүсье ээ.

**Д.Амарбаясгалан:** Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурлын дэд дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүнээс 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг ТББХ 2025 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын хууль Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулснаар Улсын Их Хурлын хянан шалгах арга хэрэгслүүдийн нэг болох түр хороог илүү үр дүнтэй болгоход ач холбогдолтой гэж үзсэн болно оо. Хуулийн төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын d.parliament.mn цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Хянан шалгах түр хорооны даргыг цөөнхийн бүлгээс томилох зохицуулалтын ач холбогдол үр дүнгийн талаар мөн Улсын Их Хурлын гишүүн санаачилга гарган түр хороо байгуулах даргалах манлайлж ажиллах боломжийг хаах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг Хянан шалгах түр хороог цөөнхийн бүлгээс даргалах асуудлыг судалсан олон улсын туршлагын талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Э.Болормаа төсөл нь хэт явцуу харилцааг зохицуулсан бөгөөд Хянан шалгах түр хороонд орж ажиллах гишүүдийн эрхийг болзошгүй тул төслийг дэмжихгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмааг Хянан шалгах шалгах түр хороог санаачилсан гишүүн даргалах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Л.Гантөмөр Улсын Их Хурлын хяналтын механизмыг улс төрөөс ангид, бодит үр дүнтэйгээр хэрэгжүүлж, сөрөг хүчинд хяналт тавих эрх мэдлийг олгосноор засаглалын тэнцвэр ардчилал тогтоох талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатар Монголын парламентын ардчиллыг хамгаалж хяналт шалгалт олонх цөөнхийн эрх чиг үүргийг ойлголцож ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг парламент ёсны зарчимд нийцэхийн тулд хяналт шалгалтын түр хорооны даргыг цөөнх заавал удирдах ёстой гэхээс илүү уян хатан нарийвчилсан зохицуулалт хийх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл олон цөөнхийн зарчмыг парламент ёсны үзэл баримтлалын хүрээнд ойлгож хяналтын түр хороог үр ашигтай ажиллуулах зохицуулалт бөгөөд хэлэлцүүлгийн түвшинд засах боломжтой талаар саналаа илэрхийлсэн болно оо.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх 42.1 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй болно. Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууя. Асуулт асууна аа.

Нийт 9 гишүүн нэр ирсэн байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн.

**П.Сайнзориг:** Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг өнгөрсөн парламент маань баталсан. Энэ хуулийг амьдруулах гээд зөв практик жишиг тогтоох гээд бас өнгөрсөн цаг хугацаанд зарим зүйлүүдийг нэлээн хэрэглэж туршиж үзлээ бид нар. Мэдээж алдаа оноо энийг засаж залруулах, сайжруулах зүйлүүд харагдаад байгаа. Ний нуугүй л хэлэхэд. Баярмаа гишүүн маань түрүүн байнгын хороон дээр худлаа хэлж байсан л даа. Энэ Сайнзориг гэдэг хүнээр шалтаг хэлээд хяналт шалгалтыг сонсгол хийх асуудлыг хойшлуулж барьсан гээд.

Баярмаа гишүүн маань өөрөө алдаа гаргачихсан юм. Тэгээд Тэмүүжин гишүүн бид нар зөвлөж байж энэ бичгийг нь солиулж авсан байхгүй юу. Хүний эрхийн сонсгол явуулъя гээд ерөнхий юм өгчихсөн гэж байтал Хяналт шалгалтын хуулиар чинь болохоороо сэдвээ сонгох ёстой байсан. Сэдвийг нь бид нар тантай ярилцаж байж сэдэв тогтоосон журмын асуудал байсан. Баярмаа гишүүнээ би үгээ хэлээдэхье. Та тэгэхээр ингэж гөрдөж болохгүй ээ.

Энэ өөрөө эргээд та ерөнхий сэдвээ сонгоогүй ерөнхий байдлаар өгчихсөн учраас энэ асуудлууд гарсан юм шүү. Тэгэхээр олон нийтэд би энэ залруулга хэлэх нь зөв байх.

Хоёрдугаарт яах вэ зүгээр Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх байгаа. Аливаа энэ хянан шалгалтын чиг үүрэг бүхий түр хороонд орж ажиллах тэдгээрийг даргалах, сонсголыг зохион байгуулах даргалах ч гэдэг юм уу тэгэхээр энэ зөвхөн энэ асуудлыг зөвхөн цөөнх гэхгүйгээр түрүүн Пүрэвдорж дарга санал дүгнэлт уншлаа. Би анзаарсангүй. Хэн гишүүний санал гэхчэв. Уян хатан байдлаар зохицуулах бололцоотой юу гэж санал гаргасан байна лээ.

Хэрэвзээ энийг ингэж болохгүй юу? Өөрөөр хэлэх юм бол уян хатан гэдэг нь тэр хяналт шалгалтыг санаачилж байгаа эсвэл тэр сонсголыг санаачилж байгаа хүмүүс нь дундаасаа саналаа холбогдох Байнгын хороон руу ч юм уу чуулган руу оруулаад асуудлаа шийддэг ч юм уу цөөнх гэдэг байдлаар явахаар өөрөөр хэлэх юм бол олонхын бүлэгт байгаа гишүүдийн бүрэн эрх хязгаарлагдах гээд байгаа байхгүй юу. Үндсэн хуулиараа бид нар Улсын Их Хурлын тухай хуулиараа энэ чинь ард түмний төлөөлөл. Тэгээд энэ дээр оролцох эрхтэй. Бид нар баталсан болон баталсан энэ бодлого шийдвэрийнхээ араас хяналт тавих эрхтэй байхгүй юу.

Тэгэхээр энэ зүйлүүд хэрэв зээ магадгүй би яаж санал хураагдахыг нь мэдэхгүй байна. Дэмжигдээд хэлэлцэх эсэх нь шийдвэл ажлын хэсэг гараад явбал уян хатан байдлаар гэдэг тэр саналыг авч үзээч. Энэ санаачилгыг гаргаж байгаа гишүүдээсээ даргалдаг ч юм уу иймэрхүү байдлаар анхаарч авч үзээрэй. Хэт цөөнх олонх гээд ингээд биш энэ чинь бүгд гишүүд оролцоотой байх ёстой. Гишүүдийн үүрэг байхгүй юу. Энэ хуулийг хяналт тавих эсвэл хэрэг бодлогууд баталсан бодлогын араас хяналт тавих, сонсгол зохион байгуулах.

Тэгэхээр энэ зүйлүүдийг анхаарч өгөөрэй гэдэг зүйл байна. Тэгээд хууль санаачлагч гишүүн энэ дээр ямар байр суурьтай байгаа вэ? Энийг ийм уян хатан байдлаар зохицуулах ч гэдэг юм уу ийм зүйлээс нь та харж үзсэн тал бий юу?

**Д.Амарбаясгалан:** Цогтгэрэл дарга хариулт өгөх үү? Ер нь Сайнзориг гишүүний асууж байгаа зөв юм байгаа юм. Уян хатан байхгүй бол энэ сонсголыг, хяналтын сонсголыг санаачилсан этгээд нь сонсголоо идеологийнх нь хувьд өөрөө

удирдах боломжгүй байгаа байдал нь яг өнөөдөр энэ хуулийн төсөл боловсруулагдаж орж ирэх үндэслэл болчхоод байгаа юм. Тэгээд миний хувьд ч гэсэн одоо өчигдөр энэ ТББХ хууль санаачлагч нартай санал солилцсон. ТББХ-н дээр гарсан саналыг бол дэмжсэн. Тэр нь бол яг Сайнзориг гишүүний хэлж байгаагаар санаачилсан этгээд нь өөрөө энэ сонсголоо удирдан зохион байгуулдаг байх тэр боломжийн зохицуулалтыг нь хийж өгөх нь энэ хуулийн өөрчлөлтийн хамгийн чухал зүйл байх юм гэж ингэж үзэж байгаа юм.

Цогтгэрэл дарга хариулт өгье.

**О.Цогтгэрэл:** Үндсэн хуулийн 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг үр нөлөөтэй болгох асуудал хөндөгдөж 21 онд Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль анхдагч хууль өргөн баригдсан байдаг. Хуучин Дэгийн хуулиар энэ сонсголын асуудал зохицуулагдаж байсан юм байна лээ. Тухайн үед өргөн баригдсан хууль дээр одоо байгаа энэ үзэл баримтлалын түвшний агуулга бас тухайн үед өргөн баригдаад хэлэлцүүлгийн явцад өөрчлөгдөөд одоогийнхоор ингээд батлагдаж байсан.

Тэгээд нөхцөл байдал дээр өнгөрсөн 3 жилийн хугацаанд 2022 он, 2023 он, 2024 онд 7 удаагийн хяналтын сонсгол явагдсан байна лээ. 7 удаагийн хяналтын сонсгол.

Тэгээд энэ хяналтын сонсголуудын үр дүн үр нөлөөг олон зүйлүүдийг ингээд харахад дийлэнх олонх нь жишээ нь хамгийн сүүлд Ногоон автобусны сонсгол гээд баахан юм болж байгаад л хийгдэж байсан. Тэгээд л тэр сонсгол юу болоод өнгөрснийг олон нийт юу ч мэдээгүй. Зүгээр бүх сонсголыг бүгдийг нь үгүйсгэж байгаа юм биш. Тэгэхээр тийм учраас энэ тодорхой шаардлагын хүрээнд эрх баригчдыг хянах гэдэг энэ олонхыг хянах гэдэг чиг үүрэг илүү чухал юм гэдэг хүрээнд ингээд агуулга өргөн баригдсан.

Яг өчигдөр Байнгын хороон дээр Сайнзориг гишүүний ярьж байгаа саналын хүрээнд Сандаг-Очир гишүүн санал гаргасан. Энийг бид нар Байнгын хороон дээр болоод Байнгын хорооны дараа уулзаж ярилцсан. Агуулгын хүрээнд энэ бол илүү уян хатан илүү яг Улсын Их Хурлын гишүүдийн олонх, цөөнх гэлгүй бүрэн эрхэд илүү нийцсэн нэгэнт 32 гишүүнээс 4-ний 1 буюу 32 гишүүнээс доошгүй гишүүн өргөн барьж байгаа болохоор энэ асуудлыг цаашид энэ хүрээнд нь хэлэлцээд хэлэлцээд явахад өөрчлөөд явахад бүрэн боломжтой юм гэдэг дээр санал нэгдэж энэ зөв зүйтэй юм байна гэдэг дээр нэгдсэнийг танд хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвжавын Сайнзориг гишүүн тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Хууль санаачлагч гишүүн маань тодорхой ярилцаж болох уян хатан байх талын саналыг хэлж байгаад талархуштай байна.

Тэгээд энэ саналыг гаргасан Сандаг-Очир болон Номинчимэг гишүүнд талархаж байна.

Хэдүүлээ нөгөө түр хороо байгуулах 32-доо хүрэхгүй байх эрсдэлийг ч гэсэн цааш цаашдын парламент үлдээж болохгүй. Тэгэхээр илүү их нөгөө энэ зүйлийг мэдэрч байгаа, мэдээллээ цуглуулсан шаардлагыг нь харж чадаж байгаа тэр

гишүүд дотроосоо буюу санаачлагч гишүүд нь илүү авч явдаг. Энэ өнцөг рүүгээ явуулах дээрээ би хувь гишүүнийхээ хувьд адилхан саналтай байгаа шүү гэдэг зүйлийг хэлье. Цөөнх гэж нэг талдаа ингэж юу гэдэг юм туйлшрах шаардлагагүй гэж л үзээд байна.

Тэгэхээр энэ бас гишүүдийнхээ юу гэдэг юм нам харгалзахгүйгээр оролцох тэр боломжийг бид нар бүрдүүлж өгөөч гэдэг дээр хэлэлцэхийг шийдсэн тохиолдолд анхааръя гэдэг зүйлийг зарчмын хувьд хэлмээр байна аа.

**Д.Амарбаясгалан:** Баярмагнайн Баярбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Баярбаатар:** Гишүүддээ өдрийн мэнд хүргэе ээ. Цогтгэрэл даргын энэ санаачилсан хуулийг дэмжиж байгаа. Зарчмын хувьд бол зөв санал гэж би харж байгаа. Тэгэхдээ яг Сайнзориг гишүүний хэлсэн ер нь парламент гэдэг чинь ер нь өөрөө 1 дүгээрт зөвшилцөх, 2 дугаарт мэтгэлцэх гэсэн нэг ийм 2 зарчим дээр тулж байгаа юм.

Тэгэхээр бид нар өөрөө энэ ямар нэгэн байдлаар олонх цөөнх гэдэг байдлаар аль нэгнийхээ эрхийг хязгаарлах нь өөрөө буруу юм аа. Энэ нь өөрөө Үндсэн хуулийн зөрчил рүү дагуулчхаж магадгүй гэж харж байгаа учраас би бол хэлэлцэх эсэхийг нь дэмжээд тэгээд тэрний дараа ажлын хэсэг байгуулаад тэрэн дээрээ яг миний хувь гишүүний бодол бол сонсгол санаачилсан Улсын Их Хурлын гишүүн тухайн сонсголоо даргалдаг байвал их зөв юм байна гэж би бодож байгаа.

Яагаад гэхээр тэр санаачилж байгаа гишүүн нь өөрөө бүх агуулга, бүтэц, олон зүйлүүдээ асуудлуудаа мэдэж байгаа. Дээр нь өнөөдөр энэ 126 гишүүний хэн нь ч өнөөдөр энэ сонсголыг санаачлах эрх нь байж байгаа учраас энэ дээрээ нэг уян хатан явах нь зөв юм болов уу гэсэн ийм бодол байна.

Хэлэлцэх асуудлаас гадна манай Сайнхүүгийн Ганбаатар гишүүнтэй холбоотой асуудал байна аа.

Жоохон шүүмжлэлтэй хандахаас өөр аргагүй байдал үүсэж байна. Өнөөдөр энэ хууль хяналтын мөрдөн шалгах хянан шалгах энэ чиг үүрэгт Улсын Их Хурлын гишүүн парламентын гишүүн өнөөдөр нөлөөлөх ийм нөхцөл байдал үүссэн байна. Аль аль талаас нь харж үзлээ. Мэдээж өнөөдөр парламент, парламентын гишүүний эрх үүргийг бодолгүй яах вэ. Гэтэл өнөөдөр нөхцөл байдал эсрэгээрээ байна.

Дээр нь өнөөдөр энэ төрийн тэргүүн рүү их субъектив байдлаар ер нь хандаж байгаа. Яг энэ нотлогдсон болоод хандаад байгаа юм уу гэдэг асуудал. Үнэхээр төрийн тэргүүнд тийм үйл ажиллагаа явуулаад байна гэдгийг өнөөдөр мэдээд тэр хүн хандаад байгаа юм уу? Би бол тийм гэж бодохгүй байна. Тэгээд өнөөдөр Монгол Улсын парламентын гишүүн ийм ёс зүйгүй байдал гаргаж байгаа нь өөрөө надад жоохон харамсалтай санагдаж байгаа юм.

Монгол төр Монгол улсын парламент гэдэг нэг эрх үүрэг дотор, нэг эрх ашиг дотор явж байх ёстой гэж би хувь хүнийхээ хувьд боддог. Тэгээд энэ мэтчилэн иймэрхүү нөхцөл байдал нь өөрөө тийм ёс зүйгүй, увайгүй нэг ийм нөхцөл байдлыг үүсгээд байна уу гэсэн ийм нөхцөл байдал байгаа. Би зүгээр бусдын үзэл санаа үзэл бодлыг хүндэтгэх ёстой. Энэ миний үүрэг. Тэгэхдээ өнөөдөр энэ Монгол Улсын эрх

ашиг гэдэг бол нэг шүү дээ. Энийг тэгээд 1 нөхөр ингээд нэг янз бүрийн байдлаар буруу зөрүү лайв хийгээд ингээд бусниулаад алдагдуулаад байх нь өөрөө ер нь хир зохимжтой юм.

Би тэр нотолсон болоод л өнөөдөр нэр усыг нь дуудаж байгаад төрийн тэргүүний нэр усыг дуудаж байгаад хэвлэлийн хурал хийгээд лайв хийгээд байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Тэгээд тэр өөрт нь ямар ч хамааралгүй хүний гэрт нь хянан шалгах ажиллагаа явуулах гэж байхад тэрнийг нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг ашиглаж зогсоож байдаг.

Тэгээд олон нийтийг ингээд буруу зүйл рүү турхирч байгаа нь өөрөө энэ нийгмийг буруу зүйл рүү турхираад байгаа л ийм нөхцөл байдал ажиглагдаад байгаа юм л даа. Тэгээд энийг л цаашид байж болохгүй. Би Ганбаатар гэдэг хүнийг бол хувь хүнийхээ хувьд хүндлээд дэмжээд явдаг юм. Олон жил энэ Монгол Улсын төрд байсан хүн гэдэг дээр. Тэгэхдээ ийм ёс зүйгүй үйлдлийг нь ямар нэгэн байдлаар хаацайлж хамгаалах боломж байхгүй. Хэн нэгнийг хамгаалаад байгаа юм биш. Бид бүгд өнөөдөр парламентаараа Монгол Улсын эрх ашгийг хангаж хамгаалах үүрэгтэй гэдэг л ийм зарчим дээр би энэ үгийг энэ хариуцлагатай индэр дээрээс хэлье гэж бодож байна.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Үг хэлчихлээ. Баатаржавын Мөнхсоёл гишүүн асуулт асууя.

Асуулт бараг биш болох нь ээ. Зүгээр тодруулах гэж байсан одоо яг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн 33.8-д байгаа Түр хорооны тусгай шалгалтын сэдвээс нь хамааруулаад шаардлагатай гэж үзвэл түр хорооны даргыг түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн төлөөллөөс сонгоно гэдэг ийм заалт угаасаа байгаа.

Тэгээд яагаад энэ хуульд нэмэлт, өөрчлөлтийн талаар оруулах болов гэж асуух гэж байсан. Сая хурлын дарга өөрөө зорилгыг нь тодруулаад хэлчихсэн учраас дэмжиж байна гэж протоколд бичүүлье.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Батбаярын Жаргалан гишүүн үг хэлье.

**Б.Жаргалан:** Бид бол өнгөрсөн хугацаанд парламентын хяналт тэнцлийн тухай маш их ярьж байгаа. Тэгээд парламентын хяналтын чиг үүргийг энэ парламент сайжруулах ёстой гэдэг агуулгыг ч маш их ярьж байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд бол парламентын хяналт тавих механизмуудыг тодорхой тодорхойлсон байгаа. Тэгээд энэ хүрээнд энэ орж ирж байгаа өөрчлөлт бол энэ парламентын хяналт шалгалтын механизмыг илүү боловсронгуй болгоход чиглэсэн гэж харж байгаа. Гэхдээ сая гишүүдийн дурдаад байгаа тухайлах юм бол түр хороо байгуулах асуудлаар гарын үсэг зурсан гишүүд дотроосоо түр хороо даргалагчийг сонгох гэх зэргээр уян хатан зохицуулалт хийхийг дэмжиж байна аа.

Яг одоо байгаа хуулийн хүрээнд болохоор зөвхөн олонхын бүлгээс л даргалагчид томилогдоод байгаа юм. Тэгэхээр нөгөө зөвхөн олонхын бүлгээс даргалагчид томилогдохоор одоо энэ Улсын Их Хурал дээрх хяналтын үндсэн механизм чинь олонх цөөнхийн бүлэг байгаад байгаа шүү дээ. Тэгэхээр тэр олонх цөөнхийн хяналт алдагдаад байгаа гэж хараад байгаа юм. Тэгэхээр гишүүдийн хэлж байгаачлан түр хороог санаачилж байгаа гишүүдийн санаачилгаар тэр дундаас даргалагчийг олонх цөөнхийн бүлгийг харгалзалгүйгээр сонгох тэр боломжийг нээж өгнө гэдэг дээр бол байж болох асуудал гэж үзэж байгаа.

Тэгэхээр хэлэлцэх эсэх асуудал дээр энэ асуудлыг босгоод өгвөл дараа дараачийн хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй саналаар саяын саналыг оруулаад тэгээд энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын механизмуудаа илүү боловсронгуй болгох цааш цаашдаа энэ ялангуяа энэ хяналт шалгалтын түр хороодын үйл ажиллагааг илүү сайжруулах олон нийтэд илүү нээлттэй болгох тэгээд үр дүнг нь илүү тодорхой болгох асуудал дээр ахиц дэвшил гарна гэдэгт итгэж байгаа.

Баярлалаа. Асуулт байхгүй ээ.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн асуулт асууж үг хэлье.

**М.Мандхай:** Энэ хуулийг жоохон харлаа. Тэгээд ер нь бол энэ цөөнхийн төлөөллийг хуульчлан оруулсан зохицуулалт Үндсэн хууль дээр угаасаа байсаар байтал энэ тухайн Түр хороог цөөнхөөс даргална гэдэг нь яг хангалттай үндэслэл гэж дэмжигдэхгүй гэж харагдаж байна. Тэгэхээр өөрөөр хэлэх юм бол энэ Улсын Их Хурлын гишүүн олонхын эсвэл цөөнхийн ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална гэж хаана ч заагаагүй байгаад байгаа. Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааны үндсэн зарчим нь цөөнхийг бид нар хүндэтгэж олонхоороо жишээлбэл шийдвэр гаргах явдал тэ. Тэгэхээр түүнээс биш цөөнхийг хүндэтгэн дэмжиж байж дэмжинэ. Тэгээд гишүүд нь санал өгөх эрхээ хязгаарлагдах үндэслэл болохгүй гэж харж байна аа. Ийм ч байх ёсгүй тиймээ.

Тэгэхээр санал өгөх эрх гээд байгаа нь тухайн түр хороог хэн даргалах, хэн тухайн ажлыг авч явах нийцтэй байх вэ гэдгээс аль аль талаасаа хандаж бид нар шийдвэр гаргах эрхийг ярьж байгаа юм аа. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн 6-д Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонх нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ гээд заачихсан байдаг юм байна.

Тэгэхээр энэ Улсын Их Хурлын шийдвэр гаргах өөрөө процесс байгаад байгаа. Гэтэл Улсын Их Хуралд хамаарах бусад хорооны шийдвэр гаргалтад олонхын саналаар шийдвэрлэхгүй байх нь өөрөө Үндсэн хууль зөрчиж байгаа юм биш үү гэдэг асуулт тавимаар байна. Ямар хороо байхаас үл хамаараад тухайн асуудлыг олонхоороо шийднэ гээд бүр Үндсэн хуульд нь өөрөөр заагаагүй гэдгийгээ тодорхой заагаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр энэ чинь өөрөө Үндсэн хуулиа зөрчиж байгаа юм биш үү?

Хоёрдугаарт Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхт өөрөө халдаж байна. Олонхоороо шийдвэрлэхээр. Тэгэхээр цөөнх нь даргалаад бусад нь эрхгүй байх ийм зөрчил харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр хариулт авъя.

Одонгийн Цогтгэрэл дарга хариулт өгье.

**О.Цогтгэрэл:** Ер нь Улсын Их Хурлын хуулиуд дээр бүхий л зүйлүүдийг санал хураалтаасаа гадна тодорхой чиг үүргүүдийг хаанаас яах тодорхой чиг үүргүүд хуулиар мэдээж Улсын Их Хурлын хуулиар заачихсан байдаг. Жишээ нь төсвийн бүрэн эрх дээр Төсвийн хяналтын дэд хороог цөөнхөөс ахална. Яагаад гэвэл төсвийн хэрэгжилтийн гүйцэтгэлийг Засгийн газрыг хянахыг энэ бол цөөнхтэй холбоотой асуудал. Ийм учраас төсвийг Төсвийн хяналтын дэд хороог цөөнх ахална гээд л Улсын Их Хурал дээр байж байдаг. Жишээ нь энэ асуудлыг өөрийг нь яагаад олонхоос ахалж болдоггүй юм. Энэ Үндсэн хууль зөрчсөн үү гэдэг асуудал тавигдах нь өөрөө утгагүй. Тэгэхээр тухайн асуудлыг хуулиар хэрхэн яаж зохицуулсан бэ гэдэг л өөрөө асуудлыг нь ингээд үндэс суурь байх гэж. Би тэгээд түрүүн хэлсэн нэг статистикийг танд дахиад хэлье.

Нийтдээ өнгөрсөн хугацаанд 2022 онд 3 удаа, 2023 онд 2 удаа, 2024 онд 2 удаа нийтдээ 7 удаа хяналтын сонсгол явж байсан байна лээ.

Тэгээд энэ хяналтын сонсголдуудыг бид нар авч эргэж ингээд харсан. Эргээд үр дүнгүүдийг яах вэ энэ нийгмийн анхааралд 1-ээс 2 нь ороод асуудлууд болж байсныг бүгдээрээ мэдэж байгаа. 7 хяналтын сонсголоос үндсэндээ 5-аас 6 сонсгол нь зүгээр л энэ асуудал хэн ч мэдээгүй унтагдаад л өнгөрсөн. Тэгэхээр энэн дээр тэр тодорхой хэмжээнд цөөнхийн хяналт гэдэг эрх баригчид засгийн газраа байгуулаад олонх засгийн газраа байгуулаад өөрсдийнхөө гүйцэтгэсэн ажлыг өөрснөө хянана гэдэг логик л энэний цаана тодорхой хэмжээнд ингээд харагдаад байгаа.

Тэгээд хэлэлцүүлгийн явцад түрүүн бас хэлсэн. Хэлэлцүүлгийн явцад тодорхой хэмжээний өөрчлөлт ороод энийг санаачилсан гишүүн ахалж болох заалтыг оруулах нь өөрөө байж болох юм гэдэг дээр хууль санаачлагчид болоод өчигдрийн Байнгын хорооны гишүүд бас ер нь тодорхой түвшинд ингээд ойлголцоод ярилцсаныг дахин хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Мэндбаярын Мандхай гишүүн тодруулж асууя.

**М.Мандхай:** Би бол ийм санаатай байна аа. Ер нь одоо энэ түр хороог хэн даргалах, энэ ажлыг хэн авч явах энэ нийцтэй байх вэ гэдэг нь илүү ажил хэрэгч ийм талаасаа бид нар хандаж шийдвэр гаргана. Тэрнээс биш зөвхөн цөөнхөд цөөнхөөр удирдуулж тухайн сэдэвтэй холбоотой түр хороог байгуулж ажиллана гэдэг нь өөрөө учир дутагдалтай, 1-д.

Хоёрдугаарт угаасаа цөөнхийн асуудлыг хүндэтгээд дэмжиж байгаа асуудал өөрөө Үндсэн хуульд нь тусгачихсан байгаа учраас бид нар энийг би бол энэ хуулийг яг үндсэндээ дэмжихгүй байр суурьтай байгаагаа илэрхийлье.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн үг хэлье.

**О.Номинчимэг:** Ер Энэ асуудлыг өчигдөр ТББХ-н дээр нэлээн хэлэлцсэн. Байр сууриа илэрхийлсэн. Асуулт асуусан. Хангалттай хариулт аваагүй. Тэгээд яах вэ өнөөдөр бол Цогтгэрэл гишүүн өргөн барьсан хуулийнхаа үзэл баримтлалаас ухраад яах вэ хэлэлцье. Жоохон уян хатан байдлаар оруулж ирэхэд окэй гээд өөрөө хэлж байх шиг байна. Ер нь яах вэ энэ 33.8 буюу энэ Түр хорооны бүрэлдэхүүн ямар байх юм. Заавал цөөнхийг оролцуулна тиймээ. Даргалагч ямар байх юм гэдэг дээр одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр чинь ч гэсэн цөөнхөөс даргалж болно. Тэр сэдвээсээ хамаараад гээд тиймээ. Бүүр тухайлж хэлэх юм бол Түр хорооны тусгай шалгалтын сэдвээс хамааран шаардлагатай гэж үзвэл Түр хорооны даргыг Түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн төлөөллөө сонгоно оо гээд оруулчихсан байгаа байхгүй юу. Тэгээд яг үнэхээр гүйцэтгэх засаглалыг хянах ч байдаг юм уу энэ асуудал дээр яалт ч үгүй цөөнх даргалдаг жишиг байдаг.

Хуулиар бүх нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хуулийн хэрэгжилтийг хангах асуудлаар хийх гэж байгаа. Түр хороог зөвхөн цөөнх даргална гэж орж ирдэг бол их болхи. Тэгээд болхи гэхээсээ илүү бараг балмад ийм зүйл заалт байсан. Тэгээд өөрөө энийгээ наанатай цаанатай хандъя гэж байх шиг байна.

Хоёр юм энэ дээр анхааруулж хэлмээр байгаа юм.

Нэгдүгээрт, хууль санаачлагчийн хувьд өчигдөр асуултад хариулж байхдаа олон улсын жишиг нь тийм, олон улсад ийм байдаг ийм ийм улсуудтай гээд хэлж байна аа. Яг үнэндээ хуулиар ингэж хатуу заасан улс байхгүй. Яагаад гэвэл энэ гишүүдийн хэлж байгаа шиг та бүхний ч гэсэн хүлээн зөвшөөрч байгаа шиг ард түмний элч болсон аль ч намын төлөөллийн хүн бай энэ Хянан шалгах түр хороонд бүрэн эрхээ хэрэгжүүлж оролцоно оо.

Тухайлсан сэдвээсээ хамаараад цөөнх байх уу олонх байх уу, юу гэдэг юм энэ асуудал бол шийдэгддэг зүйлийг олон улсын жишиг нь тийм гэж ингэж дайрах нь өөрөө болохгүй ээ. Өмнө нь ингээд олон улс гадаадад ингэдэг юм гээд хэлээд гишүүд итгээд явчихдаг байсан байж магадгүй. Энэ удаа энэ 126 гишүүн дотор чинь юмыг нарийвчилж хардаг уншдаг ийм гишүүд орчихсон байгаа учраас ийм үгээр битгий ам хаачихна гэж бодоорой гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт энд нөгөө цөөн юу санаачилсан гишүүд даргална гэдэг асуудал явж байх шиг байна. Тэгэхээр энийг 2 ялгаж үзээсэй гэж бодож байгаа. Ер нь Түр хороог хамгийн багадаа 32 гишүүн санаачлаад заавал цөөнхийн төлөөллийг оруулаад санаачилж баталдаг. Эндээс Түр хорооны өөрийнх нь бүрэлдэхүүнийг баталдаг. Тэгээд нөгөө санаачилсан гишүүн гээд тэгчихээр 32 санаачлагч гээд энэ дотроо нэг санал хураалтын процесс эд нартай байх ёстой. Энэ нь уг нь энэ одоогийн 33.8 дээр уг нь байгаа юм л даа. Тэгээд яаж энийгээ засах гэж байгаа юм. Тэгээд дараа нь илүү ярилцана биз. Энэ Түр хорооны сонсголыг Хяналт шалгалтын тухай хууль дээр байгаа бусад хяналтын сонсгол, нийтийн сонсгол өнөөдөр Баярмаа гишүүн, Сайнзориг гишүүдийн яриад байгаа эрүүдэн шүүлттэй холбоотой хяналтын сонсгол нээлттэй сонсгол хийсэн.

Энэнээс нэг жоохон ялгаж үзээсэй гэж бодож байгаа юм. Түр хорооны чиг үүрэг бол яг үнэхээр шалгах энэ нөгөө шүдтэй арслан байх энийг гаргаж ирэхийн тулд ийм 32 гишүүнээр санаачилж гарч ирдэг ийм асуудал. Энэ дээр бол тэр санаачлагч нь энээ тэрээ гэдэг нарийн процесс нь байж болно. Энэ зүгээр нийтийн

сонсгол, хяналтын сонсгол хийх асуудлыг, энийг урьд нь бид нар ажлын хэсэг гараад ч гэсэн энэ Тэмүүжин гишүүн, Баярмаа гишүүд өөрсдөө ороод бид нар уг нь ажилласан юм. Тэгээд энийг нэг хаа хамаагүй хүмүүс ингээд санаачлаад өөрсдөө дураараа хийнэ гэхээсээ илүү Байнгын хороо, Дэд хороодуудтайгаа уяж өгөх ёстой. Ер нь олон улсын парламентын энэ дэг жаягт энэ Байнгын хороо, мэргэжлийн Байнгын хороо, Тусгай дэд хороогоороо үйл ажиллагаагаа явуулж байж энэ өөрөө илүү мэргэжлийн болно.

Тэгэхээр энэ сонсголууд өөрсдөө Дэд хороо, Байнгын хороотойгоо заавал холбогдож явж байх ёстой. Тэгж байж гарсан санал, дүгнэлт маань ажил хэрэг рүү болох юм руу орно гэдэг саналууд гарч байсан. Тэгээд энийг бас үзэж энэ 2 сонсголыг бол тусад нь авч үзэх ёстой. Энэ бол одоо зөвхөн Түр хорооны асуудал бүрэлдэхүүн гээд байгаа шүү гэдэг дээр.

**Д.Амарбаясгалан:** Ер Одонгийн Цогтгэрэл гишүүн хариулт өгье.

**О.Цогтгэрэл:** Одоогийн байгаа хуульд цөөнхөөс даргалж болох зохицуулалт байгаа шүү дээ гэж байна. Байгаа. Тэгэхдээ олонхоороо шийднэ л гэхчхэн байгаа. Тэгээд өнгөрсөн түүхийг ингээд харахаар нийтдээ 2022 онд, 2023 онд, 2024 онд нийлээд 7 удаагийн сонсгол болсон нь долуулаа тухайн үеийн олонхоос шийдэгдээд л явсан. Бодит нөхцөл байдал яг факт нь өөрөө ийм байгаа учраас тэрнээс цөөнхөөс даргалж болно шүү дээ гэдэг хуулийн боломж онолын боломж нь бол байгаа. Практик дээр бол боломж ингээд байхгүй болчихоод байгаа юм аа. Ер нь үзэл баримтлалын түвшинд 2021 оны 7 сарын 2-нд энэ хуулийг анх өргөн барихдаа анх өргөн барьсан хуулийн үзэл баримтлалд одоогийн бид нарын өргөн барьж байгаа энэ хувилбараар үзэл баримтлал өргөн баригдаж байсан юм байна лээ. Тэгээд явцын дунд эцэслэн батлагдах үед ингээд өөрчлөгдсөн гэдгийг хэлье.

Тэгээд тухайн үед хууль өргөн баригдаж байхад Үндсэн хуулийн үзэл баримтлал ба сайн туршлага энэ дотроо Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороо гэдгээр яг энэ хуулийн хүрээнд судалгааны ажлыг Парламентын судалгааны хүрээлэнгээс нэлээн тийм өргөн баг гарч энэ зөвлөх тийм судалгаа хийлгэж байсан юм байна лээ. Жишээ нь энэ судалгаануудыг ингээд уншихад Холбооны бүгд найрамдах Герман улсын парламентад яг энэ цөөнхийн төлөөллийг хэрхэн яаж оролцуулах вэ? Бүр энийг боддог Шеферсийн арга гээд Улсын Их Хурлын энэ төлөөллийг боддог. Энэ томъёоны тухай хүртэл энд дурдагдаад. Тэгээд энэн дээр ер нь жишээ нь ХБНГ Улсад парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ тухайн оронд хийгдэж байгаа тэр хяналтын сонсголын дийлэнхийг цөөнхөөс ахалдаг энэ зохицуулалтуудыг энэ зарчмууд ингэж хэрэгжиж байна гэдэг зүйлүүдийг жишээ нь энэ парламентын судалгааны хүрээлэнгийн энэ дүгнэлт дээр яг энэ утгаараа дүгнэлтээ биччихсэн байгаа.

Тэгээд энэ хүрээнд өргөн баригдаад асуудал өөрчлөгдөөд явсан. Тэгээд дахиад давтаад хэлэхэд бид нарын хувьд эцсийн дүндээ, эцсийн дүндээ хяналт шалгалт илүү үр дүнтэй болоход тэр түрүүн зарим гишүүдээс гарч байсан хяналт шалгалтыг өргөн барьсан гишүүд тэр тусмаа санаачилсан гишүүнийг хуралдаан даргалагчаар байх зохицуулалт бол нэлээн тийм байж болох үндэслэлтэй зохицуулалт юм байна аа. Түрүүн тэр Номинчимэг гишүүний хувьд дахиад санаачилсан гишүүд дотроо дахиад яах юм гэдэг асуудал дахиад л өөрөө том бодлогын асуудал болоод үүсээд гараад ирчих магадлалтай юм байна лээ.

Тэгэхээр тэр санаачилсан гишүүн гэдгийг анхнаасаа санаачилсан гишүүн хурал даргалагчаар байхаар анх өргөн барихдаа гарын үсэг цуглуулахдаа энэ асуудлуудаа харгалзаж үзэх ийм нөхцөл байдлуудыг тооцвол өөрөө энэ байж болох хувилбар юм аа. Энэ бол олонх цөөн гэхээсээ илүү Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхтэй холбоотой асуудал шийдэгдэж болох юм гэж санал нэгдэж байгаагаа дахин хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Ер Батын Батбаатар гишүүн асуулт асууна.

Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууна гэж байна. Тодруулга өгье.

**О.Номинчимэг:** Ер Тэгэхээр нөгөө практик дээр ийм асуудал болоод байна гээд тэрийгээ шийдэхдээ л их муйхар арга орж ирж байна л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр нарийвчилсан судалгаагаар харах хэрэгтэй судалгаагаар сайн харах хэрэгтэй. Германы хууль дээр ийм заалт байхгүй. Практик дээрээ сэдэвчилсэн зүйл дээрээ яг юу нь зохистой байх юм гэдэг юман дээр л цөөнхөө тавьж явдаг. Тэгэхээр хуулиар битгий ийм муйхар юм оруулж ирээч л гэдэг асуудлыг хэлсэн. Тэгээд дахиад жоохон уян хатан хуулиа харъя гэж байгаа юм. Ер нь бид нар нөгөө нэг санаа нь зөв байвч хэрэгжилт дээрээ дандаа ингээд алдчихдаг юм байгаа шүү дээ. Санаа нь зөв ийм практик дээр асуудал гараад байна энийгээ зөв яаж шийдэх вэ гэдэг дээрээ шийдлээ их залхуу шийдэл хийчихдэг байхгүй юу. Нарийвчилж харахгүйгээр өө ерөөсөө бүгдээрээ цөөнх байх нь зөв юм байна гээд орж ирж байгаа чинь л буруу байгаад байгаа юм энийг анхаарах ёстой л гэдгийг хэлээд байгаа юм. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Цогтгэрэл гишүүн нэмж хариулт өгье.

**О.Цогтгэрэл:** Муйхар гэхээсээ төсвийн хяналт гэдэг зүйл дээр би түрүүн хэлсэн. Төсвийн хяналтын дэд хороо гэдэг байгууллага байдаг. Төсвийн хяналтын дэд хороо зөвхөн зөвхөн цөөнхөөс ахална гээд хуульд бичихсэн байдаг. Энийг муйхар зохицуулалт гэж үзэхэд бол хангалтгүй шүү. Төсвийг цөөнх хянана л гэхчихсэн байдаг. Тийм тэгэхээр эндээс харахад энэ чинь өөрөө муйхар зохицуулалт гэж шууд та ингэж мушгиж хэлж байгаа чинь өөрөө зохисгүй шүү.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн дахин тодруулж асууя.

**О.Номинчимэг:** Төсөв ойлгомжтой шүү дээ. Төсвийг хэн батлаад хэн хэрэгжүүлдэг вэ гэхээр яалт ч үгүй гүйцэтгэх засаглал хэрэгжүүлдэг. Гүйцэтгэх засаглал дээр хэн хяналт тавих вэ гэхээр яалт ч үгүй л цөөнх байдаг. Тэгээд би түрүүн хэлсэн шүү дээ. Гүйцэтгэх засаглалтай холбоотой асуудлын яалт ч үгүй цөөнх даргалдаг юм. Энэ практик гээд тэгээд ийм энэ чинь энэнээсээ хамаардаг уян хатан байх ёстой гэхээр төсвийг Түр хорооны хяналт шалгалтын чиг үүрэгтэй бүүр бүгдийг нь холиод ингээд хэлж байгаа чинь одоогийн хариулт чинь ч гэсэн муйхар байна Цогтгэрэл дарга аа. Тэгээд буруу дутуу байгаа юмаа хүлээн зөвшөөрөөд уян хатан хамтдаа яая гэдэг юмаа хүлээн зөвшөөрөхгүй бол арга барил чинь ч, хандлага чинь ч муйхар байна л гэдгийг хэлээд байгаа юм.

**Д.Амарбаясгалан:** Батын Батбаатар гишүүн асуулт асууя.

**Б.Батбаатар:** Өнөөдөр ингээд Улсын Их Хурал парламент олонх цөөнхтэйгөө харилцаатай болж байгаа нь их сайхан санагдаж байгаа. Парламент маань зөв ажиллаж эхэлж байна.

118-ын бүлэг байх үед би энэ босгыг давахад их хэцүү байсан. Олонх цөөнх бүлэгт харьяалагдаагүй гишүүд намын гишүүд үг хэлнэ гээд одоо ч гэсэн энд үг хэлэх асуулт асуухад ийм л байдлаар хариулж байгаа юм. Энэ санаачлагч гишүүндээ тэр Түр хорооныхоо дарга марга болдог ахалдаг тэр юмыг нь өгөх хэрэгтэй. Түр хороо чинь эцсийн шийдвэр гаргадаггүй шүү дээ. Түр хороо чинь тогтоолын төсөл гаргаад бэлдээд Их Хурлын шийдвэр олгоход бэлдээд Их Хурал руу оруулж ирнэ. Их Хурал дээрээ тэр олонх нь асуудлаа шийддэг байх хэрэгтэй. Их Хурлын гишүүд нь кнопоороо. Санаачилж байгаа гишүүн нь заавал цөөнхөөс бүрдэх албагүй. 32 гишүүнээ цуглуулж байгаад тэр санаачилгынхаа дагуу түр хороогоо байгуулах тэр боломжийг нь өгч байх хэрэгтэй. Иргэний зориг ногоон намын хувьд бүтэн жилийн хугацаанд Улсын Их Хуралд Түр хороо байгуулъя. Ажлын хэсэг байгуулъя. Ардчилсан хувьсгалын удирдагч С.Зориг агсан хөнөөгдсөн хэргийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлье гэдэг зүйлийг жил орчим ярьсан. Үр дүн гарч өгөөгүй. Олонхын гишүүн ажлын хэсгийг ахалсан.

1 удаа уулзалт хийсэн. Тэгээд алга болсон олонх дотор живчихдэг. Иймэрхүү байдлаар яваад байвал энэ санаачилгууд хангагдахгүй. Америкт уугуул иргэд индианчуудын эрхийг хэр хэн хамгаалах юм. Олонх нь хамгаалах юм уу? Австралид. Энэ чинь ганцхан тэр төсвийн асуудал биш байхгүй юу. Өөр бусад олон асуудлууд жендер тэгээд энэ нийгэмд байгаа тодорхой бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал. Ганцхан ингээд төсөв юм уу цөөнх гэдэг тоон дээр яриад олонх нь шийдэх ёстой Их Хурлын эрх гэдэг байдлаар асуудлыг яриад баймааргүй байгаа юм.

Цааш цаашдаа бид нар Улсын Их Хурал дээр энэ суудал бүхий намууд нь нэгэнт иргэд сонгогчдын сонголтоор 4 хувь, 5 хувь, 7 хувийн босгууд байж байдаг. Тэрийгээ даваад ороод ирж байгаа, суудлаа авч байгаа, энэ цөөнхдөө хамгийн босго давж орж ирсэн, хамгийн цөөхөн суудалтай, магадгүй бие даагаад сонгогдсон гишүүнтэй тэр эрхийг нь олгож байхгүй бол тэд нарыг дэмжсэн, тэр иргэдийгээ, сонгогчдыгоо, та нар цөөнх учраас аливаа асуудлыг санаачлаад удирдаад аваад явах боломжгүй гэдэг ийм л хариулт өгч байгаатай адилхан болно биз дээ.

Хууль санаачлагч тэгэхээр энэ чиглэл рүүгээ Их Хурлын суудал бүхий 5 нам нь төлөөлөл оролцуулаад дахиад нөгөө 68, 42 гэдгээр хувилахгүйгээр тэнцүү тооны хүн оруулж байгаад энэ дээрээ ингээд ярилцаад тэр чиглэл рүү нь ордог. Тэр 3 сая 500 мянган хүний 35 мянган хүний эрхийг хамгаалж болдог. 35 мянга чинь хэт цөөнх шүү дээ. Нэг хувь. Тэр эрхийг нь хамгаалж болдог ийм орчин нөхцөл рүү парламент ажиллаж чаддаг, бага ард түмэн төлөөлөл байдаг гэдэг. Энэ чиглэл рүүгээ ингээд ажиллах боломж, бүгдээрээ ярилцах боломж байна уу?

Тэгэхгүй бол ингээд төсвийн хяналт ч гэдэг юм уу хүний эрх ч гэдэг юм уу ярихаар Их Хурлын тухай хууль дээр цөөнхийн бүлэг наадхыг чинь авдаг юм. Та нар бүлгийн суудалгүй учраас авч болохгүй гээд бүгдээрээ эрх барьж байх үедээ хяналтаа өөрөө өөрсдөдөө зохиогоод яваад байдаг ийм зовлон байгаад байсан.

**Д.Амарбаясгалан:** Батбаатар гишүүний асуултад хариулъя.

Цогтгэрэл гишүүн хууль санаачлагч.

**О.Цогтгэрэл:** Өнөөдөр парламент 126 гишүүнтэй болоод өнөөдөр 5 нам эвслийн төлөөлөл Улсын Их Хуралд ажиллаж байгаа. Тэгэхээр парламент өөрөө ойлголцлын, зөвшилцлийн, мэтгэлцээний талбар гэж бид нар агуулгаар нь ойлгож ажилладаг. Тэгээд энэ хүрээнд яг энэ хуулийн агуулга дахиад дээрээс нь тэр Байнгын хорооны гишүүдээс гарч байгаа саналын хүрээнд Түр хороог санаачлагч гишүүн сонсгол ахлаад явах боломж хэрвээ энэ тал руу асуудал шийдэгдээд явбал парламентад 4 суудалтай байгаа улс төрийн хүчнээс ч гэсэн энэ асуудал үнэхээр зөв зүйтэй асуудлыг зөв зүйтэй асуудлыг парламентын 4-ний 1-ээр сонсгол зохион байгуулагдах бол яг тэр. Парламент гэдэг ойлголцлын, парламент гэдэг зөвшилцлийн, парламент гэдэг мэтгэлцээний талбар юм бол энэ хүрээнд нь бид нар асуудлаа ярилцаад явах бүрэн дүүрэн боломж бололцоо ингээд үүсэж байгааг л танд хэлье.

Тэгээд хэрвээ хэлэлцэх эсэх дэмжигдээд шийдэгдээд явбал энэ ажлын хэсгийн хүрээнд хэдүүлээ энэ асуудлыг яг саяын тэр ойлголцол зөвшилцлийн буюу цөөнхийн оролцоог хэрхэн яаж хангах вэ гэдэг дээр нэлээн томоохон дэвшил болно л гэж бодож байгаа юм. Тэрний хүрээнд хамтран ажиллахад нээлттэй байна аа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байхгүй. Өө за үг хэлэх гишүүн байгаа юм байна. Сархадын Зулпхар гишүүн үг хэлье. Индрээс 1 дүгээр индэр.

**С.Зулпхар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье ээ.

Цогтгэрэл нарын гишүүдийн санаачилсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуультай уялдсан энэ санаачилгыг, энэ саналыг бол зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ яах вэ дэмжихтэй уялдуулаад зарим нэг асуудлыг бид сая их нээлттэй ярилцлаа. Тэрийг бас их тодорхой цаашдаа бол бид нарийн судалж байж тал талаас хэлэлцэж байж шийдэл гаргах юм байна гэж ойлголоо. Угаасаа ч тэгэх ёстой.

Нөгөөтээгүүр Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль дээр хяналт шалгалтын тодорхой 7 арга хэрэгсэл байгаа. Асуулт тавих, асуулга тавих, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, мэдээлэл сонсох, тайлан илтгэл хэлэлцэх, төсвийн хяналт хяналтын сонсгол. Энэ 7 дахь нь бол Хянан шалгах түр хороо байгуулж тусгай одоо шалгалт явуулах тухай энэ шинэ практик юм байгаа юм. Гэхдээ энэ практик дээр бол сая бидний ярьсан зүйл бол нөгөө одоо жишээ нь арга хэрэгслүүд нь байгаа учраас парламентад цөөнхийн бүлэг цөөнхийн төлөөлөл бол хяналтаа тавих тэр эрх нь бол тэр механизм байгаа шүү гэдгийг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Дан ганц Хянан шалгах түр хороо байгуулагдаад тэгээд Хянан шалгах түр хороог даргалснаар бол аль нэг цөөнх энэ хяналт шалгалтад нь ялангуяа цөөнхийн жишээ нь хяналт тавих эрх бол илүү боловсронгуй болно оо гэдэг бол нэг талдаа өрөөсгөл гэж байгаа юм. Гэхдээ энэ эрхийг бол нээх буюу боловсронгуй болгох шаардлага бий гэж байгаа юм.

Сая Улсын Их Хурлын гишүүн Цогтгэрэл бас өөрөө асуулт хариултын явцад хэлж байсан. 2021 онд энэ хууль анх жишээ нь санаачлагдаад тэгээд тэрний дагуу

батлагдаад хэрэгжээд, 2024 онд энэ нэмэлт жишээ нь өөрчлөлтүүд ороод ингээд бид хэрэглээд явж байгаа. Тэгээд цаашдаа ч гэсэн бид энийг бол илүү үр бүтээлтэй шаардлагатай үед бол бидний сайн мэдээг хяналт тэмцлийн тогтолцоог Засгийн газрын жишээ нь хууль хэрэгжүүлж байгаа тэр үйл явцад илүү сайн хяналт тавих энэ боломжийг нээх үүднээс бол сайн ашиглах ёстой гэж ойлгож байгаа юм аа.

Нөгөөтээгүүр сая бол жишээ нь бид нэг зүйлийг ойлголоо. Дан ганц бол түр хороог цөөнхийн бүлгийн төлөөлөл юм уу цөөнхийн гишүүдээс ахлуулах ёстой гээд гэдэг энэ ойлголт бол өөрөө бас Улсын Их Хурлын гишүүдийн эрхийг хууль санаачлах, хууль санаачлахтай уялдсан аливаа шинэ үйл ажиллагаанд эрх тэгш оролцох эрхэд нөлөөлөхөөр байгаа учраас энийг уян хатан нээлттэй байдлаар зохицуулах ёстой юм байна гэж ойлгож байна аа.

Дөнгөж өчигдөр МАН-ын гишүүдээс Батнайрамдал тэргүүтэй гишүүд бас хяналт шалгалтын түр хороо байгуулах санаачилга гаргаад явж байгаа юм. Би өөрөөс нь асуусан. Та түр хороогоо даргалах сонирхолтой байна уу гэсэн. Тийм л гэж байгаа юм.

Тэгэхээр бид энэ эрхийг бол нээсэн энэ уян хатан зохицуулалтыг заавал хийж өгөх ёстой. Тэгж байж энэ бол парламентын тогтолцооны парламент ёсны, парламентын засаглал нөхцөл бүрдэх юм гэсэн ийм бодолтой байна аа.

Нөгөөтээгүүр яах вэ 2 дахь зүйл. Магадгүй та бүхэн цаашдаа харна биз ээ. Зөвхөн таны саяын хэлж байгаа хэлбэрээр биш. Тухайн Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг уян хатан байдлаар тогтоож саяын хэлбэрийг зохицуулж болж байгаа шүү гэдгийг хэлье. Энэ бол хуулийн 33 дугаар зүйлийн би энд хэлж өгье. 33.2-т байгаа юм.

Энэ 33.2 өөрөө бүрэлдэхүүнийг тогтоохтой холбоотой зохицуулалт байгаа юм. Тэгэхээр энийг уян хатан хэлбэрээр зохицуулах юм бол саяын нөхцөлүүдийг бид шийдэх бүрэн боломжтой гэж үзэж байна аа. Парламент бол өөрөө жишээ нь зөвшилцлийн орчин. Парламент өөрөө нөгөөтээгүүр бол мэтгэлцээний хэлэлцүүлгийн орчин. Энэ хэлэлцүүлэг мэтгэлцээний орчинд гишүүд эрх тэгш байх үүднээс энэ зохицуулалтууд мөн адил өөрөө уян хатан шаардлагатай үед маш тодорхой. Шаардлагатай үед бол жишээ нь бүрэн зохицуулагдсан байх ёстой гэж үзэж байгаа юмаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалт явагдана. Гишүүдийг танхимдаа орж ирэхийг урьж байна. Өнөөдөр олон асуудалтай асуудал тус бүрийг санал хураалтаараа шийдээд явна.

Дараад нь Засгийн газраас нэн яаралтай горимоор төсвийн хүрээ, төсвийн тодотгол гэх мэт олон асуудлыг өргөн барихаар бэлтгэж байгаа учраас Улсын Их Хурал цаг алдаж боломгүй байна. Ялангуяа өнөөдөр бид төсвийн хүрээг яаралтай хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар шийдвэрлэсний дараа бусад асуудлууд хөдлөх боломжтой учраас санал хураалт явуулна аа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүйг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

7 гишүүн дэмжиж, хэлэлцэхийг дэмжээгүй санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлээ.

16.33 цаг

Энэний дараа Улсын Их Хурлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах 3 төсөл байгаа. Бат-Эрдэнэ, Ариунзаяа, Тэмүүжин, Мөнхбаатар, Цогтгэрэл нарын хамт өргөн мэдүүлсэн 3 хуулийн төсөл байгаа.

Өнөөдөртөө хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэж дуусна.

Тэгээд энэ 5 хуулийн төсөл нэгэнт хэлэлцэх эсэх нь Улсын Их Хурлаар шийдэгдэж байгаа тохиолдолд энэ ажлын хэсгийг бүгдийг нь нэгтгээд 1 болгоод хэлэлцээд явахад хамгийн боломжтой болов уу гэж бодож байна. Ингэж хэлэлцэж байж бид энэ хаврын чуулган завсарлахаас өмнө энэ 5 салангид хуулийн төслийг хэлэлцэж ард нь гарах байх гэж бодож байгаа.

Тэгэхээр хууль санаачлагчид энэ дээр хоорондоо ярилцаад надад саналаа хэлээд өнөөдрийн нэгдсэн чуулганаас чиглэл авах нь зүйтэй гэж бодож байна.

Би түрүүн зарласан, өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбогдуулж **Засгийн газраас нэн яаралтай горимоор хуулийн төсөл хэлэлцүүлэхээр өргөн барьсан. Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцье.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог хэрэв тухайн төсөлд хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог нь тогтоож нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан. Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан.

Ингээд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд хуваарилсан.

Хэлэлцэх асуудалд оръё.

**Улсын Их Хурлын чуулганы чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-аас 2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Одоо Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар яаралтай хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Гишүүд ирцдээ бүртгэгдье. Санал хураалтдаа бэлтгэе. Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Санал хураалтад орж амжаагүй гишүүд байна уу? 1, 2, 3, 4, 5, 6.

Санал хураалт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Горимын санал Ж.Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Даргаа гар энэ мөстэй юм барьчихсан чинь гар нурууд сая 1 нуруу уншиж орсонгүй. Дахин санал хураалт явуулж өгнө үү?

**Д.Амарбаясгалан:** Тэгье. Энхбаяр сайдын горимын саналаар саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

50.5 хувиар санал дэмжигдэж байна.

Энэ зарим гишүүдийн санал орохгүй байгаад байх шиг байна. Хэн хэнийх орохгүй байна. Тэгвэл үндсэн саналын томъёоллоороо буюу Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Цэвэгдоржийн Туваан гишүүн горимын санал гаргая.

**Ц.Туваан:** Саяын санал хураалтыг хүчингүй болгож дахин санал хураалт явуулж өгөхийг хүсье ээ.

**Д.Амарбаясгалан:** Туваан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүдээ дуудъя.

Горимын саналаар санал хураалт явуулъя.

Туваан гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалтыг явуулъя.

Санал хураалт

Санал дэмжигдлээ.

Үндсэн санал хураалтыг явуулъя. Энэ яах вэ нөгөө төрийн ажил явж байгаа цаг хугацаатай асуудал учраас ингээд 2 удаа горимын санал хураалгачихлаа.

Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Төсвийн хүрээний мэдэгдэл явж байгаа.

Санал хураалт.

56.1 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шилжүүлж байна.

Дараачийн асуудалд орж байя. Өргөн барьсан асуудлыг нягталъя.

Засгийн газрын яаралтай асуудал явж байгаа учраас би өдөр хэлсэн байгаа. Хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулаад Бүрэлдэхүүний тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ гэж хэлсэн.

ТББХ хуралдаж дууссан байна. ТББХ-ны санал, дүгнэлтийг байж байгаарай. Энэ материал хараахан орж ирээгүй байна.

Дараагийн асуудалд орёе. Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлдсэн байна.

Төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэгдсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнайн Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайдаас 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулахад Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга О.Цогтгэрэл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу ажлын нэг өдрийн завсарлага авсан.

Завсарлагааны хугацаа дууссан тул анхны хэлэлцүүлгийг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар үргэлжлүүлэн явуулж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүлсэн билээ.

ТББХ 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хуулийн төслийн агуулга, бодлого, зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, найруулгын шинжтэй засварыг хийж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүд болон Байнгын хорооны танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон “Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ТББХ-ны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ажлын хэсгийн гишүүд ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга Мөнх-Эрдэнэ, Хууль, эрх зүйн газрын дарга Саруул. Ингээд ажлын хэсгийн хүмүүс ирсэн байна. Нэрсийн жагсаалт нь ирээгүй байна шүү. Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна.

7 гишүүн нэр ирүүлсэн байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууна. Алга байна. Жамбалын Ганбаатар сайд алга байна. Цэндийн Баатархүү гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн нэрээ татаж байна. Цэрэндоржийн Мөнхтуяа гишүүн асуултаа асууна аа.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе ээ. Монгол Улсын эрхэм гишүүд ээ, элсэлтийн шалгалт утгаараа дампуурсан. Ер нь энэ улс орны ирээдүй болсон хүүхэд багачуудынхаа асуудал дээр бид нар онцгой анхаарахгүй бол энэ салбарыг сүүлийн 30 жилд улс төрийн томилгоогоор томилогдсон сайд нар ер нь самраад дууслаа.

Элсэлтийн шалгалт 2006 оноос хойш авч эхэлсэн энэ жил 20 дахь жилээ авч байгаа. Энэ хугацаанд ийм алдаа завхрал огт гарч байгаагүй. Утгаараа бүүр энэ жил бүүр онцгой анхаарал хандуулахаар ийм асуудал гарч байгааг гишүүд аягүй сайн анхаарч сонсоорой. Идэрээ гишүүнээ сайн сонсоорой. Манай Батжаргал гишүүн ЭЕШ-тай холбоотой асуудал яригдаж байна шүү. Та хэд битгий хоорондоо яриад бай.

Дархан-Уул аймгийн англи хэлний элсэлтийн шалгалт дээр бүртгэлийн дугаарыг нь би хэлэхгүй, орхиё. Хүүхдийн асуудал учраас. Дугаартай шалгуулагч анхны оноо 71 байсан. Шалгалтын оноо эцэслэхэд анхны оноо 93 буюу хэмжээст оноо 22-оор нэмэгдэж 793 болж засагджээ. Энэ булхайг Боловсролын үнэлгээний төвийн захирал хийхээс бусад өөр хэн ч хийх боломжгүй юм аа.

Тэгэхээр энэ дэлхийн түүхэнд байхгүй шившиг Монголд болж байна. Ийм байдлаар хэчнээн хүүхдийн хувь заяаг, хэчнээн хүүхдийн оноог засаж хэчнээн олон мянган хүүхдийн хувь заяагаар тоглосон бол оо гэж бодохоор сэтгэл үнэхээр өвдөж байна аа.

Боловсролын сайдад хариуцлага тооцох хангалттай үндэслэл ерөөсөө л энэ. Надад өргөдөл гомдол нь ирчихсэн байгаа. Бүх баримт нотлох баримт нотолгоонууд нь энд байна аа. Тэгээд 71 гээд анхны оноо гарчихсан хүүхдийн оноо тавигдахдаа 93 оноо болоод 22 оноо засагдсан байна. Энэ хэчнээн хүүхдийн боломжийг хулгайлж байгаа ийм хулгай вэ?

Тэгээд энэнтэй холбоотойгоор 4 ийм шаардлага тавьж байна.

Нэгдүгээрт бол Боловсролын сайд Наранбаярыг огцруул.

Хоёрдугаарт элсэлтийн шалгалтын бүх анхдагч материалуудыг Төрийн тусгай хамгаалалтад авах шаардлагатай байна.

Гуравдугаарт Засгийн газраас энэ жилийн элсэлтийн шалгалттай холбоотой тусгай шалгалтыг оруулах ийм саналыг хүргүүлж байна.

Дөрөвдүгээрт энэ завхарсан олон мянган хүүхдийн хувь заяагаар тоглосон асуудлуудад яаралтай цэг тавьж 8 сард дахин шалгалт авахыг олон мянган эцэг эхчүүд, хүүхдүүд, багш нар шаардаж байгааг хэлмээр байна аа. Тэгээд энэн дээр Ерөнхий сайд байхгүй байна.

Би Ерөнхий сайдаас асуух асуулт маань байсан юм.

**Д.Амарбаясгалан:** Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя.

**О.Номинчимэг:** Яах вэ бүрэлдэхүүний тухай хууль маань эцсийн хэлэлцүүлэг болж байгаа. Ингээд дэмжигдээд явах байх. Зүгээр энэ дээр нэг цаг үеийн шинжтэй асуудал дээр би үг хэлмээр байгаа. Засгийн газар ер нь төсвийн тодотгол оруулж ирэх байх ер нь хэмнэе гамная гэсэн бодлого оруулж ирэх юм шиг байна зөв өө. Энийг бол дэмжинэ ээ. Тэгээд үнэхээр төсөв мөнгөний бодлого орлого багасаад байгаа юм бол төсөв бүрдүүлдэг, гаалийн татвараа багасгадаг, тэглэж орж ирж байгаа. Орж ирэх тэр бодлого явуулж байгаа нь хэр зохистой юм бэ л гэж байгаа юм.

Маргааш одоо Минскт Евро Азийн худалдааны түр хэлэлцээрт Монгол Улс гарын үсэг зурах гэж байгаа юм байна. Тэгээд би энэ хяналтын, тамхины хяналтын тухай хуулийг санаачлаад гишүүдтэй хамт өргөн барих гээд Засгийн газар луу 5 сарын 14-нд санал авах гээд явуулсан юм. Тэгээд ерөөсөө ингээд өөрсдийнхөө энэ Евро Азийн энэ асуудал, гаалийн татвараа тэглэх гэж байгаа бууруулах гэж байгаа асуудалтайгаа барьсаар байгаад миний Тамхины хяналтын тухай хуульд саналаа өгөхгүй ингээд барьсан.

ЗГХЭГ-аас асуухаар сайд нар шинэ Засгийн газар бүрдчихсэн буцааж байгаа гэдэг юм ярьсан. Юу ярьж байгаа юм бэ ихэнх сайд чинь адилхан байна шүү дээ гээд нэг юм гуйж түйж олон юм ярьж байж өнөөдөр Засгийн газрын хурлаар санал, дүгнэлт гарч байгаа гэсэн сураг байна. Тэгээд ийм увайгүй юм хиймээргүй байна аа. Энэ Тамхины хууль чинь янз бүрийн ашиг сонирхол байдаг юм байна.

Засгийн газар ч гэсэн энэнтэй ашиг сонирхлын зөрчилтэй хэд хэдэн хүн байж болзошгүй байна. Тэгээд хуулийг өргөн бариулахгүй саналаа өгөхгүй удаж удаж хуулийн хугацаа 30 ажлын хоног чинь болчихлоо шүү би ингээд ингээд явлаа шүү гэдэг юм барьж байж энэ нэг өнөөдөр саналаа гаргаж байх шиг байна л даа. Тэгээд энэ хоорондоо гаалийн албан татвараа тэглэх тамхин бүтээгдэхүүний 30 хувийн гаалийн албан татвараа тэглэх Евро Азийн худалдааны түр хэлэлцээрээ гарын үсэг зурах гээд ингээд шийдэж байгаа юм байна.

Энийгээ засаагүйгээр тэгээд та бүхэндээ хэлье. Энэ Тамхины хяналтын хууль явах ёстой. Энэ тамхины татварын бодлого дээрээ Засгийн газар ч гэсэн адилхан анхаарах ёстой төрийн бодлого нийгмийн эрүүл мэндийг хамгаалах бодлого мөнгөний өмнө сөхөрч болохгүй шүү сайд нараа, гишүүдэд энийг л анхааруулж хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Номинчимэг гишүүний хэлж байгаа үгэн дээр би нэмж хэлж өгье гэж бодож байгаа нь энэ Улсын Их Хурлын гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд гараад маш идэвхтэй ажилласан. Монгол Улсад урьд өмнө нь бичигдэж байсан өнөөдөр хэрэгжиж байгаа хуулиудын бичилтийн хэлбэр агуулга, үзэл баримтлал, философи гээд маш олон зүйлийг нь өөрчилсөн.

Шинэчилсэн сайжруулсан ажлын хэсгийн үр дүнгүүд гарсан. 60 орчим ажлын хэсэг байгуулагдаж ажилласнаас хаврын чуулгандаа багтаж 18 ажлын хэсэг тайлан дүгнэлтээ гаргасан. Одоо гаргахад бэлэн болсон 15 орчим ажлын хэсэг байгаа юм.

Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүд маш идэвхтэй ажиллаж байна.

2 улирал гарны хугацаанд нийтдээ 30 гаруй ажлын хэсэг дүнгээ гаргана гэдэг бол дүгнэлтээ гаргана гэдэг бол маш сайн үзүүлэлт юм байгаа юм. Тэгэхээр энэ Улсын Их Хурлын гишүүдийн энэ идэвхтэй ажиллах энэ санал санаачилгыг Засгийн газрын холбогдох сайд нар дэмжиж хамтарч ажилламаар байна аа. Номинчимэг гишүүний хэлж байгаа үнэн. Зарим салбарын сайд нар зориудаар эс үйлдэхүй хийж хуулийн хугацааг дуусгах замаар хугацаа авч байгаа тохиолдлууд хүртэл гарч байгааг анхаарч ажиллах нь зүйтэй гэж бодож байгаа. Тэгээд энэ Улсын Их Хурлын гишүүд энэ гарсан ажлын хэсгийнхээ үр дүн гарахын төлөө ажиллана. Сая ТББХ хуралдсан юм байна. Одоо жишээлбэл ТББХ, ХЗБХ-н дээр Жагсаал цуглааны хуулийн ажлын хэсгийг яаралтай байгуулж ажилд нь оруулах шаардлага байна гэх мэтээр.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн ажлын хэсгийг байгуулж ажилд нь оруулах шаардлага байна гээд энэ дутагдаж байгаа зүйлүүдийг бүгдээрээ ажил хэрэг болгоод явъя гэсэн ийм байдалтай байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн түрүүн асуулт асуухаар нэр ирсэн байсан. Асуултаа асуучихаар тэгээд нэгмөсөн хариулт өгье. Пүрэвдорж гишүүн асууя.

**Б.Пүрэвдорж:** Би энэ Засгийн газрын хэрэгжүүлэгч хяналт хэрэгжүүлэх агентлаг 2023 онд байгуулагдсан тэгээд энэ Засгийн газрын хоорондын үйл ажиллагааг, ялангуяа яамдын агентлагийн нийслэл болон аймгуудын Засаг дарга төрийн өмчит болон орон нутгийн өмчит байгууллагуудын удирдлагуудад хяналт тавих энэ хуулийн хэрэгжилтийг хангах энэ үүрэг бүхий байгууллагыг эдийн засаг хөгжил хариуцсан Тэргүүн шадар сайд руу шилжүүлсэн нь буруу юм гэж санал гаргасан.

Гэвч МАН-ын бүлгийн шийдвэр гарсан учраас бүгд эсэргүүцэж миний саналыг унагаасан байгаа. Тэгэхээр Одбаяр гишүүний хүсэлтээр дахиад үг хэлье гэж бодож байна. Тэгэхээр энэ бол ер нь цаашдаа Учрал гишүүний харьяанд очсоноор яах вэ мониторинг энэ тэр нь Засгийн газар дээрээ үлдэж байх шиг байгаа юм.

Тэгэхээр Учрал сайдын яаманд очсоноор энэ цаашдаа мэргэжлийн хяналт байгуулагдах энэ их суурь болчих вий гэдэг ийм болгоомжлолыг хэлж байна. Тийм учраас энэ уул нь ЗГХЭГ дээрээ байх нь зүйтэй байсан юм гэдгийг хэлмээр байна.

Хоёрдугаарт нь зарим нэгэн МАН-ын Их Хурлын гишүүд АН-ын хяналтын менежерүүд энд тэнд очиж ажиллахдаа 30 тэрбум төгрөгийн зардал гаргасан гэж ярьж байна лээ. Тэгэхээр энэ нийтдээ 28 хяналтын менежер АН-аас сонгогдсон 29 хяналтын менежер хүн намаас сонгогдсон.

Нийтдээ 52 гуя дагуулаад хүзүү гэгчээр. 52 МАН-аас хяналтын менежер томилогдсон байдаг юм аа. Жишээ нь Эрдэнэт дээр 2, хүн намаас АН-аас 1-ийг тавьчхаад, 2 Ардын намаас тавьсан. Жишээ нь АТҮТ дээр Хүн нам, АН-аас 1-ийг тавьчхаад Ардын намаас 2-ыг тавих жишээтэй. Ингээд явчихсан юм аа. Тэгээд би өөрийнхөө хяналтын менежерүүдээс бүх цалингийнхаа гүйцэтгэлийг гаргаад ир гэсэн чинь дунджаар 868 сая төгрөгийн зардал гаргасан байна. Тэгэхээр ийм байдлаар энэ хяналтын менежер зөвхөн АН-аас тавигдсан юм шиг нийгэмд буруу ойлголт өгөх нь буруу юм гэж би та нарт хэлмээр байна.

Ер нь АН-аас сонгогдсон хяналтын менежер тухайн байгууллагууддаа хулгай зэлгийг тогтоох талаар маш их айдастай бо орчныг бий болгосон. Идэж хулгайлах нь ч багассан. Жишээ нь Тамир гэдэг хяналтын менежер очоод нийтдээ 1800 гаруй ажилтантай Тавантолгой төмөр зам болон МТЗ-ыг нийлүүлээд шүүмжлэл гаргасны үр дүнд тэр 2-ыг нийлүүлсний үр дүнд маш их олон ажлыг цомхотгох үр дүнгүй орон тоог цөөлөх ийм боломжийг нээж өгсөн.

Тэгэхээр МАН-ын хяналтын менежерүүд юу хийдэг вэ гэх дээр АН-ын менежерүүд дээр нэг ганц 2 шил юм авч орж ирээд л энэ хяналт мяналтаа багасгачхаач хамтдаа идье гэдэг ийм л зүйл ярьдаг юм байна лээ. Манай залуучууд бол маш сайн ажилласан гэдгийг энэ ташрамд хэлье. Ер нь нэг тийм өрөөсгөл байдлаар хэтэрхий байна. Энэ байдлаар энэ АН руу энэ хяналтын менежер зөвхөн Ардчилсан намаас сонгогдсон юм шиг ийм зүйл ярихаа МАН-ын гишүүд болих хэрэгтэй. Энэ дээр тодорхой баримтуудыг бид нар тоогоор нь, аль компанид, хэдэн хяналтын менежер томилогдсон гэдгийг нь бид нар бүгдийг нь гаргаж өгөд хариулаад явах боломжтой шүү.

Тийм учраас энэ дээрээ илүү юм яриад байвал тэрнээс олон юм ярина гэдгийг та нарт хэлж анхааруулъя аа.

**Д.Амарбаясгалан:** Сандагийн Бямбацогт сайд хариулт өгье.

Номинчимэг гишүүний асуулт болон Пүрэвдорж гишүүний асуултад хамтатган хариулъя аа.

**С.Бямбацогт:** Номинчимэг гишүүний асуултад эхлээд хариулъя.

Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан хуулийн төсөл Засгийн газраас санал өгдөг. 1 сарын хугацаанд өгөх ёстой. Энэ сарын хугацаандаа санал өгөөгүй бол Улсын Их Хурлын гишүүн хуулиа өргөн бариад явчих бололцоотой. Номинчимэг нарын гишүүдийн санаачилсан Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурал Засгийн газар дээр санал авахаар ирсэн санал. Урьд нь бэлдээд явуулахаар бэлдсэн байсан боловч нөгөө шинэ Засгийн газар бүрэлдээд шинэ Засгийн газар бүрэлдсэнтэй холбоотой урьд өмнө Засгийн газар хэлэлцсэн бүх хууль, тогтоолын төслүүдийг буцааж, шинэ сайд нараас байр суурь саналыг нь авахаар буцаагдаад өнөөдөр нэн яаралтай горимоор Мөнхбаатар сайд оруулж ирээд Засгийн газар саналаа бэлдсэн байгаа.

Тэгээд маргааш танд хүргүүлнэ. Та энэ хуулийн төслийг хэлэлцүүлээд явах бүрэн бололцоотой болно.

Цаашдаа бид нар Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүд дээр санал өгөх асуудал дээр хэзээ ч юу хугацаа хэтрүүлэхгүй богино хугацаанд саналаа өгч байх болно гэдгийг хэлье ээ.

Пүрэвдорж гишүүний ярьж байгаатай санал нэг байна аа. Бид нар юу гэдэг юм домог зохиогоод ингээд хуйлруулаад нөгөө жижигхэн юмыг том болгоод том юмыг жижигхэн болгоод ингээд үнэн худал нь мэдэгдэхгүй янз янзын яриа гаргадаг. Энэ танхимаас л гардаг тэгээд л ард түмэн түүнд итгээд л тэгээд л хямраад л бухимдаад л эргээд л үнэн юм шиг.

Нэг их олон хяналтын менежер томилчихсон юм шиг яриад байдаг. 400 гаруй хяналтын менежер томилсон. Хэдэн 100 тэрбумын зардал гарч байгаа гээд л ингээд ярьдаг. Энэ яриа энэ танхимаас л гарсан. Яг бодит байдал дээр тэр АН-аас 26, ХҮН намаас 28, АН-аас 26 хяналтын менежер. ХҮН намаас 28 бүтээмжийн менежер томилогдсон юм шиг байна лээ. Томилогдсон юм шиг байна лээ.

Тийм болохоор юу гэдэг юм цаашдаа тийм сөрөг хүчний хяналт байх ёстой. Ардын намаас 52. Цаашдаа бид нар тийм энэ хяналтын менежерүүд үнэхээр сайн ажиллаж байгаа хүмүүс байдаг юм бол хяналтаа хийгээд явна зүгээр орон тооны бөглөөс болоод очоод цалин аваад сул цалин аваад цагаа бүртгүүлээд явдаг байх юм ажлаас нь хариуцлага тооцох ёстой. Ийм зарчмыг ТӨК-уд дээр барьж шахаж шаардаж ажиллана. Илүү юу гэдэг юм хяналт байх ёстой. Хяналт байж байж илүү зардал буурна.

Хяналт байж байж бүтээмж нэмэгдэнэ, сайн хяналтаа тавьцгаагаарай.

Сайн хяналтаа тавьж байгаа хүмүүсийг чинь тийм үү ажлаа хийх бололцоогоор нь хангаж ажиллана. Харин хяналтаа тавихгүй цаг бүртгүүлээд цалин аваад ордноор зугаалаад яваад худлаа үнэн хов зөөгөөд янз янзын домог зохиогоод явдаг хүмүүс дээр хариуцлага тооцно.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж дууслаа. Зарчмын зөрүүтэй санал байхгүй учраас Улсын Их Хурлын гишүүдэд үг хэлэх дэг байхгүй. Тэгэхээр Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлах

санал хураалтыг явуулна. Хуулийн төслүүдийн эцэслэн батлуулах хувилбарыг ТББХ-оос бэлтгэн гишүүдэд тараасан байна. Гишүүд санал хураалцад бэлдье.

Алив гишүүд танхимд орж ирье. Хууль эцэслэн батална. Гишүүдийн ирц цуглалат дараачийн асуудлыг хэлэлцэж байя. Дараагийн асуудал энэ олон санал хураалттай учраас гишүүдийг танхимдаа цугласны дараа санал хураалтаа эхлүүлье.

#### Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудал.

Байнгын хорооны даргыг сонгох тухай асуудлыг ТББХ хэлэлцсэн байна. ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

#### **Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг ТББХ 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг танилцуулж байна.

ТББХ-ны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийн дарга Ж.Бат-Эрдэнэ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 дахь хэсэгт Байнгын хорооны даргыг сонгохдоо Улсын Их Хуралд сонгогдон ажилласан хугацаа, туршлагыг нь харгалзан тухайн Байнгын хорооны гишүүдээс сонгох бөгөөд түүнийг улируулан сонгож болно гэж заасны дагуу ТББХ-ны даргад Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага, төрийн ажлын мэдлэг, ур чадварыг нь харгалзан Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг нэр дэвшүүлсэн болно оо.

Цэндийн Сандаг-Очир нь 1977 онд Төв аймгийн Баяндэлгэр сумд төрсөн. Эхнэр 4 хүүхдийн хамт амьдардаг. 1995 онд нийслэлийн БНД-ийн 66 дугаар дунд сургууль, 2000 онд Тэнгэр дээд сургуулийг философич, нийгмийн ухааны багш мэргэжлээр суралцаж төгссөн. Философич Нийгмийн ухааны багш мэргэжилтэй. 2001 онд Удирдлагын академийг төрийн удирдлагын менежер, 2018 онд Удирдлагын академийг Төрийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн болно.

2000-2004 онд Нийслэлийн БНД-ийн ЗДТГ-ын 4 дүгээр хорооны нийгмийн ажилтан, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах мэргэжилтэн. 2005-аас 2008 онд Нийслэлийн БНД-ийн МАН-ын хорооны дэд дарга 2008-аас 2012 онд, 2016-аас 2020 онд Нийслэлийн БНД-ийн Засаг даргаар 2 удаа 8 жил ажилласан. 2013 оноос одоог хүртэл БНД-ийн МАН-ын хорооны даргаар сонгогдон ажиллаж байна аа.

Цэндийн Сандаг-Очир нь Дүүргийн ИТХ-ын төлөөлөгчөөр 2 удаа НИТХ-д төлөөлөгчөөр 2 удаа сонгогдож ажилласан. 2020 оноос Улсын Их Хурлын гишүүнээр 2 дахь удаагаа сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирын Улсын Их Хуралд сонгогдон ажилласан туршлага төрийн ажлын

мэдлэг ур чадвараар нь харгалзан Улсын Их Хурлын ТББХ-ны даргад нэр дэвшүүлсэн болно.

ТББХ-ны даргад Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг нэр дэвшүүлснийг хуралдаанд оролцсон гишүүдийн олох дэмжсэн болно оо.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Баярлалаа. Нэр дэвшигчтэй холбогдуулан гишүүд асуулт асууж үг хэлнэ. Асуулт асууж үг хэлэх гишүүд нэрээ өгье. Алга байна. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна аа.

Гишүүд санал хураалтад бэлдье.

Санал хураалт.

ТББХ-ны даргаар Цэндийн Сандаг-Очирыг сонгохыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

Санал хураалтад оролцсон гишүүдийн 59 гишүүн буюу 60.8 хувиар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны даргаар сонгох саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Байнгын хорооны даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцлоо.

Монгол Улсын Их Хурлын тогтоол байнгын хорооны даргыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.6, 25.7 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг Санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очирыг Улсын Их Хурлын ТББХ-ны даргаар сонгосугай.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Улсын Их Хурлын ТББХ-ны даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

ТББХ-ны даргаар сонгогдсон Сандаг-Очир гишүүнд ажлын өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. Их Хурлынхаа нийт гишүүний нэрийн өмнөөс.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулж үзье.

Хууль эцэслэн батлах учраас 64-өөс дээш гишүүн санал хураалтад оролцоно. Ирц бүртгэлийн санал хураалт.

Дараагийн асуудалд оръё.

Уучлаарай 7 дугаар асуудал.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хөххүүгийн Болормаа танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Х.Болормаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 6 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 06 сарын 23-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2025 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийн зүйл бүрээр нь хэлэлцсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гараагүй тул Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.24-д заасны дагуу хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Х.Булгантуяа:** Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн ажлын хэсгээр Жадамбын Энхбаяр ХХААХҮ-ийн сайд, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Даваасүрэнгийн Довчинсүрэн ХХААХҮЯ-ны Хүнсний үйлдвэрлэлийн БХЗГ-ын дарга, Даваасүрэнгийн Есөн-Эрдэнэ ХХААХҮЯ-ны ГТБХЗГ-ын дарга гэсэн ийм ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байна аа.

Улсын Их Хурлын гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батбаатараар тасалъя.

Улсын Их Хурлын гишүүн Баярмагнай Баярбаатар.

**Б.Баярбаатар:** Гишүүддээ оройн мэндийг хүргэе ээ.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болгох хууль Монгол Улсын Засгийн газраас яаралтай горимоор хэлэлцүүлэхээр дахин өргөн баригдаад өнөөдөр ингээд анхны хэлэлцүүлэг хийгдэж байна.

Өнгөрсөн удаад 64-ийг нь босгоо давж чадаагүй тэгээд дахиж өргөн баригдаад явж байна аа. Салбарын сайд холбогдох мэдээллүүдийг хангалттай бидэнд өгөөд тулгамдаж байгаа асуудлуудыг Байнгын хорооны болон бусад хурлууд дээр нэлээдгүй өргөн танилцуулаад явсан. Зүгээр ингээд бид нар энэ удаад энэ хуулиа дэмжээд явах нь зөв, үндэсний үйлдвэрлэл, дотоодын үйлдвэрлэл, газар тариалан эрхлэгчдийн асуудал гэж үзэж байгаа. Гол асуудал бид нар энэ эрх зүйн орчныг нэлээдгүй сайжруулах үүрэг байж байгаа. Тэгээд үүнийг бас сайжруулахтай холбогдуулаад бусад арга хэмжээг авах тухай дагалдах тогтоолыг батална гэж ойлгож байгаа.

Дээр нь өнөөдөр алслагдсан аймаг сумдуудын энэ улаан буудайн гурилын үнэтэй холбоотой асуудлууд байж байгаа. Мэдээж эндээс Улаанбаатар хотоос буюу үйлдвэрээсээ холбогдох үнээр гарч байгаа ч гэсэн тээврийн зардал бусад зардлууд нь нэмэгдээд алслагдсан аймаг буюу ялангуяа баруун аймгуудын хэрэглэгчдэд гурилын үнэ нэлээн өндөр үнэтэй. очихоор ийм нөхцөл байдал байгаа.

Энэ дээр салбар ямар бодлого гаргах вэ? Энэ дээр нэг хариулмаар байна. Дээр нь энэ Баяжуулсан хүнсний тухай хууль гэж нэг хууль байгаа юм Энхбаяр сайд аа. Энэ хуулийг яаж хэрэгжүүлэх вэ. Эс үгүй бол хэрэгжилт нь хангалтгүй гэж үзэж байгаа тодорхой нэмэлт, өөрчлөлтийг оруулж сайжруулах зайлшгүй шаардлага байна уу гэж хараад байгаа.

3 дугаар асуулт энэ лаборатори улаан буудайг чанарыг үнэлэх энэ лабораторийн яг хууль тогтоогч нь яаж чиглүүлэх вэ. Гурилын үйлдвэрүүд дэргэдээ лабораторитой тэрийг баталгаажуулж явах юм уу, эс үгүй бол хүнсний аюулгүй байдлын үндэсний лабораторийн дүнг баталгаажуулж явах юм уу гэдгийг нэг чиг болгохгүй бол нөгөө тариалан эрхлэгчид маань ингээд яг энэ үзэмжээр хандаад байна ч гэдэг юм уу нэг ийм нөхцөл байдал үүсээд асуудлыг жоохон буруу тийш нь

эргүүлээд ингээд яваад байгаа зүйл байгаад байгаа юм аа. Тэгээд энэ 3 асуулт дээр та нэг хариулт өгөөч гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Энэ асуудал нэлээн маргаан дамжуулж нэлээн хугацааг өнгөрлөө. Ингээд хэлэлцүүлгийн үр дүнд энэ салбарт байгаа олон асуудлыг сайжруулах талаар гишүүд үнэтэй саналуудаа гаргаж энэ хуультай холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг мөн боловсруулж ингэж өргөн барьж байна. Гол асуудал болж байсан баруун бүс дэх үнийн өсөлт ялангуяа малын тэжээлийн тогтвортой байдлыг хангах энэ зайлшгүй шаардлагуудыг гишүүд их саналыг хэлэлцүүлэг хугацаанд гаргалаа. Тэгээд хэрвээ энэ хууль батлагдсан нөхцөлд дагаж гарах Их Хурлын тогтоолд баруун бүс нутгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх, гурил тэжээлийн үйлдвэрлэл, хангамжийн тогтвортой байдлыг бий болгох төлөвлөгөө гаргаж 2026 оны Улсын Их Хурлын батлах төсөвт өргөн барьж шийдвэрлэхээр ингэж орсон. Мөн алслагдсан бүс нутгийн гурил тэжээлийн үйлдвэрлэлийн хангалтыг хэвийн түвшинд хүртэлх хугацаанд үнийн өсөлтөд нөлөөлж байгаа гол энэ тээврийн зардлыг бууруулах, шаардагдах гурил, малын тэжээлийг тухайн бүсийн хилийн боомтоор квот тогтоон оруулж нөөц бүрдүүлэх хангалтын тогтвортой байдлыг бий болгох гэх мэтийн ийм үүргүүдийг авсан.

Ингээд лаборатори дээр болохоор бүх гурилын үйлдвэр улсын нөөцийн байгууллагууд дээр суурилсан лабораториудыг үндэсний лавлагаа лабораториор сорилтоор бүрэн баталгаажуулж энэ жилийн үр тариа хурааж авах үйл ажиллагаанд ашиглахаар ингээд шийдвэрлэж байгаа. энэ үндсэндээ бид энэ зохион байгуулалтаа хийгээд шаардлагатай лабораторийн хангалт хийгдээд дууссан. Ямар нэгэн алдаа гарахгүйгээр энд энэ жилийн улаан буудайн чанарын үзүүлэлтүүдийг хангаж чадах байх гэж бодож байна.

Гурав дахь Баяжуулсан хүнсний тухай хуультай холбоотойгоор яг энэ гурилыг баяжуулж ард иргэдийн иргэдэд хэрэгтэй эрдэс бодис шаардлагатай минералыг гурилтай хольж баяжуулж хэрэглээнд гаргах ийм хууль байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдсантай холбоотойгоор бид нар гурилын үйлдвэр дээрээ энэ баяжуулсан хүнсний хуулийг хэрэгжүүлэх ажлаар нэлээн дорвитой арга хэмжээ авч хэрэгжүүлэх болно.

**Д.Амарбаясгалан:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн алга байна. Жамбалын Ганбаатар гишүүн алга байна. Ганбатын Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Өдрийн мэнд. 2 сар хүрэхгүй хугацааны өмнө энэ хуулийн төсөл орж ирсэн юм. Тэгээд энд байгаа Их Хурлын гишүүд, аймаг, бүс янз бүрийн юмаараа нийлж байгаад энэ хуулийн төслийг унагаасан юм л даа. Тэгээд ямар ч байсан ингээд Засгийн газраар дахиад өргөн бариад ороод ирлээ. Тэгээд ер нь Энхбаяр сайд бид ер нь Монгол Улс цаашаа энэ аж үйлдвэрийн салбараа ялангуяа энэ уурхайгаас салаад эдийн засгаа сонгож солонгоруулахын тулд энэ МАА-н салбар газар тариалангийн салбараа дэмжиж явах ёстой шүү дээ тэ? Энэ концепцыг бол 2024 оны 4 сард эвдсэн. Зөвхөн сонгуульд зориулж Монголын ард иргэдийг ашиглаж

нэмүү өртөг шингээдэг энэ аж үйлдвэрийн салбарыг нэг өдөр устгасан. Тэгээд жилийн дараа оруулж ирсэн.

Энэ буруу байсан юмыг оруулаад ирэхээр одоо дахиад энэ буруу гэж шийдвэр гаргачхаад дахиад 2 сарын дараа зөв юм гээд бүгдээрээ хэлээд ороод ирж байгаа юм. Тэгээд энэ Монгол төрийн бодлого чинь ер нь ингэж явах юм уу. Цаашдаа аман дээрээ бүгдээрээ ярихдаа аж үйлдвэрийн салбараа дэмжье, эдийн засгаа солонгоруулъя, газрын доорх баялгаа эцсийн бүтээгдэхүүн болгоё экспортод гаргая гэж ярьдаг мөртөө начир дээрээ болохоор яг ингээд нутаг усаараа нийлээд сум орон нутгаараа нийлээд лобби хийж ийм шийдвэр гаргадаг. Тэгээд энэ байдлыг нь хэзээ зогсоох юм. Тэгээд энэнтэй холбоотой би тэр ажлын хэсэгт орж ажилласан Энхбаяр сайд аа. Энэ монополын эсрэг газраас Монголын үйлдвэрлэгч нарыг нийлээд сүүлийн 2021 оноос хойшоо 101 тэрбум төгрөгийг авсан. Хөнгөлөлттэй зээлээр тэгээд нийлж үнэ зохиодог гэсэн ийм юм явж байгаа. Та энэ Монополын эсрэг газартай ер нь уулзалт хийж энэ дүгнэлттэй нь холбоотой асуудлууд дээр ярилцсан уу? Бас нэг ийм ажлын хэсэг гарсан. Бас л ингээд эсрэг дүгнэлт гаргасан байна лээ. Мөн дээрээс нь Монголын энэ гурил үйлдвэрлэгч нарын гурилынх нь чанар муу байна гэсэн ийм дүгнэлт байгаад байдаг. Тэгээд энэ мэнэтэй та яг танилцсан уу? Эхлээд энийг би асуучихъя. Тэгж байгаад цаашаа тодруулъя даа.

**Д.Амарбаясгалан:** Хариулт өгье. Жадамбаагийн Энхбаяр сайд.

**Ж.Энхбаяр:** Уул уурхайгаас ингээд эдийн засгийг босгоход гол тулгуур нь ХХААХҮ-ийн салбар болох ёстой. Тэгэхээр энд чиглэсэн бодлого бол тогтвортой байх нь зүйтэй. Энэ гурилын асуудалтай холбоотойгоор хэлэлцүүлэг их өргөн хүрээг хамарч яригдлаа. Тэгэхээр энэ нь зөв энэ нь буруу гэж хэлэх туйлшрах шаардлага салбар хариуцаж байгаа хүний хувьд алга байна. Бид бас энэ дотор дутуу юмаа олж авлаа. Энэ хууль бас өөрөө тэр бүс нутгийн өвөл хаваржилтын хүндрэлийг даван туулахад тодорхой үүргээ амжилттай гүйцэтгэсэн. Гэхдээ нөгөө талдаа сөрөг нөлөөлөл буюу төвийн бүсийн газар тариалангийн бүсэд ялангуяа улаан буудайн тариалалтад сөрөг нөлөө үзүүлчихлээ. Гурилын үйлдвэрүүд маань ч гэсэн өөрсдийн чанар энэ лаборатори гээд олон зүйл дээрээ дор дороо л эргэн харж дор дороо нэгийг дүгнэж байна.

Тэгэхээр энэ хэлэлцүүлгийн гол үр дүн бол салбар өөрөө цаашдаа ил тод, тодорхой, ойлгомжтой, хаа хаанаа чанар нөгөө талдаа хэрэглэгчдийн эрх ашгийг хангах үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх гээд олон зүйлүүд байгаа. Гэхдээ энэ зүйлийг ингээд орхих ёстой юм биш гол асуудал энэ байна. Худалдаан дээрх үнийн өсөлтийг л бүгдээрээ нэг зохицуулж энэ худалдааны хууль эрх зүйн зохицуулалтыг хийхгүй бол тариаланчдаас үйлдвэрлэгчид ирээд үйлдвэрлэгчдээс эцсийн бүтээгдэхүүн худалдаж байгаа байдал дээр үнийн өсөлт нэг айхтар зүйл алга байна.

Борлуулалт дээр үндсэндээ бид нар аль сум, аль аймагт хэдээр хөрс зарахыг үйлдвэрлэгч ерөөсөө тэнд зохицуулалт хийж чадахгүй байгаа юм. Тэгэхээр зарим газар 50 хувь нэмж байна, зарим газар 30 хувь нэмж байна. Гол үнийн өсөлт гээд байгаа зүйл яг энэ худалдаан дээр гараад байгаа юм. Тэгэхээр нөгөө талдаа өргөн дэлгэр газар нутаг гурил маань өөрөө хямд үнэтэй бүтээгдэхүүн. Тээврийн зардал их өндөр өртөг шингэж байгаа байдал байна. Ингээд олон талын л асуудлууд энэ их тодорч гарч ирж байна л даа.

Тэгэхээр сая энэ асуудалд оролцогч бүх талууд л өөр өөрсдийн давуу тал сул тал олон юмаа авч нөхөж, ойлголцож, тайлбарлаж, тэгээд цаашдаа авч хэрэгжүүлэх арга хэмжээгээ Улсын Их Хурлын тогтоол болгож ингэж арваад зүйл заалт бүхий энэ Их Хурлын тогтоол гаргаад Засгийн газарт үүрэг даалгавар өгч байгаа нь энэ хэлэлцүүлгийн гол үр дүн болж байгаа юм аа.

**Д.Амарбаясгалан:** Ганбатын Очирбат гишүүн тодруулж асууя.

**Г.Очирбат:** Тэгээд Монгол төрийн бодлого тогтвортой баймаар байгаа юм. Энэ аж үйлдвэрийн салбараа дэмжинэ гэж байвал дэмжсэн шиг дэмжээд энэ хүнс хөнгөн үйлдвэрийнхээ салбарыг дэмжвэл дэмжсэн шиг дэмжээд явахгүй бол ийм бөөрөнхий баймааргүй байгаа юм. Үгүй тэгээд олон талын санал гэж та яриад та тэгж ерөөсөө ярьж болохгүй шүү дээ. Та бол сайд. Манай яамны бодлого ийм байгаа. Тэгэхээр бид нар энийг аваад явах ёстой, энэ салбараа хөгжүүлэх ёстой. Харин энэ ирээд байгаа асуудлуудыг аваад шийдээд ийм зохицуулалтыг нь ингээд өөрчлөөд сайжруулаад явж байгаа шүү л гэдэг тайлбар хэлэх ёстой шүү дээ та.

Тэгэхээр ер нь энэ аж үйлдвэрийн салбараа хөгжүүлэх ялангуяа энэ хөнгөн үйлдвэрийн салбараа хөгжүүлэх тал дээр өшөө анхаарч ажиллахгүй энд нь явж байгаа хэдэн компаниудыг нийлж байгаад харлуулдаг муугаар хэлдэг. 1-д.

Хоёрт гэх юм бол тэр компаниуд нь ч гэсэн хариуцлагатай байх ёстой. Хоорондоо үгсэн хуйвалдаад үнэн дээр тоглодог ийм байж болохгүй шүү дээ. Тэгэхээр энэ бид нар олон улсынхаа жишгийг дагамаар байгаад байгаа юм. Энэ компаниудыг бойжуулаад босгоод.

**Д.Амарбаясгалан:** Очирбат гишүүнд нэг минут нэмж өгье. Компаниудаа нэгэнт бодлогоор дэмжээд бойжуулаад босгоод ирсэн бол дараагийнх нь компаниуд нь боломж олгодог энэ систем рүү ормоор байна Энхбаяр сайд аа. Тэгэхгүй бол ерөөсөө 1 ийм л яриа үүсчихсэн байна шүү дээ. Нэг хэдэн гурилын компани байдаг. Шинээр гурилын үйлдвэрлэл хийгээд орж ирэх гэхээр тэд нар шахуулаад дуусчихдаг. Нөгөөдүүл нь тариаланчдаа барьчихсан, зээлээр ингээд бүүр барьчихсан тэгээд ийм тогтолцоо цаашаа үргэлжлээд байх юм бол энэ салбар чинь бас яг бодитойгоор энэ чөлөөт эдийн засгийнхаа зарчмаар хөгжихгүй байна шүү гэдгийг танд хэлэх гэсэн юм аа.

Тэгээд ямар ч байсан энд байгаа Их Хурлын гишүүд энэ аж үйлдвэрийн салбар хүнсний энэ хөнгөн үйлдвэрлэлийн салбарыг дэмжиж энэ удаа саналаа өгөөрэй гэж хүсье. Урьд нь нэг удаа би өгсөн.

Тэгээд олонхоороо гэдэг юм уу орон нутгаараа нийлж бойкотолж энэ бүхэл бүтэн үйлдвэрлэлийн салбар, гурилын салбар газар, тариаланч нарын салбарыг унагаасан шүү. Бүгд нэг дэмжчихээрэй гэж хүсэх гэсэн юм. Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Асуулт давхардсан байна. Бадамсүрэн гишүүн өчигдөр асуугаад тогтоолын төсөл гаргуулна гэж шийдсэн. Нэрийг нь хасчихъя. Доржзовдын Энхтуяа гишүүн асуулт асууя.

**Д.Энхтуяа:** Ер нь бол энэ хүнсний хувьсгал гээд Ерөнхийлөгчийн зүгээс Хүнсний хувьсгал үндэсний хувьсгал юм гэсэн ийм улс орон даяар ийм уриалгатай том ажил явсан. Харамсалтай нь энэ 2024 оны энэ 4 сарын 19-нд батлагдсан энэ хууль бол яг одоо дотоодын ААН-үүдээ энэ хүнсний хувьсгалыг боомилсон ийм зүйл болсон гэж миний хувьд харж байгаа юм. Тэгээд би ХАА-н сайдтай газар дээр нь очиж үзсэн л дээ.

Тэгэхээр ингээд нэг ийм тогтворгүй байдал түрүүн бас Очирбат гишүүн хэлж байна. Энэ тогтворгүй байдал энэ улс орны энэ хувийн ААН-үүдээ маш их гай болдог. Тэгээд газар тариалан МАА-г хөгжүүлбэе гурилын үйлдвэрийг дотооддоо хүнсээ хангая гээд л ингээд л маш олон сайхан уриалгууд гардаг боловч бид нарын өнөөдөр байж байгаа царай энэ л байна. Тэгээд жилийн дараа дахиад энийгээ өөрчлөх гээд 2 удаа ингээд оруулаад ирж байна аа. Тэгэхээр энэ хариуцлагагүй байдал бол хэзээ цэгцрэх юм бэ гэсэн нэг ийм асуулт байна.

Хоёрт нь ХАА-н сайд аа та бид нар яваад үзэж байхад олон үйлдвэрүүд ерөнхийдөө хаалгаа барилаа. Маш их олон бүтээгдэхүүнээ татсан байсан энэ бүтээгдэхүүнийг ажиллуулах боломжгүй болчихлоо гэсэн ийм нөхцөл байдалтай байсан. Энэ хууль батлагдсанаараа энэ үйлдвэрүүд буцаж сэргэх боломж байгаа юу? Ер нь ямаршуухан ийм судалгаа явагдсан бэ? Бүгдээрээ л ажилчдаа явуулчихлаа. Энэ олон нөөцөлсөн бүтээгдэхүүнүүдээ гурил үйлдвэрлэх ямар ч боломжгүй боллоо гэсэн ийм л нөхцөл байдалтай хаалгаа барилаа гэхихсэн ийм байж байсан шүү дээ тиймээ.

Тэгэхээр энэ дээр эргэж сэргэх боломжийг нь судалсан уу та бүхэн.

Хоёрт нь маргааш Евро Азийн энэ худалдааны гэрээ хэлэлцээр батлагдах ийм гарын үсэг зурах гэж байгаа юм байна. Тэгэхээр энэнтэй холбоотойгоор бас энэ ААН-үүдээ хамгаалах энэ Евро Азийн худалдааны гэрээтэй холбогдсон хамгаалах асуудлаар та бүхэн ямар арга хэмжээ авч байгаа вэ? Эргээд дахиад нэг асуудал нь энэ дээр ингээд шийдэгдэж байтал нөгөө талаасаа дахиад энэ сэргэх гэж байгаа энэ гурилын ААН-үүд аж ахуй дотоодын ААН-үүд маань эргэн сэргэх ийм боомилох асуудал гарах вий гэсэн ийм болгоомжлолын үүднээс би танаас энэ асуултыг асууж байна. Юуны хувьд бол саналын хувьд бол дэмжиж саналаа өгнө өө.

**Д.Амарбаясгалан:** Жадамбаагийн Энхбаяр сайд хариулт өгье.

**Ж.Энхбаяр:** Энхтуяа гишүүний асуултад хариулъя аа.

Евро Азийн эдийн засгийн холбоотой хийх хэлэлцээрт газар тариалангийн салбарын хамгаалалтыг сайтар суулгасан. Гурил болон улаан буудай малын тэжээл дээр энэ гэрээний үйлчлэл үйлчлэхгүй байхаар тодорхой хэмжээний квотын буултыг бид хийсэн. Тэр буулт хийсэн 50 мянган тонн хүртэлх үр тариагаа Монголын үндэснийхээ будааг сайжруулах Монголд тарьдаггүй хатуу улаан буудайгаар орц жорлох үүднээс ингэж авах хэмжээнд зохицуулалтаа хийсэн.

Тэгэхээр энэ улаан буудай гурилын үйлдвэрлэл энэ Евро Азийн гэрээ нөлөөлөхгүй.

Хоёрдугаарт үйлдвэрлэл сэргэлт энэ жилийн тухайд бол жоохон уналт байгаа. Үндсэндээ 150 орчим мянган тонн улаан буудайн үйлдвэрлэл багаслаа. Тариалалт 120-иод мянган га-ийн тариалалт багаслаа. Энэтэй холбоотойгоор нэг дунджаар 150 мянган тонн үр тариа намар гэхэд дутах байх. Тэгэхээр бид энийг тодорхой хэмжээнд эх үүсвэрийг төсөвт суулгаж импортоор хангах энэ бодлогыг авч хэрэгжүүлэхээс аргагүй ийм байдалд орсон.

Өнөөдрийн энэ хууль гарч байгаа нь бид нар одоо яг талбайн боловсруулалт, ирэх жилийн тариалалт талбай бэлдэж байгаа юм. Тэр талбайн тариалалтыг талбай бэлтгэлийг, уриншийг идэвхжүүлэх, ирэх жил тарих тэр нөхцөлийг бүрдүүлэх энэ үүднээс цаг алдалгүй ингээд дахиад явуулах дараагийн технологит ажил ингээд тулчхаад байгаа. Ингээд энэ бол их хаа хаанаа их сургамжтай нэг ийм хуулийн өөрчлөлт хуулийн хэлэлцүүлэг тэгээд дахин өргөн барьж байгаа үйл явдал болж байна. Тэгээд цаашдаа ахиж ийм зүйл давтагдахгүй байх гэж найдаж байна.

Дэмжиж байгаад баярлалаа танд.

**Д.Амарбаясгалан:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Санал хураалт.

Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Ирц, бүртгэл. Санал хураалтын бэлтгэл хангая.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя, бэлтгэл хангасан уу?

Гишүүд санал хураалтынхаа бэлтгэлийг хангасан уу? Хурууныхаа хээг уншуулчих. Ирц бүртгэлийн санал хураалт явуулаадахъя.

44 гишүүн санал хураалтад оролцсон байна. Ирц дутуу байна. Байнгын хорооны гаргасан горимын саналаар санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэгдсэн байгаа. Байнгын хорооны саналаар Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

57 гишүүн буюу 58.2 хувиар горимын санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн тул Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг эцэслэн батлах асуудал яригдана.

Тэгээд өмнөх хуулийг эцэслэн батлах асуудал хүлээгдэж байгаа. Гишүүд нийт гишүүдийн олонх.

Гишүүд чуулганы танхимдаа цуглая.

Санал хураалт.

Улсын Их Хурлын гишүүд танхимдаа орж ирье.

Санал хураалт.

Бүртгэлтэй 98 гишүүн байгаа. 64 саналаар санал дэмжигдэнэ. Санал хураалт.

Ирц бүртгэлийн санал хураалт явуулъя.

Ирц бүртгэлийн санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан байна.

Санал хураалт Энхбаяр сайд хураалгах уу?

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураахаар байгаа.

Энэ хууль энэ жил ган гачиг болж байгаатай холбоотойгоор зайлшгүй батлах шаардлагатай байна гэж Засгийн газраас үзэж, дахин өргөн барьсан байгаа гэдгийг тодруулж хэлье ээ.

Ингээд эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Хууль тогтоолын нийт 71 гишүүн буюу 72.4 хувиар хууль эцэслэн батлагдлаа.

Хууль тогтоолын төслүүдэд батлагдсан.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье ээ.

Дараачийн асуудал санал хураалт руу оръё.

Ес дүгээр асуудал буюу Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн санал хураалт үлдсэн байгаа.

Санал хураалт руу оръё.

Одоо энэний дараа сонсоно. Эцсийн хэлэлцүүлэг явагдаж дууссан. Одоо санал хураалт эхэлнэ.

Ес дүгээр асуудал.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2-т нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол хууль эцэслэн баталсанд тооцно гэж заасан.

Санал хураалт.

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

69 гишүүн дэмжиж 70.4 хувиар дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

70 гишүүн буюу 71.4 хувиар санал дэмжигдлээ.

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ чинь уначихлаа. 59 гишүүн дэмжсэн байна.

Хууль эцэслэн батлагдсангүй. 64-өөр.

Дуламын Бум-Очир гишүүн горимын санал.

**Д.Бум-Очир:** Дэмжиж санал өгсөн боловч дэмжсэнд орсонгүй. Татгалзсан дээр миний нэр орчихсон байх юм. Горимын санал гаргаж дахиж санал хурааж өгөхийг хүсэж байна аа.

**Д.Амарбаясгалан:** Бум-Очир гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 65.3 хувиар санал дэмжигдлээ.

Үндсэн санал хураалтыг дахин явуулъя.

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

Энэ чинь ямар үр дагавартай билээ?

Дондогмаа дарга.

Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт нь орчихсон. Нөгөө Хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт нь орохгүй бол хууль хоорондын зөрчил үүсэх л асуудал болох юм байна л даа.

Булгантуяа гишүүн горимын санал гаргая.

**Х.Булгантуяа:** Их Хурлын дарга аа сая энэ төхөөрөмж юу яагаад би жоохон хоцорчихлоо санал хураалтаас. Дахин санал хураалт хийж өгнө үү? Саяын санал хураалтыг хүчингүйд тооцож дахин санал хураалт явуулж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Сүүлийнх шүү. Одоо дахиж хэдүүлээ горимын санал ингээд дахин дахин хураагаад явах бас зарчимгүй зүйл болно. Булгантуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт.

64 гишүүн буюу 65.3 хувиар горимын санал дэмжигдлээ.

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

65 гишүүн буюу 66.3 хувиар санал дэмжигдлээ.

4.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

66 гишүүн буюу 67.3 хувиар санал дэмжигдлээ.

5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураана.

Санал хураалт.

63 гишүүн буюу 64.3 хувиар санал дэмжигдсэнгүй.

Пүрэвийн Батчимэг гишүүн горимын санал гаргая.

**П.Батчимэг:** Хоцорчихлоо.

Горимын санал гаргая. Саяын саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт хийж өгнө үү.

**Д.Амарбаясгалан:** Пүрэвийн Батчимэг гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 65.3 хувиар санал дэмжигдлээ.

5 дахь санал хураалт.

Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

68 гишүүн буюу 69.4 хувиар санал дэмжигдлээ.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа.

Санал хураалт.

67 гишүүн буюу 68.4 хувиар санал дэмжигдлээ.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

65 гишүүн буюу 66.3 хувиар дэмжигдлээ.

8.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

69 гишүүн буюу 70.4 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд хууль тогтоолын төслүүд батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд Ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье.

Дараагийн асуудалд орно. Энэ нөгөө тийм Гаалийн албан татварын хууль батлагдсантай холбогдуулаад энэ эцсийн найруулгыг сонсгочихмоор байна.

Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүд байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо. Энэ хуулийг дагаж гарах тогтоолын төслийг хэлэлцэнэ.

### Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсьё

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3-д Улсын Их Хурал Энэ хуулийн 46.1.2-т заасан хууль тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх гэж заасны дагуу хууль тогтоолын эцсийн найруулгыг байнгын хороод бэлтгэж Улсын Их Хуралд танилцуулахад бэлэн болсон байна.

1.Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дагалдан гарсан

Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо

3.Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

5.Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

6.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

7.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

8.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу?

Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

“Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Ингээд 8 дахь асуудал руугаа эргэж оръё.

Хууль батлагдсантай холбогдуулан дагаж гаргах тогтоол.

[Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.](#)

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Жигжидийн Батжаргал гишүүн танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Ж.Батжаргал:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хорооны 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал, дүгнэлт гарган та бүхэндээ танилцуулж байна аа.

Тогтоолын төсөлд МАА-н салбарыг эрсдэлээс хамгаалах хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих, үнийг зохистой түвшинд тогтворжуулах зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилын гаалийн албан татварыг чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонтой холбогдуулан тухайн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэл, хангалт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын стратегийн нөөцийг 100 мянган тонн улаан буудайгаар бүрдүүлэх, мөн гурилын үйлдвэр, үйлдвэрүүдэд нийлүүлэх хүнсний улаан буудайн чанарыг итгэмжлэгдсэн лабораторийн сорилт үр дүнд үндэслэн баталгаажуулах, суурилагдсан гурилын үйлдвэрүүдийн хүчин чадал ашиглалтыг нэмэгдүүлж улаан буудайн гурил үр тариаг экспортлох боломжийг бүрдүүлэх, баруун бүсийн газар тариалангийн үйлдвэрлэлийг сэргээх болон гурил тэжээлийн хангамжийн тогтвортой байдлыг бий болгох үнийн өсөлтөд нөлөөлж буй тээврийн зардлыг бууруулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгож болголоо.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар улсын стратегийн нөөцөд шаардлагатай улаан буудайн нөөцийн хэмжээ болон алслагдсан бүс нутгийн гурил тэжээлийн үнийн өсөлтөд нөлөөлж байгаа тээврийн зардлыг хэрхэн бууруулах талаар асуулт асууж хариулт авсан болно. Байнгын хорооны хуралдааны санал хураалтын дүнд үндэслэн “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлье.

**П.Сайнзориг:** Баярлалаа. Би энэ тогтоолыг агуулгын хувьд дэмжиж байгаа юм аа. Тэгэхдээ 1 зүйлийг хэлмээр байна. Энэ гурил үнэтэй холбоотойгоор зохисгүй байдлаар ч гэдэг юм уу нэмж байгаа энэ асуудал дээр татварын бодлогоосоо гадна өрсөлдөөний хууль тогтоомжийг сайжруулъя гэдэг саналыг өмнөх уг хуулийн төслийг хэлэлцэж байхад хэлж байсан гишүүдийн нэг байгаа. Тэгэхээр энийгээ илүү их онцгой анхаарах нэг шаардлага байгаа.

Хоёрдугаарт ер нь зүгээр энэ тогтоол дээр яг өгөх чиглэлүүдийг бас бид нар хууль тогтоомжийн хүрээнд баймаар байгаа юм аа. Өөрөөр хэлэх юм бол одоо 4 дүгээр заалт байна л даа. Гурилын үйлдвэрийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлж, улаан буудайн гурил үр тариаг татварын хөнгөлөлттэй нөхцөлөөр экспортлох боломжийг бүрдүүлэн ажиллах гээд Засгийн газарт байгаа.

Тэгэхээр энэ Засгийн газарт яг энэ асуудлыг зохицуулах эрх хэмжээ нь хуулиараа байгаа эсэхийг дээр сайн мэдэхгүй байна. Тэгэхдээ энэ татварын асуудлыг тэндээ бүрдүүлж ажилла гэхэд чинь өгч байгаа чиглэл хэр оновчтой байгаа юм. Сайн мэдэхгүй байна.

Хоёрдугаарт энэ яаралтай горимоор өргөн барих энэ асуудлыг яах вэ бас энэ тогтоол дээр ч ингэж оруулж өгөх шаардлага байгаа юу үгүй юу тухайн үедээ Засгийн газар өөрөө хууль тогтоомжийнхоо хүрээндээ асуудлаа шийдээд яримаар байгаа юм аа. Тэгээд. Ер нь зүгээр энэ боловсруулалтын юмнуудыг анхаарахгүй бол сүүлийн үед энэ хууль давсан хууль дээр байгаа зохицуулалтыг давсан ийм Улсын Их Хурлын тогтоолууд чиглэл өгөх байдлаар гарч байна. Тэгээд тэрийгээ Засгийн газар нь хуулиа хэрэгжүүлэх хэцүү, тогтоолоо хэрэгжүүлэх хэцүү. Ингээд яг олон нийт тэрийг чинь ялгаж салгахгүй байгаа юм. Эцсийн дүндээ хууль өөрөө эргээд Улсын Их Хурлын тогтоолоос давуу хүчин чадалтай байгаа. Тэгээд ийм зөрчилтэй ч гэдэг юм уу тэрийг нь зарим ингээд улс төрийн арга хэрэгсэл болгоод яваад байх тохиолдлууд мэр сэр өөр салбарууд дээр гараад байна тэгэхээр энийгээ цаашдаа анхааръя гэдэг зүйлийг хэлмээр байна.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье.

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Ирц хангалттай байна.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

54 гишүүн буюу 54.5 хувиар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа. Улсын Их Хурлын гишүүд ажлын хэсгийнхэнд талархал дэвшүүлье ээ.

Эцсийн найруулгыг сонсгоё.

Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Дамдины Цогтбаатар гишүүнийг дэмжсэнээр протоколд тэмдэглээ.

Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Дараачийн асуудалд оръё 4 дэх асуудал.

18 цаг болсонтой холбогдуулаад өнөөдрийн зорилго тавьсан хэлэлцэх асуудал хараахан дуусаагүй байгаа тул чуулганы хуралдаанаа үргэлжлүүлж хэлэлцэх асуудлаа дуусгах саналтай байна. Дэмжиж байна уу гишүүд. Дэмжиж байгаа гишүүд гараа өргөчихье. Баярлалаа.

100 хувийн саналаар дэмжигдлээ.

Чуулганы хуралдааныг сунгаж хуралдууллаа.

4 дэх асуудал Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Энэ Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 3 төслийг дараалан хэлэлцэнэ.

Тийм учраас эдгээр төслүүдийг гурвууланг нь хэлэлцүүлээд санал хураалтыг нэг мөсөн явуулна. Гэхдээ өнөөдөр явуулна. Яагаад гэхээр энэ санал хураалт хойшлох тусмаа одоо энэ дараа дараачийн 7 хоногуудад хэлэлцэх асуудлуудад эрэмбэ дараанд өөрчлөлтүүд орно.

Хаврын чуулган завсарлаж амжихгүй нөхцөл рүүгээ явах талтай.

[Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.](#)

Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Лхагвын Мөнхбаатар, Одонгийн Цогтгэрэл нарын өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа. Мөн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна аа.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин танилцуулна. Индэрт урьж байна.

**Х.Тэмүүжин:** Улсын Их Хурлын дарга эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд суудал бүхий 5 намын төлөөлөл санаачилж Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуульд Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хурал хадгална. Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монгол ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох мөн сонгож байгуулсан төрийн эрх байгуулагчид төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ гэж зааснаар Монгол Улс байнгын ажиллагаатай нэгд танхим бүхий парламентын БНУ болсон бөгөөд парламентын ардчилалыг Үндсэн хуулиараа тогтоон баталгаажуулсан юм аа.

Монгол Улсын Ерөнхий сайд нь Засгийн газрыг удирдаж төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн нэгд заасанчлан Засгийн газар нь төрийн гүйцэтгэх дээд байгууллага байна аа. Ерөнхий сайд нь Улсын Их Хурлаас томилогдож түүний шууд хяналтад үйл ажиллагаа явуулах нь парламентат ёсны гол илэрхийлэл болдог.

Энэ хуулийн төслөөр үндсэн 2 асуудлыг хөндсөн бөгөөд 1 дүгээрт нь одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Дэгийн хуульд байгаа Ерөнхий сайдын мэдээллийн цагийг Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчилсөн.

Улсын Их Хурлын асуулгын цаг болгон өөрчилсөнтэй холбогдуулаад Ерөнхий сайд юу хүссэнээ Улсын Их Хуралд ярьдаг биш Улсын Их Хуралд цаг үеийн асуудал болон Улсын Их Хурлын гишүүдийн юу асуухыг хүсэж байгаа тэр асуудлаараа Ерөнхий сайдаас асууж Ерөнхий сайд мэдээлэл өгдөг энэ тогтолцоо руу шилжинэ.

Хоёрт нь төрийн алба хаагчид буюу Улсын Их Хуралд мэдээлэл өгч байгаа албан тушаалтнууд парламентыг хуурдаггүй байх худал мэдээллээр хангадаггүй байхад чиглэсэн өөрчлөлтийг энэ хуулиар оруулсан байгаа.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ,

Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын дэгийн тухай хууль, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал болгож байгаа хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү?

**Д.Амарбаясгалан:** Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн ТББХ-ны дарга Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна.

**Ц.Сандаг-Очир:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүжин нарын 11 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг ТББХ 2025 оны 6 сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төслийг боловсруулахдаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлж, мэдээлэл хийж буй Ерөнхий сайд Засгийн газрын гишүүд болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтсан нийт нийтийн албан тушаалтан бусад этгээд үнэн бодит мэдээлэл өгөх, асуудлыг үүрэгжүүлэх, хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгасан байна аа.

Хуулийн төсөл батлагдсанаар төсөвт нэмэлт зардал үүсэхгүй бөгөөд хуулийн төсөл Dparliament.mn цахим сайтад байршуулж иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 73.7 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 73.7 хувийн саналаар, Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 73.7 хувийн саналаар үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүдээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа.

Асуулт асууя Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Хуулийн төслийг зарчим агуулгын хувьд ойлгож дэмжиж байна. Гэхдээ би зүгээр бас түрүүн Цогтгэрэл гишүүнд хэлдэг шиг хууль санаачлагчаас бас энэ асуудлыг уян хатан аль аль боломжийг нь хадгалсан байдлаар зохицуулах боломж бий юу л гэж асуух гэж байгаа юм. Гишүүд маань цаг үеийн болоод яг тодорхой чиглэлээр Ерөнхий сайдад урьдчилан асуултаа тавиад тэрийгээ мэдээллээ авах нь чухал. Гэхдээ бас нөгөө талаасаа Засгийн газрын тэргүүн ийм асуудлаар Улсын Их Хуралдаа мэдээлэл өгмөөр байна гээд албан ёсоор хандвал тэрийгээ ингээд хуваарьт оруулаад тэр бололцоог нь үлдээвэл яадаг юм бэ? Ер нь

зүгээр яах вэ нэг юмыг яахдаа шууд ингээд байхгүй болгож өөрчлөөд байгааг жоохон анхаарч үзээч л гэж байгаа юм.

Тэгэхээр энийг бас асуудлуудыг хэлэлцэх эсэхийг дэмжвэл энэ аль аль талаас нь үлдээх тэгэхдээ илүү и. гишүүдийн сонирхсон асуултаар тэр энэ асуудал цагийг бас илүү их үр бүтээмжтэй өнгөрөөх тэр тал дээр зарчмын хувьд ойлгож дэмжиж байгаа шүү. Ер нь зүгээр бас Засгийн газрын тэр тэргүүний хүсэлт гэдэг юм уу албан бичгээр хандаад би мэдээлэл өгмөөр байна гэвэл тэрийг нь харгалзаж үзэх асуудлыг нэг зарчмын хувьд ойлголцоод явчихвал яасан юм бэ гэдэг зүйл байгаа. Энийг ямар байдлаар зохицуулах боломжтой гэж хууль санаачлагчид үзэж байна эсвэл ямар шийдэл оруулж ирсэн бэ? Энэ дээрээ бас мэдээлэл өгөөч гэж хүсэж байна.

**Д.Амарбаясгалан:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн хариулт өгье.

**Х.Тэмүүжин:** Сайнзориг гишүүний асуултад хариулъя.

Өргөн барьсан хуулийн төсөл дээр 112.10 гэж байгаа цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд Улсын Их Хуралд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг өдөрт хийж болно оо.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан гишүүд асуулт асуух үг хэлэхэд энэ зүйлийн 9.10.7-д заасныг баримтална гэсэн зохицуулалт орсон байгаа. Тийм учраас зөвхөн Ерөнхий сайд Улсын Их Хурлаас асуугаад байхгүй цаг үеийн асуудлаар мэдээлэл хийх эрх нь нээлттэй байгаа.

**Д.Амарбаясгалан:** Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна. Батбаярын Жаргалан гишүүн асуулт давхардсан. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя. Тэмүүжин, Мөнхбаатар, Цогтгэрэл нарын өргөн мэдүүлсэн хууль байгаа.

**О.Номинчимэг:** Оройн мэнд хүргэе. Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Яалт ч үгүй бид энэ асуулгын цагийг илүү мэтгэлцээний болгоё гэж байна. Дээр нь энэ холбогдох албан тушаалтан Улсын Их Хуралд мэдээлэл өгөхдөө хариуцлагатай хандах байдал бол бүтэн нэг жилийн хугацаанд сууж байхад маш их анзаарагдсан юм. Нэг хугацаагаа дуусгачихъя гэсэн байртай хариулах, эсвэл мэдэхгүй дур мэдэн худал мэдээлэл өгдөг асуудал ерөнхийдөө нэлээн их ажиглагдсан учраас энийг илүү чанартай Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг илүү үр өгөөжтэй болгох тал дээр дэвшил гарна гэж бодож байна. Яах вэ энэ дээр би зүгээр нарийвчлаад мэдээж хэлэлцэх эсэхийг дэмжээд явсны дараа ажлын хэсэг гарах болов уу гэсэн хүлээлттэй байна.

Түүн дээр энэ Улсын Их Хурлын асуулгын цаг дээр яах вэ дахиад нарийвчилсан юмнуудыг хармаар байгаа юм. Жишээ нь энэ Ерөнхий сайдаас асуулга авахад долоохон хоногийн өмнө байгаад байгаа юм. Тэгээд энэ хугацаа ер нь яаж явах ёстой юм дахиад хармаар байна.

Дээр нь энэ хугацааны хуваарилалт байна л даа. Цөөнхийн бүлгийн хугацаа, олонхын бүлгийн хугацаа, цөөнхийн гишүүдийн хугацааг ингээд хуваарилчихсан нарийн юмнууд байгаа юм. Тэгэхээр энэ дээр илүү юуг барьж ямар судалгаан дээр үндэслэж энэ хугацаа болгон цагийн хуваарилалтыг гаргасан юм бол гэдгийг эхлээд

асуучихъя. Ер нь цаашдаа анхаараад ажлын хэсэг ажиллах хэрэгтэй болов уу л гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Хишигдэмбэрэлийн Тэмүүжин гишүүн асуултад хариулъя.

**Х.Тэмүүжин:** Бусад парламентын жишгээр бол энэ Ерөнхий сайдаас асуух гэж байгаа асуултаа ер нь 3 хоног дотор өгдөг юм байна лээ. Асуулгын 7 хоног болгон 14 хоног болгон ингээд хуваарь гараад тэгээд Ерөнхий сайд асуултад Улсын Их Хурал парламентын гишүүдийн асуултад хариулна гэхээр ямар асуулт асуух гэж байгаа вэ гэдэг асуултаа 3 хоногийн өмнө тавьдаг юм байна лээ. Тэгээд Манай нөхцөлд бол энэ 3 хоног арай жоохон тулгамдах байх гээд Монголын нөхцөлтэй тааруулаад 7 хоног гэдэг энэ агуулгыг оруулсан. Улсын Их Хурлын гишүүд 7 хоног гэдэг дотор үнэхээр улс орны амьдрал өөрөө буцалж байдаг хормоор өдрөөр нөхцөл байдал өөрчлөгдөж байдаг учраас гишүүд нийгэмд болж байгаа үйл явдал яг тэр халуун цэг дээр нь халуун цаг үе дээр нь анхаарал төвлөрсөн байгаа тэр үе дээр нь Засгийн газрыг тэр чиг асуудал руу чиглүүлэх зорилготой асуултуудаа асуух гэдэг бол парламентын гишүүдийн их чухал эрх юм байна лээ.

Энэ хугацаа урт байх тусам сэдэв хуучирдаг. Асуудал нь өөрөө шийдэлгүй болоод тэр өөрөө асуудлаа барьж чадахгүй гээд олон нийтийн итгэл даах тэр чадвар өөрөө суларчихдаг гэдэг тийм шүүмж байдаг юм байна лээ. Ард хуваарилсан хугацаанууд бол олон улсын парламентад хэрэглэж байгаа л жишгүүдээр ер нь явсан. Энэ асуулгын цаг дээр бол нэг чухал зарчим бол парламентын гишүүд олонх цөөнхөөс өөрөөс нь шалтгаалаад Засгийн газар буюу Ерөнхий сайдаас асуулт асуух эрхтэй байдаг юм байна лээ. Гэхдээ энэ эрхээ эдлэхдээ асуулгын тэр асуулт асууж байгаа цагийн 50-аас доошгүй хувийг ерөөсөө албан ёсны цөөнхийн бүлэг олон албан ёсны тэр цөөнхдөө өгөх ёстой гэдэг зарчим үйлчилдэг юм байна лээ.

Дахиад нэг чухал зарчим нь тодорхой. Тэр асуудлуудыг живүүлэхгүйн тулд дэс дараалсан асуулттайгаар нэг сэдэв дээр төвлөрч асуулт хариулт өрнөх бололцоог хангахын тулд энэ дэс дараалсан асуулт буюу нэг сэдэв дээр төвлөрөх гэдэг энэ зарчмыг өөрөө тодорхойлж хуульчилж өгдөг юм байна лээ. Тэгээд энэ агуулгуудыг нэлээн сайн шингээсэн.

Хоёр намын бүлэг дээрээ хоорондоо ярилцаж байгаад энэ анх өргөн барьж байсан өргөн барихаар санал авч байсан төсөл дээрээсээ тодорхой хугацаануудыг шилжүүлсэн байгаа.

**Д.Амарбаясгалан:** Одсүрэнгийн Номинчимэг гишүүн тодруулж асууя.

**О.Номинчимэг:** Тодруулъя. Бүлгүүд яах вэ юу ярилцсан гэж ойлголоо. Зүгээр яах вэ энэ нөгөө гишүүд Ерөнхий сайдад тавих асуулт гэхээр чинь бүхий л асуудал яг нөгөө сэдвийн хүрээнд бол ямар нэгэн хязгаар байхгүй. Сонирхсон бүхий л асуултаа асууна гэсэн үг үү?

Тэгэхээр одоо зүгээр практик дээр яах юм бодъё л доо. 126 гишүүнээс юу гэдэг юм 50 гишүүн нь Ерөнхий сайдаас ийм асуулт асуумаар байна гэдэг нь янз бүрийн асуудал байж болно. Тэгээд энийг 2 цагийн хугацаанд тэгэхээр хэлэлцэнэ

гээд тэгэхээр энэ өөрөө хэр байх юм бол. Эсвэл сэдэвчилж явах юм уу? Өмнө нь практик дээр бишээ өмнөх дэгээр яадаг байсан бэ гэхээр Ерөнхий сайдын асуулгын цаг байсан. Энэ асуулгын цаг дээр болохоор ингээд олон гишүүд эхлээд асуулга тавиад хариултаа аваад тэрийгээ хэнийх нь асуултыг асуух вэ гэдгийг ингээд даргын зөвлөл дээрээ шийддэг. Тэр нь бол бас нэг жоохон учир дутагдалтай байсан юм. Гэхдээ яг энүүгээр ороод ирэх юм бол 40, 50 гишүүн зэрэг асуулт асуучихъя гэхээр тэрийг бүгдээрэнг нь олон төрлийн асуулт байх юм бол 2 цагт хэлэлцэж чадах уу гээд.

**Д.Амарбаясгалан:** Номинчимэг гишүүн энэ дээр би яах вэ нэмэлт тайлбар хийчихье. Ер нь манай гишүүд бас нэлээн олон талаас нь ярилцаад парламентад суудалтай намуудын бүлгийн дарга нар, дээрээс нь суудалтай намын төлөөллүүд хамтраад өргөн барьсан байгаа юм. Өнөөдөр яг ямар нөхцөл үүсчхээд байна гэхээр Ерөнхий сайдын мэдээллийн цаг гэдэг дэгийн цагтай тэр цаг дээр орж ирж асуух асуулт асуух гишүүдийн тоо тодорхой, асуулт нь бараг үндсэндээ тодорхой орж ирдэг. Тэгээд үндсэндээ 1 цаг 30 минут хэрээтэй формалны асуудал болчихоод байгаа учраас энийг нийгэмд хэрэгцээтэй байгаа цаг үеийн шинжтэй асуултуудыг гишүүд асууж чаддаг тийм боломжийг нээж өгье өө гэж тодорхой хугацаатай. Тухайн хугацаанд нийт гишүүний асуусан асуултад бүгдэд нь хариулах алба байхгүй. Хугацаандаа багтсан хариултыг л өгнө гэсэн үг.

Тэгэхээр магадгүй цаг 30 минутын хугацаа байж байлаа гэхэд 7 хоногийн өмнө урьдчилаад 50 гишүүнээс 50 асуулт оччихсон байхад Ерөнхий сайд тэр 50 асуултад цаг 30 минутдаа багтаж хариулж чадвал сайн. Асуулт асууж байгаа байдал нь ч тийм. Хариулж чадахгүй бол мэдээж тэр асуулт дараа дараачийн 7 хоног руугаа шилжээд явдаг хэлбэр рүү орно.

Харин зүгээр энэ дээр бид хэлэлцүүлгийн явц дээр Тэмүүжин гишүүн энэ асуулт асуух хугацаа, хариулт өгч байгаа хугацаа 2-ыг нэлээн уян хатан болгож өгөхгүй бол одоогийн дэгийн хуулиар 3 минут асууна, 4 минут хариулна гээд явчихаар ахиад маш цөөхөн гишүүн асуултад хариултаа авч чаддаг хэлбэр рүү орчихыг үгүйсгэхгүй. Энэ парламентын соёл нь хөгжихсөн улсуудад бол бараг л 15 секундэд асуултаа асуугаад 30 секундэд хариултаа авчаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ өөрөө нийгэм, олон нийт, ард иргэдийн зүгээс тулгамдчихсан байгаа нийгэм эдийн засгийн ач холбогдолтой асуултуудад бодитой хариулт авч байгаа боломж гэдэг талаас нь л хармаар байгаа юм. Тийм ээ.

Тэгээд энэ хуулийн нэмэлт өөрчлөлтийнх нь үзэл баримтлал бол хуучин Ерөнхий сайдын мэдээллийн цаг гэдгийг болиулаад Улсын Их Хурлын асуулгын цаг болгож байгаа юм. Улсын Их Хурлын асуулгын цагийн гол онцлог нь юу юм гэхээр гишүүд, иргэд, олон нийтэд хэрэгцээтэй байгаа асуултыг төлөөлж асууна л гэсэн үг болж байна шүү дээ. Тойргийн асуудлаа асууж болно. Хөрөнгө оруулалтын асуудал асууж болно. Төсвийн асуудлыг асууж болно. Асуулт бол чөлөөтэй.

Тэгэхээр энийг бол хэлэлцүүлгийнхээ явц дээр бас зохицуулалт хийх гээд үзэхгүй юу даа гэсэн нэг ийм бодол бол байгаа гэдгийг хэлье ээ.

Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагддаггүй гишүүдээс үг хэлэх боломжтой байгаа. Одоогийн байдлаар нэр ирүүлсэн гишүүн алга байна.

Ингээд Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Тийм шүү дээ. Уучлаарай.

Би чинь тийм бүх 3 төслийг хэлэлцчихээд хамтад нь санал хураалт явуулъя гэсэн байгаа. Санал хураалтыг түр хойшлуулъя.

Дараагийн асуудалд л орьё.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын 10 гишүүний санаачилсан хуулийн төсөл байгаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ танилцуулна аа.

Индэрт урьж байна.

**Б.Бат-Эрдэнэ:** Сайн байна уу? Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэндээ БОХХАА-н байнгын хорооны дэргэд Агаар, орчныг бууруулах дэд хороо байгуулахтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа өргөн барьсан хуулийн төслийг та бүхэндээ танилцуулъя.

2024 оны 12 дугаар сард агаарын бохирдолтой холбоотой асуудлууд нийгэмд үүссэн. Агаарын бохирдолтой холбоотойгоор салбар дундын асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай байгаа. Өнөөдөр агаарын бохирдолтой холбоотой эрх зүйн орчин дээр хууль, Улсын Их Хурлын тогтоол, тогтоомж захиргааны хэм хэмжээний актууд 225 орчим үйлчилж байна.

Эдгээрийг бид нар нэгтгэн 1 бодлого цэгцэд оруулахгүйгээр агаарын бохирдолтой холбоотой асуудлыг бид нар цаашдаа шийдвэрлэх боломжгүй байна аа. Агаарын бохирдол гэдэг бол орчны бохирдол гэдэг бол Монгол Улсын хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа томоохон гамшгийн хэмжээнд очоод байгаа зүйл ээ.

Тийм учраас бид нар цаашдаа агаар орчны бохирдолтой холбоотой асуудал эрх зүйн орч шныг нэг мөр шийдвэрлэхийн тулд Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар БОХХАА-н байнгын хороонд иргэд Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хороог байгуулах энэхүү хуулийн төслийг өргөн барьж байгаа юм аа.

Өнгөрсөн хугацаанд ард нийтээс ирсэн саналын дагуу ерөнхий сонсголыг зохион байгуулсан. Ерөнхий сонсгол 4 салбар хуралдаантай явагдсан бөгөөд өнгөрсөн хугацаанд бид нар техник технологи, шинжлэх ухаан, инновац, эрх зүйн орчин, мөн хүний нөөц, боловсон хүчинтэй холбоотой олон асуудлууд үүнд үүсэж байгааг ард олон нийтээрээ бүгдээрээ үзэж харж сонссон.

Тийм учраас 220 гаруй эрх зүйн орчин дээр байгаа энэ хууль тогтоомж захиргааны хэм хэмжээний актуудыг бид нар нэг мөр цэгцэд оруулах мөн энэхүү төрийн үйл ажиллагааг нэг чиг баримжаанд аваачиж Үндсэн хуулиар олгогдсон ард нийт иргэд маань эрүүл, аюулгүй орчинд амьдрах ёстой энэ орчныг бүрдүүлэхийн төлөө энэхүү Дэд хороог бид нар байгуулах нь зүйтэй гэж өргөн барьж байгаа юм аа.

Энэхүү асуудлыг шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Ингээд Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэн аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасныг ханган баталгаажуулах зорилгоор Монгол Улсад агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах бодит үр дүнд хүрэх стратегийг хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтийг дэмжих орчныг бүрдүүлэхийн тулд Монгол Улсын Их Хурлын БОХХАА-н байнгын хорооны харьяанд агаарын бохирдол, хорт бодис, байгаль орчны асуудал, байгаль орчныг хамгаалах, байгалийн тэнцлийг хангах, цаг уур, орчны хяналтын асуудал, усны бодлого, нөөц, усны бохирдол, хог хаягдал, дахин боловсруулалт зэрэг асуудлыг дагнан хариуцах үүрэг бүхий Агаар орчны бохирдлыг бууруулах дэд хороог байгуулах хуулийн төслийг боловсруулан өргөн барьж байна аа.

Баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Төслийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Энхбатын Болормаа танилцуулна. Индэрт урьж байна.

**Э.Болормаа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 10 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг ТББХ 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төслийг боловсруулахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж заасныг баталгаажуулах зорилгоор улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах асуудлаарх хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Агаар, орчны бохирдлын дэд хороог Улсын Их Хурлын БОХХАА-н Байнгын хорооны харьяанд байгуулах зохицуулалтыг тусгасан байна аа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 57.9 хувиар дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авна. Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн түр гарсан байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дараагийн асуудалд оръё. Үг хэлэх гишүүдийн нэр. Бадамсүрэн гишүүн асуулт асуух байсан уу? Хоцроод ороод ирсэн нэр хасагдсан байсан. Нэр ирээгүй байна тиймээ. Үг хэлэх гишүүн нэр ирээгүй байна.

Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах олон төсөл явж байгаа учраас өмнөх төслүүд дээр гишүүд үгээ хэлчихсэн учраас нэр татагдаад байна.

Дараагийн асуудалд оръё.

Ариунзаяа нарын 9 гишүүний санаачилсан хуулийн төсөл Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Аюушийн Ариунзаяа индэрт урьж байна.

**А.Ариунзаяа:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын Байнгын хороодын бүтцийг цомхон, зүй зохистой болгох, эрхлэх асуудлыг оновчтой хуваарилан, ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, бодлогын асуудлыг илүү мэргэшсэн байдлаар хэлэлцэн харилцан уялдаатай нэгдмэл шийдэл шийдвэр гаргах боломжийг бүрдүүлж, шийдвэрийн чанарыг сайжруулах зорилгоор зарим Байнгын хороодыг нэгтгэх, Байнгын хороодод харьяалагдах гишүүдийн тоог нэмэгдүүлэх, Дэд хороод байгуулж тодорхой чиглэлээр нарийвчлан мэргэших нөхцөлийг бүрдүүлэх. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батболд, Жаргалан, Лодойсамбуу, Найдалаа, Номтойбаяр, Отгонбаяр, Тэмүүжин нарын хамтаар санаачлан боловсруулж өргөн мэдүүлж байна аа.

Монгол Улсад байнгын ажиллагаатай парламент байгуулагдан ажилласнаас хойших хугацаанд Улсын Их Хурал 7-оос 11 Байнгын хороотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Монгол Улсын Их Хурал 2012-2020 онд 8 Байнгын хороотой байсан бөгөөд, 2020 оноос эхлэн үйлдвэржилтийн бодлого, Ёс зүй дэгийн, Инновац, цахим бодлогын асуудал эрхэлсэн 3 Байнгын хороог нэмж байгуулан Аж үйлдвэржилтийн бодлогын, Аюулгүй байдал, гадаад бодлогын, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй дэгийн, Инновац, цахим бодлогын, Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалтын, Төсвийн, Хууль зүйн, Эдийн засгийн гэсэн 11 Байнгын хороотой ажиллаж байна аа.

Эдгээр 11 Байнгын хороо хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төслийн талаар санал, дүгнэлт гарган, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй.

Байнгын хороодын тоо олон байгаагаас шалтгаалан хэлэлцэх асуудал болон ажлын ачаалал харилцан адилгүй байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт Байнгын хороо 25 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар заасан ч өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэн санал, дүгнэлт гаргах, Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй зарим Байнгын хороо 11-ээс 12 гишүүний л бүрэлдэхүүнтэй байгаа нь хуульд заасан тооны дээд хязгаарын 50 хувьд ч хүрэхгүй байна аа.

Иймд хуулийн төсөлд дараах өөрчлөлтүүдийг тусгасан болно.

Нэгдүгээрт Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, БСШУС-ын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй дэгийн байнгын хороог ТББХ-нд тус тус нэгтгэх, иргэд байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулах.

2.Улсын Их Хуралд Өргөдлийн байнгын хороог байгуулж нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх асуудлыг хуульд тусгаж байгаатай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийн холбогдох журам батлах зохицуулалтыг хасаж уг журмаар зохицуулсан асуудлуудыг хуульд нэмж тусгахаар зохицуулсан болно.

3.Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар ТББХ-нд Ёс зүйн, бүсчилсэн хөгжлийн, Эдийн засгийн байнгын хороонд ЖДҮ-лэлийн хөгжлийн, Инновац цахим бодлогын хөгжлийн, БОХХАА-н байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуйн, НББСШУБХ-нд Шинжлэх ухааны соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулахаар тусгасан.

Монгол Улсын Их Хурлын зохион байгуулалтыг цомхон оновчтой болгож байгаатай холбогдуулан Байнгын хороо 32 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байх, Төрийн байгуулалтын болон Төсвийн байнгын хорооны бүрэлдэхүүнд Засгийн

газрын гишүүний албан үүргийг хавсран гүйцэтгэж байгаа гишүүн 2-оос илүүгүй, бусад Байнгын хорооны бүрэлдэхүүнд 3-аас илүүгүй байх өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг журмаар зохицуулж байгааг хуульд тусган зохицуулахаар холбогдох өөрчлөлтийг мөн тусгасан болно.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд мөн нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Улсын Их Хурал хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэр цомхон оновчтой болно.

Байнгын хороонд харьяалагдах гишүүдийн тоо нэмэгдэж Улсын Их Хурлын шийдвэр гаргалтад эргээр нөлөөлнө.

Хэлэлцэх асуудлын уялдаа холбоо, чанар сайжрах ач холбогдолтой гэж хууль санаачлагчдын зүгээс үзэж байна.

Улсын Их Хуралд суудалтай 5 нам, эвслийн төлөөллөөс бүрдсэн Улсын Их Хурлын 9 гишүүнээс өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Ёс зүй дэгийн, Инновац, цахим бодлогын, Төслүүдийн талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ёс зүй дэгийн байнгын хороон дарга Баярмагнай Баярбаатар танилцуулна аа. Индэрт урьж байна.

**Б.Баярбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа нарын 9 гишүүн 2025 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх асуудлыг ТББХ 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд иргэд байгууллагаас Улсын Их Хуралд ирүүлсэн өргөдлийг судлах, дүн шинжилгээ хийх, холбогдох санал бэлтгэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийн асуудлыг эрхлэх Өргөдлийн байнгын хороог байгуулах, Аж үйлдвэржилтийн бодлогын болон Инновац цахим бодлогын байнгын хороог Эдийн засгийн байнгын хороонд, Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороог, Нийгмийн бодлогын байнгын хороонд, Ёс зүй дэгийн байнгын хороог ТББХ-нд тус тус нэгтгэх. Байнгын хороодыг нэгтгэсэнтэй холбоотойгоор Аж үйлдвэржилтийн бодлогын, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын, Ёс зүй дэгийн, Инновац, цахим бодлогын байнгын хороодын эрхлэх асуудлыг холбогдох Байнгын хороодод шилжүүлэх.

Түүнчлэн Байнгын хороодын эрхлэх асуудлын тодорхой хэсгийг дагнан хариуцуулахаар Төрийн байгуулалтын байнгын хороонд, Ёс бүсчилсэн хөгжлийн эдийн засгийн байнгын хороонд ЖДҮ-лэлийн хөгжлийн, Инновац цахим бодлогын хөгжлийн, БОХХАА-н байнгын хороонд Агаар, орчны бохирдлын, Хүнс, хөдөө аж ахуй, Нийгмийн бодлого, боловсрол, соёл шинжлэх ухааны байнгын хороонд Шинжлэх ухааны соёл, спорт, залуучуудын дэд хороог байгуулах зохицуулалтыг тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Зулпхар, Уянгахишиг нар БСШУС-ын байнгын хороог Нийгмийн бодлогын байнгын хороонд нэгтгэх үндэслэлийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир Улсын Их Хурлын одоогийн бүтэц болон Аж үйлдвэрчдийн бодлогын байнгын хороо, Инновац, цахим бодлогын байнгын хороог бусад байнгын хороонд нэгтгэх талаар асуулт асууж хариулт авсан болно оо.

Улсын Их Хурлын гишүүн Тэмүжин Улсын Их Хурлын тусгай хяналтын дэд хорооны тухай хуулийн төсөл болон Хянан шалгах түр хорооны даргалагчтай холбоотой хуулийн төслүүдийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир Улсын Их Хурал Улсын Их Хурлын Тамгын газрын бүтцийг өөрчлөх нь зохимжгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд Байнгын хороодод гишүүд хуваарилахдаа олонх цөөнхийн төлөөллийг зохистой хуваарилах талаар, Улсын Их Хурлын гишүүн Зулпхар Баярбаатар нар хуулийн төслийг дэмжиж байгаа боловч БСШУС-ын байнгын хороог татан буулгахыг дэмжихгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Уянгахишиг байнгын хороодыг нэгтгэх, гишүүдийн тоог нэмэх нь хурлын ачаалал, ирц, асуудал хэлэлцэх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй талаар, мөн Байнгын хороодын статистик мэдээлэл, ачаалал зэрэг тодорхой судалгааг гаргах талаар Улсын Их Хурлын гишүүн Баярмаа хуулийн төслийг дэмжиж байгаа бөгөөд бүтцийн өөрчлөлтийн гарах хэмнэлт үр ашгийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ хуулийн төслийг хэлэлцүүлгийн явцад тодорхой саналаа тусгаж ажлын хэсэг байгуулан ажиллах талаар саналаа илэрхийлсэн болно.

Байнгын хороо хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулахад Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 63.2 хувийн саналаар, хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 63.2 хувийн саналаар, үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ТББХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууна аа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

**П.Сайнзориг:** Баярлалаа.

Тэгээд энэ чухал хуулийн төсөл орж ирж байна. Яах вэ ер нь зүгээр энэ хууль хэрэвзээ Байнгын хороодын тоог цөөрүүлбэл бид нар бүтээмж болон хурд энэ бодлогуудын Улсын Их Хурлаас хэлэлцэн баталж байгаа бодлогын уялдаанууд хангагдах байх ерөнхийдөө.

Тэгэхээр энийг бол зарчмын хувьд дэмждэг гишүүдийн нэг байгаа. Тэгэхдээ яах вэ би зүгээр хууль санаачлагч гишүүдээс асууя.

Боловсролын байнгын хороог ер нь тусад нь үлдээх тийм бололцоо байгаагүй юу? Хэрэв яг энэ НББСШУБХ гээд байх гэж байгаа бол энийг нэр томъёоны хувьд анхаармаар байна. Нийгмийн бодлого гэдэг чинь ерөнхий аймаар тийм агуулга харагдаад байгаа юм аа. Яг юуг хэлэх гээд байгаа юм? Нийгмийн бодлогод эдийн засгийн асуудал ч байгаа, хууль зүйн асуудал ч байгаа. Маш өргөн хүрээтэй асуудал байхгүй юу. Бид хэд л энийг л л халамж, НДШ, эрүүл мэнд гэж ойлгоод байгаа болохоос биш бас их ерөнхий том агуулга байхгүй юу.

Тэгэхээр би өнөөдөр парламентын төгөлдөршийг Улсын Их Хурлын дарга манлайлаад явж байгаа энэ үе дээр хүн төвтэй асуудлуудыг бид их ярьж байгаа. Хүний хөгжлийн хороо болгох л нэр томъёоны саналыг би оруулж байгаа юм. Хүний хөгжлийн байнгын хороо. Хүний хөгжлийн байнгын хороондоо магадгүй боловсролын асуудлаа ярьж нийгмийн даатгал, эрүүл мэндийн асуудлаа ярьж болох болов уу гэж би зүгээр хувьдаа бодож байгаа юм.

Тэгээд энийг хэрэвзээ хэлэлцэх эсэх шийдэгдээд ажлын хэсэг гарвал анхаарч зүгээр үзээч. Энэ нэр томъёоны хувьд ингэж болох уу? Хууль санаачлагч гишүүдээс хэлээч гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ Байнгын хороонууд дээр яг эрхэлсэн сайдууд нь байхгүй нэг ийм сонин тогтолцоо хууль яваад байгаа юм аа.

Би жишээ нь Хууль зүй, эдийн засгийн байнгын хороонд орохоор манай Эдийн засгийн байнгын хороо чинь Эдийн засгийн сайд байхгүй. ХЗБХ-д Хууль зүйн сайд байхгүй.

Тэгэхээр ер нь гишүүд өөрөө бас орж ирж асуудлаа бид хэд уялдаатай ярьдаг байхгүй бол жишээ нь өнгөрсөн цаг хугацаанд Алтангэрэл сайд бараг энэ Байнгын хорооны хурал дээр суухгүй байгаа байхгүй юу. Яагаад гэхээр гишүүн биш.

Бид хэд уг нь сайдаасаа асуумаар байдаг. Тэгэхээр энэ асуудлуудыг шийдэх бололцоо энэ дээр хөндөж орж ирсэн болов уу нэг хариулж өгөөч гэж хүсэж байгаа юм.

Хоёрдугаарт энэ Өргөдлийн байнгын хороог шинээр байгуулах гэж байгаа юм байна аа. Яах вэ Өргөдлийн байнгын хороог байгуулж байгаа тохиолдолд ер нь цаашдаа иргэдээс, төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах тухай хуулийг нэг уялдуулж шинэчлэх асуудлыг нэг авч үзмээр байна. Энэ хуулийн төсөл дээр нэг заалт дээр би жоохон анхаарч үзээч гэж байгаа юм. Өргөдөл ч гаргах чинь 18 нас хүрсэн хүн байна гээд байгаа юм. Иргэний эрх зүйн чадамжийн тухай асуудал байдаг. 16 наснаас дээшээ бол ерөнхийдөө бүрэн бус чадамжтай. Тэр нь өөрийн асуудлаар бас өргөдөл гомдол асуудлуудаа энд тэнд тавиад явах эрх нь нээлттэй.

Тэгээд бас энэ тодорхой асуудлууд дээр насны хязгаарыг бас 18 гэж байгааг бид нар16 руу авч үзээд үзмээр байна. Энэ чинь иргэдийн оролцоотой залуучууд бас яг зөв зүйл дээр ч юм уу өөрийнхөө асуудал дээр бас ингэж оролцох бололцоог нь бас энэ нас руу татаж аваачиж өгч болно шүү дээ. Бас тодорхой боловсролын асуудлуудаар гэдэг ч юм уу.

Тэгэхээр энийг бас зүгээр тодорхой агуулгын хүрээнд энийг нээж өгөх талаас нь анхаарч үзээч гэдэг зүйлийг л хэлмээр байна. Тэгээд ерөнхийдөө 3 асуулт асуучлаа л гэж ойлгож байгаа. Тэгээд зарчмын хувьд дэмжиж байгаа.

**Д.Амарбаясгалан:** Хууль санаачлагчаас Аюушийн Ариунзаяа гишүүн хариулт өгье.

**А.Ариунзаяа:** Сайнзориг гишүүн зарчмын хувьд дэмжиж байгаад талархаж байна аа. Ер нь бид байнгын парламент байгуулагдсанаас хойш яг энэ үндсэн 7, 8 байнгын хороотой байсан. Тэгээд дийлэнхдээ бол яг энэ нийгмийн бодлого гэдэг нэрээрээ явж ирсэн түүхтэй юм аа. Жишээлбэл 92-оос 96 онд яг хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгмийн халамжийн гэсэн ийм томьёололтой байсан байна. Үүний улмаар 96-аас 2000 онд нийгмийн бодлогын болж, 2000-2004 онд нийгмийн бодлогын хэвээрээ байж.

2004-2006 онд нийгмийн бодлогын гэдгээрээ явж 2006- 2008 онд НББСШУ-ы гэх мэтчилэн одоо яг энэ НББСШУ-ы гэдэг энэ салбараараа сүүлийн ер нь 30 жил явж ирсэн ийм түүхтэй. Яах вэ мэдээж нийгмийн бодлого гэдэг маань өөрөө мэдээж л нөгөө хүний хөгжлийн асуудал мөнөөс мөн учраас яг Хүний хөгжлийн байнгын хороо гэдэг нэршлээр нь явуулах саналыг бол ажлын хэсгийн хүрээнд гаргаад гишүүд маань бүрэн эрхийнхээ хүрээнд санал хураагаад явж болохын хувьд бол болно. Зүгээр үндсэн явж ирсэн зарчмын хувьд бол эдийн засгийн асуудал гэдэг ч юм уу, нийгмийн асуудал гэдэг ч юм уу энэ өөрөө нөгөө шинжлэх ухааныхаа хувьд хэлэгдэж ирсэн ийм уламжлалт томьёолол учраас үүн дээр хууль санаачлагчдын хувьд бол яг энэ нийгмийн бодлого, соёл, шинжлэх ухааны байнгын хороогоороо орж ирсэн байгаа юм аа.

Өргөдлийн байнгын хорооны хувьд яах вэ насанд хүрээгүй хүүхдийн асуудлын өргөдлүүдийг авдаг байх эрх зүйн зохицуулалтыг хэрхэн яаж хийж болох вэ гэдэг асуудал бол яг л нөгөө хүүхдүүдийг бүрэн эрхтэй гэж үзэх юм уу, үгүй юм уу? Хүүхдийг хэн төлөөлөх вэ гэдэг ийм асуудал бол хууль эрх зүйн хувьд бол яригдана. Гагцхүү иргэний хуулиар ч гэсэн тэр насанд хүрсэн гэдэг юм уу, хууль зүйн чадамжтай болох гэдэг юм уу яг энэ агуулгаараа бол энэ насны хязгаар тавигдаж ирж байгаа юм аа. Нийтийн өргөдлийн цахим системээр тоон гарын үсгээр

баталгаажуулж И системээр ордог учраас яахын аргагүй насанд хүрсэн хүн байдаг гэдгээрээ бол бүртгэгддэг И.Монгол систем хүртэл өөрөө 18 нас хүрсэн хүмүүсийг бүртгэдэг шүү дээ. Үүндээ бол гол өөрчлөлт нь байгаа юм.

Гурав дахь асуудал нь болохлоор ер нь Өргөдлийн байнгын хороог сэргээж байгаатай гэлүү эс үгүй бол Боловсролын байнгын хороог яагаад тусад нь байлгаж болохгүй вэ гэдэг ийм асуудлыг дэвшүүлсэн шиг санаж байна тийм үү? Ер нь манай Байнгын хороодын ачааллыг аваад үзэх юм бол 25 гишүүн, хамгийн дээд хязгаар нь 25 гишүүнтэй байх Байнгын хороод байгаа бол яг манай БСШУС-ын байнгын хороо бол 15 гишүүнтэй. Нийгмийн бодлогын байнгын хороо бол 21 гишүүнтэй.

Хуралдсан давтамжийг аваад үзэх юм бол бусад байнгын хороодтойгоо харьцуулахад хурал.

**Д.Амарбаясгалан:** Би Сайнзориг гишүүн 2 зүйл нэмээд хэлээд өгчихье.

Нэгдүгээрт яах вэ боловсролын буюу нэг асуудлаар дагнасан байнгын хороо байгуулагдаад явахаараа Их Хурлын нийт үйл ажиллагааны явцад ачаалал багасаад байгаа юм, дагначихсан. Жишээ нь Аж үйлдвэржилтийн байнгын хороо гээд л асуудал ярина. Жилдээ 1, 2 удаа л хуулийн төсөл хэлэлцсэн тэр Байнгын хороо. Цахим гээд л тэгэхээр жилдээ 1, 2 удаа л хуулийн төсөл хэлэлцээд ингээд нөгөө олон байснаараа Байнгын хороодын үйл ажиллагаа сайн биш, тарамдаад бүтээмж илүү муудаж байгаа. Яг өөртэй чинь санал нэг байна. Тэгэхээр илүү их тийм цомхон байх нь зүйтэй. БСШУС, залуучууд, нийгмийн бодлогын асуудлууд нь өөрөө нэг Байнгын хороонд харьяалагдаад тухайн жилдээ магадгүй уян хатнаар. Аль бодлогыг илүү тавих вэ гэдгийгээ Улсын Их Хурал шийдвэл тодорхой дэд хороодыг нэмээд байгуулаад явдаг хэлбэрээр явах юм бол Улсын Их Хурлын үйл ажиллагаа оновчтой болох юм байна аа.

Жишээлбэл энэ орж ирсэн төсөл дээр шинжлэх ухааны асуудал хариуцсан Дэд хороог анх удаагаа Улсын Их Хуралд байгуулах гэж байна шүү дээ. Шинжлэх ухаанаа голчилж үзье гээд Дэд хороо ингээд ороод ирж байгаа юм. Нэг дэх асуудал нь энэ байгаад байна.

Хоёрт нь энэ Байнгын хороодын үйл ажиллагааг сайжруулах гэдэг шаардлагыг гишүүд их тавьж байгаа. Тэр нь 2 агуулгаар тавьсан.

1 дэх нь болохоороо нөгөө шийдвэр гаргалт сайн байх ёстой буюу Байнгын хорооны шийдвэр гаргалтад олон гишүүн оролцдог байх ёстой нэг дэх асуудал.

Хоёр дахь асуудал нь Улсын Их Хурлаас нэг зүйл дээр анхаарал хандуулж байгаа шүү дээ. Би бүүр энэчээ зориуд хэлье. Саяхан Төрийн аудитын байгууллагын дарга шинээр томилогдож очоод аудитын байгууллагын бүтцийг шалгаад үзсэн чинь аудитын байгууллагад орон даяар нийт 700 хүн ажиллаж байна, ойролцоогоор. Тэгсэн нийт ажилчдын 50 хүрэхгүй хувь нь аудитор, 50 хүрч байгаа хувь нь захиргааны албан хаагчид болчихож байгаа байхгүй юу. Гэтэл тэр аудитын байгууллага уул нь аудит хийх зорилготой байгууллага байгаад байдаг.

Тэгээд шинэ дарга өөрчлөлт хийгээд нийт ажилчдынхаа 75-аас 80 хувийг нь аудитор болгоод 20 хувийг нь захиргааны албан тушаалтан болгож байгаа юм. Яг

энэнтэй адилхан энэ Улсын Их Хурлын Байнгын хороодын тоо цөөрөөд ирэнгүүт Байнгын хороодын ажлын албаны бүрэлдэхүүнийг сайжруулъя гэж байгаа юм.

Одоо бол 2-оос 3 референт ажиллаад ажлын ачааллаа дийлэхгүй байгаад байгаа бол Байнгын хороо болгон тусдаа нэг тийм ажлын алба маягийн дор хаяж 1 5 хүний бүрэлдэхүүнтэй мэргэжилтнүүд нь ажилладаг болгож өгье өө гэж байгаа юм.

Тэгэхээр нөгөө Байнгын хорооны шийдвэр гаргалт чинь 1 дүгээрт олон гишүүн оролцоод шийдвэр гаргаж байна.

Хоёрдугаарт ажлын чанар сайжрах боломжийг бүрдүүлж өгч байгаа гэсэн ийм агуулгаар явж байгаа шүү гэдгийг нэмэлт тайлбар болгож хэлье ээ.

**Д.Амарбаясгалан:** Сайнзориг гишүүн тодруулж асууя.

**П.Сайнзориг:** Хариултууд өгсөнд баярлалаа. Тэгээд олон нийт ч гэсэн энэ мэдээллийг аваасай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт би бас хуулийн төслийг хэлэлцэхэд ажлын хэсэг байгуулбал орж ажиллах санал байна. Тэгээд Хүний хөгжил нийгмийн хамгааллын байнгын хороо гэдэг юм уу сошиал протекшн гэдгийг бид хэд яах вэ агуулгаар нь оруулаад ийм саналуудыг дэмжиж анхаарч үзээрэй гэж хүсэж байна.

Хоёрдугаарт эрхэлсэн сайдууд маань яг тухайн асуудал эрхэлсэн Байнгын хороондоо гишүүнээр байдаг. Энэ асуудлыг энэ удаад хөндөөд нэг ярилцаад үзээч гэж хүсэж байгаа. Жишээ нь Хууль зүйн сайд ХЗБХ-нд баймаар байна аа, Эдийн засгийн сайд Эдийн засгийн байнгын хороонд байдаг баймаар байна. Энийг анхаарч үзээрэй гэж хүсэж байгаа. Тэгээд өргөдөл гомдлын хуулийг ч гэсэн энэний дагуу уялдуулаад шинэчлэх ажлыг ярилцаж хийе гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Яг зөв Сайнзориг гишүүнтэй тийм Ариунзаяа дарга ийм юм. Хуучин нөгөө нэг Байнгын хороонд чинь 12, 13-хан хүн харьяалагдаад шийдвэр гаргалт нь 5-аас 6 Улсын Их Хурлын гишүүн Байнгын хороон дээр дэмжсэн санал өгөхөд асуудал шийдэгддэг байсан юм. Тэр үед салбар хариуцсан сайд Байнгын хороонд байх нь буруу гэж үздэг болсон.

Яагаад гэхээр салбараас оруулж ирсэн асуудал дээрээ цөөхөн гишүүнд лобби хийж шийдвэр гаргалтад нөлөөлөөд байна гэдэг асуудал хөндөгдөж байсан. Одоогийн энэ өөрчлөлтөөр Байнгын хорооны гишүүдийн тоо 29 болчхож байгаа багадаа. Тэгээд энэ тохиолдолд салбар хариуцсан сайд Байнгын хороондоо ороход бол буруудах зүйлгүй болов уу гэдэг. Нэг дэх асуудал.

Хоёр дахь нэг чухал зүйл нь Сайнзориг гишүүн хуучин Өргөдлийн байнгын хороотой байгаад татан буулгаж үзсэн шүү дээ. Их хурал. Яагаад гэхээр Өргөдлийн байнгын хороо иргэдээс ирсэн өргөдлийг мэргэжлийн Байнгын хорооны урдуур орж төрийн байгууллагуудыг дуудаж асуудлыг ярьдаг болоод эхэлчихсэн. Энэ удаа Өргөдлийн байнгын хороог шинээр буцааж байгуулахдаа мэргэжлийн Байнгын хорооноос зөвшөөрсөн тохиолдолд төрийн байгууллагыг дуудаж Өргөдлийн байнгын хороо ажил явуулах боломжтой хэлбэрээр томъёолж оруулж өгч байгаа юм.

Тэгэхээр энэ нөгөө нэг төрийн ажилд ямар нэгэн байдлаар нэмэлт хүндрэл учруулахгүй байх нөхцөлийг хангаж өгч байгаа гэсэн ийм ойлголт байгаа шүү гэдгийг хэлье ээ.

Нэршлийн хувьд уг нь зөв л байна. Бас бид нар цаг үеэ хөгжлөө дагаж нэршлээ сайжруулж байх учиртай. Тэгээд энэ дээр та бүхэн маань Байнгын хороон дээрээ хэлэлцэхдээ асуудлаа яриад явах нь зүйтэй байх гэж бодож байна. Улсын Их Хурлын гишүүн Дүгэрийн Рэгдэл асуулт асууя.

#### **Д.Рэгдэл:** Баярлалаа.

Энэ Байнгын хорооны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах гэж байгаа цаг үеийн асуудалтай нийцүүлж байгааг зөв зүйтэй юм байна гэж харж байгаа. Тэгэхдээ яах вэ энэ хуульд өөрчлөлт оруулж байгаа томъёолол гэж яах юм биш байгаа 1 дүгээрт.

Нэг Байнгын хороог аваачаад нэг том Байнгын хороонд дагаар оруулж байгаа юм шиг томъёолоод байгаа. Энэ чинь 2 Байнгын хороо нийлж байгаа бол хоёулаа татан буугдаад шинээр байгуулж байна гэж харна. Нэг Байнгын хороо нэр нь байгаа ч гэсэн энэ шинэ Байнгын хороо байгуулагдаж байна гэж харж Байнгын хороонуудыг нийлүүлж байна гэж үзэх нь зүйтэй юм шиг санагдаад байгаа юм. Одоо энд нэг л анхаармаар ганц асуудал байгаад байгаа юм. Ер нь энэ шинжлэх ухаан, технологи, инновац гэдэг чинь ингээд нэг гинжин хэлхээний 3 элемент. Тэгээд энэнийг Засгийн газрын бүрэлдэхүүний хууль дээр бид нар өөрчилж чадсангүй. Сая Засгийн газар хуучнаар нь энэ алдаатай шийдвэрийг аваад явчихлаа. Одоо энэнийг энэ Их Хурлынхаа бүтэц бүрэлдэхүүн дээрээ авч хэлэлцэхдээ бид нар нэг нийлүүлчихмээр байгаа юм аа.

Тэгэхээр миний санал юу байна вэ гэвэл их товчхон хэлье. Энэ Шинжлэх ухаан, технологи, инновацын дэд хороог байгуулаад Эдийн засгийн байнгын хороон доор оруулчихмаар байгаа юм. Эдийн засгийн байнгын хороонд.

Тэгэхээр энд бол хуулийн төсөл санаачлагчид маань Байнгын хороод бүхлээр нь нийлүүлэх асуудлыг л авч үзсэн юм шиг харагдаад байна. Гэтэл Байнгын хорооны дотор эрхлэх асуудлаар нь зохицуулах асуудлыг ер нь авч үзсэн үү ярьсан уу. Энд ярьсан бол ямар нэгэн санал онол гарсан юм болов уу үгүй юм болов уу. Нийгмийн бодлого дээр биш Эдийн засгийн байнгын хороон дээр Шинжлэх ухаан технологи инновацын дэд хороо байгуулчих юм бол энэ цогцоороо асуудал явахад их нэмэртэй.

Тэгэхээр энэ асуудлыг та нөхөд маань юу гэж бодож байгаа юм бол?

Хоёрдугаарт энэ Өргөдлийн байнгын хороо ч хуучин байсан л даа. Бид нар сонсоод л өргөдөл хүртэл өгч л байсан. Зүгээр энэ үйл ажиллагааг сайтар зохицуулж өгөхгүй бол сая Амарбаясгалан дарга ч нэлээн тодорхой юм хэлчихлээ. Зүгээр энэ чинь хууль тогтоох засаглалынхаа эсрэг акц өрнүүлдэг талбар болчих боломж байж мэдэхээр байгаа юм. Энд зохион байгуулалттайгаар ийм юм руу оруулчих вий. Энэ тал дээр та бүхэн хууль санаачлагчид бас ямар бодол ямар

концепцоор ажиллаад энэ Байнгын хороог шинээр байгуулах нь зөв юм гэж зөв юм гэж үзээд байгаа юм бэ гэсэн. Ийм 2 асуудал байна.

**Д.Амарбаясгалан:** Би нөгөө Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл дээр энэ асуудал их өргөн хүрээгээр яригдсан учраас би өмнөөс нь зарим хариулт өгөөд байгаа юм.

Өргөдлийн байнгын хороо байгуулагдах болсон үндсэн шалтгаан юу юм бэ гэхээр Улсын Их Хурлын гишүүд дээр тойргийн ард иргэдээс сонгогчдоос маш олон тооны өргөдөл гомдлууд ирж байна. Тэгээд Улсын Их Хурлын гишүүн ямар үүрэг гүйцэтгэж байна гэхээр тухайн өргөдлийг төрийн байгууллагад шилжүүлэх л үүрэг хүлээж байна. Эргээд нөгөө тухайн байгууллага нь хэрхэн яаж шийдвэрлэсэн талаар иргэд сонгогчдод хариу өгөх боломж бүрдэхгүй болчихсон байгаад байгаа учраас Улсын Их Хурлын гишүүн иргэдийнхээ асуудлын шийдвэрлэх биш бүхэмдлийг төрүүлдэг хэлбэр рүү шилжчихсэн байгаа юм.

Тэгэхээр Өргөдлийн байнгын хороо энэ чинь албан ёсоор байгуулагдаад иргэдийн гомдол санал өргөдлийг хүлээж авч албан ёсны хариу өгдөг болох ёстой. Нэг дэх зарчим нь.

Хоёр дахь зүйл нь түрүүн би танд хэлсэнчлэн Өргөдлийн байнгын хороо өмнө нь яг таны хэлсэнчлэн бусад Байнгын хороодын өмнүүр орж ажиллаад төрийн байгууллагуудын ажлыг хийлгэхгүй нөхцөл рүү орж эхэлсэн. Тэр алдааг засахын үүднээс мэргэжлийн Байнгын хорооноос зөвшөөрөл авсны үндсэн дээр Өргөдлийн байнгын хороо тухайн асуудлаар төрийн байгууллагуудыг сонсох үйл ажиллагааг зохион байгуулж болно гэж заалт оруулж өгчхөж байгаа юм.

Гурав дахь нэг маш том зохицуулалт байгаа. Өнөөдөр парламентын үйл ажиллагаа цахимжсан дижитал хэлбэрээр иргэдийн өргөдөл гомдлыг хүлээж авдаг байдал бол нээгдсэн. Занданшатар дарга Улсын Их Хурлын даргаар ажиллаж байхдаа санаачилга гаргаж энэ ди парламентын үйл ажиллагааг бол маш бодитой бий болгож гаргаж ирсэн. Өнөөдөр амжилттай үргэлжилж явж байгаа юм.

Харамсалтай нь ди парламент руу оруулж байгаа иргэдийн өргөдөл гомдлыг дунд нь Тамгын газар шүүдэг ийм процесс явагдаад байгаа юм. Тэгэхээр энэ процессыг хуулиар нь байхгүй болгож өгөөд шууд Өргөдлийн байнгын хороо иргэдийн Ди парламент руу орсон өргөдлийг хүлээж авч цааш нь Улсын Их Хурлын процесс руу оруулах алхмыг эхлүүлдэг хэлбэр лүү оруулж өгч байна. Тэгэхгүй бол Улсын Их Хурлын даргын баталсан журмаар хэн нэгэн этгээд 100 мянган иргэний гарын үсэг зурж байгаа өргөдлийг Их Хурлын процесс руу оруулах уу, оруулахгүй юу гэдэг асуудал шийдэгдээд болохгүй байгаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр нэгэнт л иргэд олон мянгуулаа санал гаргачхаж байгаа бол энэ асуудлыг Өргөдлийн байнгын хороо хууль зүйн хувьд нийцэж байна уу үгүй юу гэдэг дээр нь дүгнэлт гаргаад Улсын Их Хурлаар дамжуулж мэргэжлийн Байнгын хороод руу оруулдаг хэлбэрийг бий болгож өгч байна л гэсэн үг. Ийм 3 дэвшилтэт санаачилгаар энэ Өргөдлийн байнгын хороо бий болж гарч ирж байгаа.

Хариулт бараг болчихсон байх гэж бодож байна.

**Д.Амарбаясгалан:** Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн алга байна. Лхагвасүрэнгийн Соронзонболд гишүүн асуулт асууя.

**Л.Соронзонболд:** Хуулийн төслийн зарим саналтай санал нэг байгаа. Ялангуяа бүтцээ илүү оновчтой болгоё, илүү бүтээмжтэй болгоё гээд. Гэхдээ энд анхаарах зүйл байна гэж бодож байгаа. Боловсролын салбар болохоор ер нь үр дүн нь маш урт хугацааны дараагаар үр шимээ өгдөг ийм онцлогтой тэргүүлэх салбар байгаад байдаг. Тэгэхээр заавал БСШУ-ны байнгын хороо нь байнга хууль баталдаг байхдаа биш, харин батлагдсан байгаа хууль, түүний хэрэгжилт хяналтдаа илүү анхаардаг байж болно гэж бодож байгаа юм аа.

Ялангуяа манай улсын хувьд энэ уул уурхайн салбартай эдийн засагтай хамааралтай улс байгаад байгаа. Цаашдаа бид нар энэ уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлохгүй байж болох ч тийм үе байж болно шүү дээ. Тэр үед бидэнд боловсролтой тийм хүний нөөц л хамгийн чухал болно.

Тийм учраас ер нь Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороо гол нь байдгаараа байрласан нь зүгээр юм шиг надад санагдаад байгаа юм. Энэ дээр Ариунзаяа гишүүнээс асууя. 2-т болохоор энэ бид нар чинь уул уурхайгаас бусад салбар эдийн засгаа солонгоруулъя гээд ЖДҮ-лэл эрхлэгчдийг дэмжье гээд. Тэгээд яг энүүгээрээ т чиглэсэн ийм Аж үйлдвэрийн байнгын хороо байсан. Тэгээд 23 гишүүнтэй. Тэгэнгүүт энийгээ бас Эдийн засгийн байнгын хороон дээр авчраад дэд хороо болгоё гээд байдаг. Гол нь энэ асуудал дээр илүү фокуслаж ажилладаг ийм Байнгын хороо нь байсан нь зүгээр юм биш үү гэсэн нэг ийм санал байгаа. Тэгээд яагаад заавал Аж үйлдвэрийн байнгын хороог Эдийн засгийн байнгын хороо нэгтгэх гээд байгаа юм бэ гээд.

Байнгын хороо болон дэд хороо 2-ын хооронд яг ямар ялгаа байгаа юм бэ гэдэг нэг асуудал байгаад байгаа. Байнгын хороо нь болохоор төсөвтэй, дэд хороо нь болохоор төсөвгүй.

Тэгэхээр яг ингээд Эдийн засгийн байнгын хорооны доор гэхээр 3, 4 дэд хороотой болох юм байна л даа. Тэгээд дэд хороо болгон нь өөрсдөө тусдаа шийдвэрээ гаргаад явчихна. Байнгын хороондоо яг дэд хорооны шийдвэрээ заавал танилцуулах ийм шаардлага байхгүй байх шиг байгаа юм. Тэгэхээр энэ дээр ер нь Байнгын хороо, Дэд хороо 2-ын хооронд яг ямар ялгаа зайг гаргаж өгөх юм бэ гэдэг дээр нэг асуулт асуучихъя.

**Д.Амарбаясгалан:** Ариунзаяа гишүүн асуултад хариулъя.

**А.Ариунзаяа:** Соронзонболд гишүүний асуултад хариулъя аа.

Ер нь бол асуудлын чухал чухал бус гэдэг юм уу манай Байнгын хороо байх ёстой. Ёс зүй дэгийн байнгын хороо жишээлбэл гишүүдийн Ёс зүй байдаг юм уу? Ёс зүй бол их чухал шүү дээ. Эсвэл боловсрол их чухал шүү дээ. Инновац их чухал шүү дээ. Аж үйлдвэрийн байнгын хороо их чухал шүү дээ гэдэг юм уу ийм асуудлуудыг бол яривал бусад салбарууд ч гэсэн жишээлбэл хүүхэд хамгааллын гэдэг юм уу гэр бүлийн бодлогын гэдэг юм уу ядуурлын бууруулах гэдэг юм уу бүхий л асуудлуудаар бид нар ярьж болохуйц ийм нөхцөл байдал харагдана тиймээ?

Тэгэхээр ер нь бол төр өөрөө яг энэ шийдвэр гаргалт маань өөрөө зохистой оновчтой ямар нэгэн байдлаар энэ эдийн засгийн болон бусад энэ салбаруудын асуудлын давхцалгүйгээр цомхон байх нь зүйтэй юм байна ингэж байж энэ шийдвэрүүд нь бол илүү оновчтой болно гэж.

Дэд хорооны асуудал нь өөрөө юу юм бэ гэхээр тухайн асуудлаар гүнзгийрүүлсэн судалгаа хийх, холбогдох мэдээллийг авах, зохих албан тушаалтан, иргэн байгууллагаас тайлбар авах ажлын хэсэг байгуулах гэх мэтчилэн Байнгын хороондоо оруулахаас өмнөх энэ ажлыг бол тухайлж мэргэшин ажиллах ийм боломжтой. Тэгээд сая та бол маш зөв хэллээ.

Дэд хороо бол ямар нэгэн төсөв ажлын алба гэдэг юм уу төсвийн асуудал бол огт үүсэхгүй. Ийм учраас төсвийн хэмнэлтэд ч гэсэн энэ их зэрэг нөлөө үзүүлэх юм гэдэг ийм саналыг бол гаргаж хууль санаачлагчид бол ажилласан.

Тэгэхээр ер нь бол асуудлуудыг тодорхой хэсгийг дагнан хариуцдаг гэж ойлгож болно гэсэн үг.

Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

**М.Бадамсүрэн:** Би Соронзонболд гишүүнтэй санал ойролцоо байна. Зарим зүйлүүдийг нь дэмжиж байгаа. Зарим зүйлүүдийг бас дэмжихгүй байгаа гэдгээ илэрхийлье ээ.

Тэгээд 1 дүгээрт энэ ТББХ-н дээр 2 ч Улсын Их Хурлын гишүүн энэ энэ Байнгын хороог ийм ийм хүнд зориулж байгуулсан гэдэг асуудал яригдсан. Тэгээд би яг энэ хэдэн онд хэнд зориулж хэн гэдэг хүнд зориулж энэ Байнгын хороог байгуулсан юм бэ гэдгийг хууль санаачлагчдаас 1 дүгээрт асууя.

Хоёрдугаарт нь энэ татан буулгахаар болж байгаа Байнгын хороодын гишүүдээсээ энэ дээр ер нь санал авсан уу? Тэд ер нь ямар саналаа илэрхийлсэн бэ?

Гуравдугаарт нь 11-ээс 12 гишүүнтэй Байнгын хороо байна гэж энэ танилцуулга дээр дурдагдаж байна аа. Энэ нь яг аль аль Байнгын хороо вэ? Мөн энэ Боловсрол шинжлэх ухааны салбар улс орны тэргүүлэх салбар. Тэгэхээр энэ салбар нийгэмд энийг татан буулгаж нийгмийн бодлогод шилжүүлэх нь ер нь юу гэж ойлгогдох вэ? Ер нь Байнгын хороог яг ажиллуулъя гэвэл хийе гэвэл ажил зөндөө байгаа. Тэгэхээр энэ нь ер нь яг ухралт болохгүй юу? Ер нь боловсрол ядуурлаас гаргах цорын ганц гэж хэлж болох хамгийн чухал ийм салбар байгаа. Шинжлэх ухаан бол энэ хөгжлийн хамгийн том түүчээ.

Тэгэхээр энэ мөн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо ингээд үйлдвэржсэн орон болох зорилт тавьсан. Тэгээд энэ дээр 14 мега төслийг хариуцаж байгаа аж үйлдвэрийн парк гээд Аж үйлдвэрийн байнгын хорооны гишүүд маш их идэвхтэй ингээд ажиллаж байгаа. Тэгээд энэ ажлууд, ажлын байр гаргах, нэмүү өртөг шингээх, экспортод чиглэсэн, үйлдвэрлэл хөгжүүлэх гээд энэ бодлогууд ер нь энэ Байнгын хороо татан буугдсанаар ямар үр нөлөө үзүүлэх вэ. Мөн хөгжлийн тэргүүлэх чиглэл бол цахим инновац мөн.

Ёс зүй бол төрийн албан тушаалтны хамгийн чухал зүйл ээ. Ер нь нийт хүн ардын иргэдийн ч гэсэн ёс зүй асуудал хамгийн чухал. Энэ дээр яагаад ингэж дэлгэрүүлж энийг тайлбарлаж өгөөч ээ? Зөвхөн хуулийн төсөл хэлэлцэхээс гадна хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх нь Байнгын хороодын хамгийн чухал нэ зүйл байдаг.

Тэгэхээр өмнө батлагдан гарсан олон хууль тогтоол байгаа. Тэгээд энийг яаж хэрэгжүүлж байна гэдэг бол бидний хувьд бодох их чухал асуудал байгаа. Одоо ингээд олон Байнгын хороон дээр өмнө гарсан хууль, тогтоолын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх энэ ажлуудыг маш ихээр хэрэгжүүлж байгаа шүү дээ. Ер нь бараг нийт ажлынх нь дийлэнх нь ер нь энэ бараг хяналт хэрэгжүүлэх ажил байгаа гэж ойлгож байгаа. Хяналт шалгалтын хууль ч гэсэн үүнд чиглэгдсэн байдаг юм байна лээ.

Тэгэхээр энэ бол Их Хурлын гүйцэтгэх ажил үүрэг дээр их том хувь нэмэр оруулж хяналт шалгалт хийгдэж байгаа байх. Зүгээр энэ хаврын чуулган эхний жилийн чуулган учраас энэ дээр ихэнх ажлын хэсгүүд дүгнэлтээ хараахан гаргаж бас амжаагүй байсан ийм дүр байгаа байх гэж бодож байна.

Мөн Дэгийн хуульд энэ хууль Их Хурлын тухай хууль болон Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай өргөн барьж байгаатай холбогдуулаад энэ даваа гарагт зөвхөн ажлын хэсгүүд хуралдаад тэгээд энэ Засгийн газрын гишүүн сайд нарт бүгд давхар гүйцэтгэж байгаа. Их Хурлын гишүүн Засгийн газрын гишүүний үүргийг. Тэгэхээр ингээд өдөр болгон Төрийн ордонд Их хурлын гишүүдийг дуудаад байх биш даваа гарагт нь ажиллах боломж олгоод ингээд даваа гарагт нь ажлын хэсгүүд хуралдаад намын бүлгүүд 2 дахь өдрийн өглөө хуралддаг байж болох уу? Ийм асуултуудад нь хариулт авъя аа.

**Д.Амарбаясгалан:** Ариунзаяа гишүүн хариулт өгье.

**А.Ариунзаяа:** Яг байгаа одоо Байнгын хороодын хувьд 11 байнгын хороотой. Эдгээр 11 Байнгын хороотойгоос хуулийнхаа дээд хязгаар буюу 25-аас илүүгүй гишүүн байх Байнгын хорооны тоогоо гүйцээсэн 4 Байнгын хороо байна. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, ТББХ, Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо. Хамгийн бага буюу 11 хүнтэй Инновац, цахим бодлогын байнгын хороо, Ёс зүй, дэгийн байнгын хороо бол 12 хүнтэй. БСШУС-ын байнгын хороо бол 15 хүнтэй хамгийн бага нь байна. Түүний дараагийн бага нь бол Нийгмийн бодлогын байнгын хороо байна гэсэн үг.

Эдгээр Байнгын хороод бол сая миний хэлсэнчлэн Байнгын хороод 2020 онд шинээр буюу нэмэгдсэн Байнгын хороодын тоонд орж байгаа Байнгын хороод байна аа.

Чухамдаа 2020 онд нэмэгдүүлсэн эдгээр Байнгын хороодыг бол хэнд зориулж байгуулсан юм бэ гэдгийг миний хувьд шууд хэлэхэд түүхэн гэрч тухайн шийдвэрийг гаргахад яг хажууд нь байгаагүй сонсоогүй учраас түүнийг бол би хэлж мэдэхгүй байна. Гагцхүү Пүрэвдорж Улсын Их Хурлын дэд даргын хувьд бол тухайн ТББХ-н дээр болон дараад нь хэвлэлийнхэнд мэдээлэл өгсөн байсан. Ингэхдээ бол Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороог бол Чойжилсүрэн гишүүнтэй холбож тайлбарлаж ярина лээ. Инновац, цахим бодлогын байнгын хороог бол Учрал сайдтай холбож ярина лээ. Ёс зүй, дэгийн байнгын хороог буюу Ёс зүй сахилга

батынхыг бол Бат-Эрдэнэ гишүүнтэй холбож ярина лээ. Нийгмийн бодлогын байнгын хороо байсныг 2 салгасныг Анужин, Оюунчимэг гишүүд нартай холбож ярина лээ. Гэхдээ би бол үүнийг гэрчилж мэдэхгүй учраас зөв эсэхийг бол хэлж мэдэхгүй байна аа.

Гэхдээ ямар ч байсан яг одоо тухайн байгуулсан Байнгын хороодын ажлын ачааллыг бусад ердийн байсан байнгын ажиллагаатай парламент эхэлснээс хойш үйл ажиллагаа явуулж байгаа одоо энэ Байнгын хороодтой харьцуулж үзэх юм бол хуралдаж байгаа хурлын тоо, шийдвэрлэж байгаа асуудлуудын тоо яалт ч үгүй 2-оос 3 дахин бага байна аа.

Ийм учраас эдгээр асуудлуудыг ямар учир шалтгааны улмаас байгуулагдсан бэ? Хамаагүй энэ удаагийн парламент илүү парламентын төгөлдөршлийг илүү авч үзэж байгаа юм бол уу, зорилго болгосон юм бол уу. Үүн дээрээ Улсын Их Хурал өөрөө энэ манлайллаа үзүүлж илүү цомхон илүү оновчтой байх хэрэгцээтэй юм байна гэдгийг бол харуулж байгаа.

Аж үйлдвэржилтийн байнгын хорооны гишүүний хувьд бол мэдээж та энэ Аж үйлдвэржилтийн байнгын хороо маш хэрэгтэй юм гишүүд хүсвэл өөрсдөө идэвхтэй байж болдог юм гэдгийг хэлж байна. Үнэн зөв. Манай энэ Ганбаатар дарга бол маш идэвхтэй ажлын хэсгүүдийг байгуулж Байнгын хороонд харьяалагдаж байгаа гишүүд маш идэвхтэй ажиллаж байгаа үнэн. Гагцхүү энэ бол яг өөрийн санаачилга дээр суурилагдаж явагдаж байгаа учраас үүнийг бол.

**Б.Пүрэвдорж:** Гишүүдийнхээ энэ оройн амгаланг айлтгая. Хэн үг хэлэх билээ. Ариунзаяа гишүүн нэмж хариулъя.

**А.Ариунзаяа:** Аж үйлдвэржилтийн байнгын хороонд даргын дэргэдэх зөвлөлөөс яг тухайлсан асуудлууд бас хуваарилагдах вэ гэдгийг бол Ганбаатар дарга ч хэлж байсан. Даргын дэргэдэх зөвлөл дээр ч яригдаж байсан. Тэгэхээр энэ маань юутай холбоотой юм бэ гэхлээр аж үйлдвэржилтийн эдгээр асуудлууд таны түрүүний хэлсэн мега төслүүдтэй холбоотой гэж. Тэгэхээр эдгээр мега төслүүдийн хуулиудыг бид нар хамтдаа баталчихсан эрэмбээ бол тавьчихсан. Одоо төсөв зэрэг энэ хэрэгжүүлэлтийн явц дээр нь бол Дэд хорооны түвшинд анхаараад ажиллаад явах бүрэн боломжтой гэж үзэж байгаа учраас эдгээр энэ саналыг бол оруулж ирж байгаа юм аа.

Тэгээд энэ даргын дэргэдэх зөвлөл дээр буюу Байнгын хороодын гишүүд болон Улсын Их Хурлын Тамгын газар дээр хамтдаа нэлээд хугацаанд ажиллаж ярилцсан учраас үүнийг бол санал авсан гэж үзэж болно оо.

Баярлалаа.

Бадамсүрэн гишүүн нэмж тодруулъя.

**М.Бадамсүрэн:** Ингээд би бол манай Байнгын хороо татан буугдах юм байна л даа. Тэгээд би энэ бараг одоо цомхотголд орно гэдэг шиг тэгээд татан буугдах юм байна. Тэгээд би нөгөө өөрөө мэдээгүй болохоор ингээд асуугаад байгаа байхгүй юу. Энэ нөгөө Байнгын хороонд харьяалагдаж байгаа гишүүдээсээ ядаж санал авчхаж болоогүй юм уу. Танай Байнгын хороог ер нь татан буулгах нь зөв үү буруу

юу гээд. Энэ бол жирийн байх ёстой л нэг зүйл л дээ. Тэгээд энийг хэрэгжүүлээгүй байна гэдгийг хэлье.

Хоёр дахь нь бол боловсрол шинжлэх ухаан болон Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороог байх нь зүйтэй гэж үзэж байна. Харин зүгээр Цахим, инновац, Ёс зүй дэгийн байнгын хороог бусад Байнгын хороонд нэгтгэх асуудлыг дэмжиж байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд маань энэ дээр олон талаас нь авч үзэж саналаа өгөх байх гэж бодож байна. Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Тэгэх дээр нэмж тайлбарлахад танай Байнгын хорооны дарга Сайнхүүгийн Ганбаатар өөрөө даргын зөвлөлийн хурал дээр манай Байнгын хороог татаж буулгаж байгааг дэмжиж байна гэж хэлсэн шүү гэдгээ хэлье. Мөнхтуяа гишүүн байхгүй байна. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууя. Асуултаас татгалзаж байгаа юм байна.

Батын Батбаатар гишүүн асуултаа татчих уу? Татчихъя татчихъя. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Хуулийн төслүүдийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилсан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ ээ.

Нэр өгсөн дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрөл өгье. Үг хэлэх гишүүн ирүүлээгүй юм байна. Батжаргал гишүүн үг хэлнэ.

**Ж.Батжаргал:** Хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хэлэлцэхийг дэмжиж байна. Хэлэлцүүлгийн үед манай хууль санаачлагчид анхаарна биз гэж би ингэж бодож байна. БОХХАА-н байнгын хороонд ХАА-н дэд хороо байхаар орж ирж байгаа юм уу? Уг үндсэн Байнгын хорооны маань чиг үүрэг ХАА-н асуудал байгаад байдаг.

Тийм учраас энүүнийг харах ёстой байх. Тэр агаар орчны бохирдлын гэдэг юм уу энэ дэд хороо байх ёстой дэд хороо мөн.

Дараагийн нэг асуудал Эдийн засгийн байнгын хороон дээр ЖДҮ-лэлийн дэд хороо байхаар асуудал яригдаж байгаа юм байна лээ. Хүнд хөнгөн үйлдвэрээ орхигдуулаад яах вэ дээ Аж үйлдвэржилтийн дэд хороо гэдгээр нь явсан нь дээр байх. Үйлдвэржилтийн бодлогоо нэгдсэн нэг бодлогоор барьж явах нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай гэж.

Дагаж орж ирж байгаа Дэгийн хууль дээр нэг санаа байгаа юм. Энэ асуулт үгэн дээр тухайн хэлэлцэж байгаа асуудлын мэргэжлийн Байнгын хороог төлөөлж 2-оос 3 хүн үг хэлдэг баймаар байгаа юм. Энэ Байнгын хороонууд дээр яригдсан гол асуудлуудыг нийт гишүүддээ таниулах ойлголтыг нэг болгох үүднээс энэ мэргэжлийн Байнгын хороодын төлөөлөл дутаад зарим асуудал унаад байгаа.

Хууль хоорондын нийцлүүд хангагдаж өгөхгүй байгаад байгаа юмнууд энэ тэр гараад байгаа. Тийм учраас энүүнийг дэгийн хуулийн боловсруулалт дээрээ анхаарах нь зөв болов уу гэсэн нэг ийм бодол байна аа.

Түрүүн Тэмүүжин гишүүний яриад байгаа тэр Их Хурлын асуулгын цаг гэдэг дээр нийт цагийнх нь гуравны нэг нь намынхаа бүлгүүд дээр асуудал нь нэгтгэгдэж

яригдвал зөв үү. Тэгээд гуравны хоёр дээрээ гишүүд нь асуултаа асууж, хариултаа авдаг хэлбэрээрээ явбал зөв болов уу. Тэгэх юм бол энэ асуудлын чинь бас нэг тийм бодлогын зангилгаа зөв болох болов уу гэсэн ийм бодол байна. Энүүнийг манай хууль санаачлагчид Байнгын хороод хэлэлцүүлгийнхээ явцад анхаараарай гэдгийг хэлмээр байна.

Баярлалаа.

**Б.Пүрэвдорж:** Гишүүд үг хэлж дууслаа.

Санал хураалтыг түр хойшлуулъя.

Одоо Засгийн газрын бүрэлдэхүүний асуудал болчихсон уу тэ. Гишүүдийн ирцийг нэмэгдүүлье. Өндөр хувиар энэ санал хураалт явагдах ёстой.

**Д.Амарбаясгалан:** Улсын Их Хурлын гишүүд санал хураалтад бэлдье.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх талаар санал хураалт явуулахаар байгаа.

Санал хураалтдаа бэлтгэцгээе гишүүд. Ирц бүртгэл болсон байна.

Санал хураалт

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

3 санал хураалт явуулах хуулийн төсөл гурвуулаа Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд байгаа.

Энэ бол Ариунзаяа нарын санаачилсан хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

54 гишүүн буюу 54 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

58 гишүүн буюу 58 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

Өмнөх асуудлын санал хураалт руу оръё. 5 дугаар асуудал

Улсын Их Хурлын гишүүн Бат-Өлзийн Бат-Эрдэнэ нарын өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байгаа.

Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

62 гишүүн дэмжиж, 62 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

**Дөрөв дэх асуудал руу оръё. Улсын Их Хурлын гишүүн Тэмүүжин, Улсын Их Хурлын гишүүн Лхагвын Мөнхбаатар, Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын гишүүдийн санаачилсан хуулийн төсөл дээр санал хураалт явуулна.**

Санал хураалт.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

67 гишүүн буюу 67 хувиар санал дэмжигдлээ.

Хамт өргөн мэдүүлсэн

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя аа.

Санал хураалт.

64 гишүүн буюу 64 хувиар санал дэмжигдлээ.

3.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулья аа.

Санал хураалт.

66 гишүүн буюу 66 хувиар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг гишүүдийн олонх дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр ТББХ-нд шилжүүллээ.

ТББХ-ны дарга болон өнөөдрийн Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт болон өөрчлөлт оруулах санал гаргасан ажлын энэ төсөл санаачлагч нар хамтдаа уулзаад Тэмүүжин гишүүн нэг дэх өдөртэй уулзаад энэ 6 төслийг нэгтгэж ТББХ-гоор хэлэлцүүлж ирэх 7 хоногт Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж ирэхийг үүрэг болгож байна.

Ингээд 2025 оны 6 сарын 25-ны өдрийн нэгдсэн хур хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

19.27 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА*